



**ДЭЛХИЙН
ДОШИНГИЙН ЭСРЭГ
ДҮРЭМ**



2015

- Энэхүү бичвэр нь ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ДҮРМИЙН 2015 оны хувилбарын англи хэлнээс хөрвүүлсэн Монгол орчуулга болно. Англи эх болон Монгол орчуулгын хооронд зөрүү гарвал англи хэлний хувилбарыг баримтлана.
- Орчуулсан: Н. Цогтсайхан /төслийн зөвлөх/

Дэлхийн Допингийн Эсрэг Дүрэм

Дэлхийн допингийн эсрэг дүрэм нь нь анх 2003 онд батлагдаж 2004 оноос үйлчилж эхэлсэн. Өөрлөлт оруулсан хувилбар нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Дэлхийн допингийн эсрэг дүрмийн энэхүү засаж, сайжруулсан энэхүү хувилбарыг Дэлхийн Допингийн Эсрэг агентлагын үүсгэн байгуулагчдын зөвлөл 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Йоханнесбург хотноо баталсан. Шинэчилсэн Дэлхийн Допингийн эсрэг дүрэм нь 2015 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хэвлэн нийтэлсэн:

Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг
Stock Exchange Tower
800 Place Victoria (Suit 1700)
PO Box 120
Montreal, Quebec,
Canada H4Z 1B7

Вэб хуудас: www.wada-ama.org

Утас: +1 514 904 9232

Факс: +1 514 904 8650

И мэйл: info@wada-ama.org

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА, ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР, ДҮРМИЙН БҮТЭЦ, ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	8
ДҮРЭМ	8
ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР	8
ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД	9
ШИЛДЭГ АРГА БАРИЛЫН ЗАГВАР	9
ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ДҮРМИЙН ТУЛГУУР ҮНДЭСЛЭЛ	10
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ДОПИНГИЙН ХЯНАЛТ	11
ТАНИЛЦУУЛГА	11
1 ДҮГЭЭР БҮЛЭГ: ДОПИНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	12
2 ДУГААР БҮЛЭГ: ДОПИНГИЙН ЭСРЭГ ЖУРМЫН ЗӨРЧИЛ	12
2.1 Тамирчны дээжнээс хориглосон бодис, эсвэл түүний хувирал буюу шинж тэмдэг илэрсэн.....	13
2.2 Хориглосон бодис, эсвэл хориглосон арга хэрэглэх буюу хэрэглэхийг завдах.....	14
2.3 Дээж өгөхөөс зайлсхийх, татгалзах, дээжээ өгөхгүй байх.....	14
2.4 Байршлын мэдээллийн алдаа.....	15
2.5 Допингийн хяналтын аль нэг хэсэгт хөндлөнгөөс оролцох буюу хөндлөнгөөс оролцохоор завдах.....	15
2.6 Хориглосон бодис болон аргыг эзэмших:.....	15
2.7 Аливаа хориглосон бодис, эсвэл аргыг худалдах худалдахыг завдах.....	16
2.8 Хориглосон бодис, хориглосон аргыг тэмцээний үед тамирчныг хэрэглэхийг тушаах, тэмцээний бус үед хэрэглэхийг хориглосон бодис, хориглосон аргыг тэмцээний бус үед хэрэглэхийг тамирчинд зааварлах, зааварлахыг завдах.....	16
2.9 Хамтран үйлдэх.....	16
2.10 Хориглосон хамтын ажиллагаа.....	16
3 ДУГААР БҮЛЭГ: ДОПИНГ ХЭРЭГЛЭСЭН ЭСЭХИЙГ НОТЛОХ	17
3.1 Нотлох үүрэг, түүний стандарт.....	17
3.2 Нөхцөл байдлыг тогтоох болон таамаглах арга.....	17
4 ДҮГЭЭР БҮЛЭГ: ХОРИГЛОСОН ЖАГСААЛТ	18
4.1 Хориглосон жагсаалтыг хянах болон хэвлэн нийтлэх.....	18
4.2 Хориглосон жагсаалтанд тусгагдсан Хориглосон бодис болон Хориглосон арга.....	19
4.3 Хориглосон жагсаалтанд тусгагдсан бодис болон арга барилыг тогтоох шалгуур.....	20
4.4 Эмчилгээний зорилгоор чөлөөлөх.....	21

4.5 Хяналтын хөтөлбөр.....	23
5 ДУГААР БҮЛЭГ: ШИНЖИЛГЭЭ БА МӨРДӨН ШАЛГАЛТ	24
5.1 Шинжилгээ, мөрдөн шалгалтын зорилго	24
5.1.2 Мөрдөн шалгалт нь:.....	24
5.2 Шинжилгээний хүрээ	24
5.3 Тэмцээний шинжилгээ	25
5.4 Шинжилгээ хийх төлөвлөгөө.....	26
5.5 Шаардлага.....	26
5.6 Тамирчны байршлын тухай мэдээлэл.....	26
5.7 Зодог тайлсан тамирчин спортод эргэн ирэх	27
5.8 Мөрдөн шалгалт ба мэдээлэл цуглуулах	27
6 ДУГААР БҮЛЭГ: ДЭЭЖИЙГ ШИНЖЛЭХ.....	28
6.1 Магадлан итгэмжлэгдсэн болон батлагдсан лабораторийг ашиглах.....	28
6.2 Дээж шинжлэх зорилго	28
6.3 Дээжийг судлах	28
6.4 Дээжийг шинжлэх, түүнийг илтгэж тайлагнах стандарт	29
6.5 Дээжийг цаашид шинжлэх.....	29
7 ДУГААР БҮЛЭГ: ҮР ДҮНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ	30
7.1 Үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах хариуцлага	30
7.2 Сөрөг аналитик илэрцэд хийх хяналт	31
7.3 Хяналтын дараа хийх мэдэгдэл	31
7.4 Гаж илэрцэд хийх хяналт	32
7.5 Паспортын гаж илэрц болон паспортын илэрцийн хяналт.....	33
7.6 Байршлын тухай мэдээллийн алдааны хяналт.....	33
7.7. Допингийн эсрэг дүрмийн 7.1-7.6 –т хамаарахгүй бусад зөрчлийг хянах	33
7.8 Өмнөх допингийн эсрэг дүрмийн зөрчлийн тодорхойлолт	33
7.9 Түр түдгэлзүүлэлтэд хэрэглэгдэх зарчмууд.....	34
7.10 Үр дүнгийн удирдлагын шийдвэрийг мэдэгдэх.....	35
7.11 Спортоос зодог тайлах	35
8 ДУГААР БҮЛЭГ: ХЭРГИЙГ ШУДАРГААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ БОЛОН ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ ЭРХ.....	36
8.1 Шударгаар хянан хэлэлцэх	36
8.2 Хянан шийдвэрлэх үйл ажиллагаа	36
8.3 Хянан шийдвэрлэх ажиллагааг цуцлах.....	36
8.4 Шийдвэрийг мэдээлэх	36

8.5 Спортын арбитрын үүхээс өмнө нэг удаа хянан хэлэлцэх	37
9 ДҮГЭЭР БҮЛЭГ: ХУВИЙН ҮР ДҮНГ ТООЦОХГҮЙ БАЙХ	37
10 ДУГААР БҮЛЭГ: ХУВИЙН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ	37
10.1 Допингийн эсрэг журмыг зөрчих үед гарсан үр дүнг тооцохгүй байх.....	37
10.2 Хориглосон бодис болон Хориглосон арга илрэх, хэрэглэх, хэрэглэхийг оролдох, эзэмшсэний төлөө эрхийг нь хасах	38
10.3 Допингийн эсрэг дүрмийн бусад зөрчилд ногдуулах шийтгэл	39
10.4 Буруугүй, эсвэл хайнга хандаснаас шалтгаалсан эрх хассан шийтгэлийн хугацааг цуцлах.....	40
10.5 Буруугүй, эсвэл хайнга хандаснаас шалтгаалсан эрх хассан шийтгэлийн хугацааг бууруулах.....	40
10.6 Эрх хасах шийтгэлийн хугацааг цуцлах, багасгах, түтгэлзүүлэх эсвэл алдаанаас өөр шалтгаанаас үүсэх бусад үр дагавар	41
10.7 Хэд хэдэн зөрчил.....	44
10.8 Шинжилгээнд дээж өгсний дараа өмнөх тэмцээнд хүрсэн үр дүнг хүчингүй болгох.....	45
10.9 Спортын арбитрын шүүхийн зардлыг гаргуулах болон мөнгөн шагналыг хураан авах.....	45
10.10 Санхүүгийн үр дагавар.....	45
10.11 Эрхийн хасалтын хугацааг тоолж эхлэх.....	45
10.12. Эрх хасуулсан үеийн байдал.....	47
10.13 Шийтгэлийг автоматаар хэвлэн нийтлэх.....	48
11 ДҮГЭЭР БҮЛЭГ: БАГТ УЧРУУЛАХ ҮР ДАГАВАР	49
11.1 Багийн спортын шинжилгээ.....	49
11.2 Багийн спортод учруулах үр дагавар.....	49
11.3 Тэмцээнийг зохион байгуулагчид Багийн спортод зориулсан хатуу шийтгэл батлах.....	49
12 ДУГААР БҮЛЭГ: СПОРТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ОНОГДУУЛАХ ШИЙТГЭЛ	49
13 ДУГААР БҮЛЭГ: ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ	50
13.1 Давж заалдаж шийдвэрүүд.....	50
13.2 Допингийн эсрэг журмын зөрчил, үр дагавар болон эрхийн түр түдгэлзүүлэлт, шийдвэр болон үндэслэлийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шийдвэрийг давж заалдах	51
13.3. Допингийн эсрэг байгууллагын цагтаа гараагүй шийдвэрийн алдаа	53
13.4 Эмчилгээний зориулалтаар хэрэглэх зөвшөөрөлтэй холбоотой давж заалдах.....	53
13.5 Давж заалдсан тухай шийдвэрийг мэдэгдэх.....	53
13.6 Дүрмийн гурав, дөрөвдүгээр хэсгийн хүрээнд үүсэх үр дагавартай холбоотой шийдвэрийг давж заалдах	53

13.7 Лабораторийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох тухай шийдвэрийг давж заалдах	53
14 ДҮГЭЭР БҮЛЭГ: НУУЦЛАЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ	54
14.1 Сөрөг аналитик илэрц, гаж илэрц болон Допингийн эсрэг журмын бусад батлагдсан зөрчилтэй холбоотой мэдээлэл.....	54
14.2 Допингийн эсрэг дүрмийн зөрчлийн шийдвэрийг мэдэгдэх болон баримт хүсэх	55
14.3 Олон нийтэд мэдээлэх	55
14.4 Статистик тайлан	56
14.5 Допингинд тавигдах хяналттай холбоотой мэдээллийн төв.....	56
14.6 Мэдээллийн нууцлал	57
15 ДУГААР БҮЛЭГ: ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЛЭХ БА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ	57
16ДУГААР БҮЛЭГ: СПОРТЫН УРАЛДААНД ОРОЛЦОЖ БУЙ АМЬТАНД ХАМААРАХ ДОПИНГИЙН ХЯНАЛТ.....	58
17ДУГААР БҮЛЭГ: ХЯЗГААРЛАЛТЫН ЖУРАМ.....	58
ХОЁРДУГААР ХЭСЭГ: БОЛОВСРОЛ, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА	59
18 ДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ.....	59
18.1 Тулгуур зарчим болон үндсэн зорилго	59
18.2 Хөтөлбөр болон үйл ажиллагаа.....	59
18.3 Үйл ажиллагааны мэргэжлийн дүрэм	60
18.4 Удирдлага болон хамтын ажиллагаа.....	60
19 ДҮГЭЭР БҮЛЭГ: ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА.....	60
19.1 Допингийн эсрэг судалгааны зорилго зорилт	60
19.2 Судалгааны төрөл	61
19.3 Судалгааны удирдлага ба үр дүнг мэдээлэх.....	61
19.4 Судалгааны талаархи практик	61
19.5 Хориглосон бодис болон хориглосон арга барилын удирдлага, зохицуулалт	61
19.6 Үр дүнг хууль бусаар ашиглах	61
ГУРАВДУГААР ХЭСЭГ:	62
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА.....	62
20 ДУГААР БҮЛЭГ: ГАРЫН ҮСЭГ ЗУРАГЧ ЭТГЭЭДҮҮДИЙН ХҮЛЭЭХ НЭМЭЛТ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	62
20.1 Олон улсын олимпийн хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	62
20.2 Олон улсын паралимпийн хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	63
20.3 Олон улсын холбоодын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	63
20.4 Үндэсний олимпийн хороо болон Үндэсний паралимпийн	65

хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага.....	65
20.5 Допингийн эсрэг үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүрэг,	66
хүлээх хариуцлага.....	66
20.6 Томоохон тэмцээний зохион байгуулах байгууллага гүйцэтгэх.....	67
үүрэг, хүлээх хариуцлага	67
20.7 ДДЭА-ын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага.....	68
21 ДҮГЭЭР БҮЛЭГ: ОРОЛЦОГЧДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА	69
21.1 Тамирчдын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	69
21.2 Тамирчдыг дэмжих ажилтны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	69
21.3 Бүсийн допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	70
22 ДУГААР БҮЛЭГ: ЗАСГИЙН ГАЗРЫН ОРОЛЦОО	71
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:	72
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, НИЙЦҮҮЛЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТАЙЛБАРЛАХ	72
23 ДУГААР БҮЛЭГ: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, НИЙЦҮҮЛЭХ	72
БА ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ.....	72
23.1 Дүрмийг хүлээн зөвшөөрөх	72
23.2 Дүрмийн хэрэгжилтийг хангах	72
23.4. Дүрэмтэй нийцэх.....	73
23.5 Энэхүү дүрэмд нийцүүлэх ажиллагаанд үнэлгээ хийх	73
23.6 Үйл ажиллагааг дүрэмд нийцүүлээгүйгээс гарах үр дагавар	74
23.7 Дүрэмд өөрчлөлт оруулах	75
23.8 Дүрмээс татгалзах	75
24 ДҮГЭЭР БҮЛЭГ: ДҮРМИЙГ ТАЙЛБАРЛАХ.....	75
25 ДУГААР ЗҮЙЛ: ШИЛЖИХ ЗААЛТ	76
25.1 2015 Дүрмийн ерөнхий хэрэглээ	76
25.2 10.7.5 зүйл, 17 дугаар бүлэг эсвэл “Lex Mitior” зарчмаас бусад тохиолдолд буцаж хэрэглэгдэхгүй байх.....	76
25.3 2015 дүрмийн өмнөх шийдвэрийг хэрэглэх	76
25.4 Эхний зөрчил нь 2015 оны 1 дүгээр сарын 15-наас өмнө тохиолдсон хэд хэдэн зөрчил 77	
25.5 Дүрмийн бусад нэмэлт өөрчлөлтүүд.....	77
ХАВСРАЛТ 1	78
ТОДОРХОЙЛОЛТ	78
ХАВСРАЛТ 2 10 ДУГААР БҮЛГИЙГ ХЭРЭГЛЭХ ЖИШЭЭ	87

ТАНИЛЦУУЛГА, ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР, ДҮРМИЙН БҮТЭЦ, ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Дэлхийн Допингийн эсрэг хөтөлбөр болон Дүрмийн зорилго нь:

- Допинггүй спортын уралдаан тэмцээнд оролцох тамирчдын үндсэн эрхийг хамгаалах болон дэлхий дахинаа тамирчдын эрүүл мэнд, шударга байдал болон тэгш эрхийг хөхүүлэн дэмжих,
- Допингийг илрүүлэх, хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн уялдуулан нэгтгэсэн, үр өгөөж бүхий хөтөлбөрийг олон улсын болон үндэсний хэмжээнд батлахад оршино.

Тайлбар: Олимпын Харти ба 2005 оны 10 дугаар сарын 19-ны өдөр батлагдсан спорт дахь допингийн эсрэг олон улсын конвенци-2005 (ЮНЕСКО конвенци) нь Олон улсын олимпын хорооны ба ЮНЕСКО-гийн зорилгын аюултай хэсэг болох спорт дахь допингоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх болон дүрмийн суурь үүргүүдийг хүлээн зөвшөөрсөн.

ДҮРЭМ

Спорт дахь Дэлхийн Допингийн эсрэг хөтөлбөр нь Энэхүү дүрэмд үндэслэгдэх бөгөөд тэр нь тулгуур буюу түгээмэл баримт бичиг болно. Энэхүү дүрмийн зорилго нь Допингийн эсрэг үндсэн элементүүдийг уялдуулах замаар бүх нийтийн хүчин чармайлтыг нэгтгэхэд оршино. Тийнхүү Допингийн эсрэг тэмцэлд уялдуулан зохицуулахын тулд энэ нь тодорхой байх шаардлагатай бөгөөд аль ч тохиодолд Допингийн эсрэг тохиролцсон зарчмуудыг хэрэглэхэд уян хатан байх шаардлагыг хангах үүднээс түгээмэл байна. Дүрэм нь тэнцвэртэй байдлын болон хүний эрхийн зарчмуудыг хангах боломжийг олгож байна.

ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР

Дэлхийн Допингийн эсрэг хөтөлбөр нь Допингийн эсрэг олон улсын болон үндэсний хэмжээний хөтөлбөрбүүдийг уялдуулан нэгтгэх, шилдэг арга барилыг нэвтрүүлэхэд шаардлагатай бүхий л иж бүрдлийг хамарна. Үндсэн иж бүрдлүүдэд:

1 дүгээр түвшин: Дүрэм

2 дугаар түвшин: Олон улсын стандартууд

3 дугаар түвшин: Шилдэг практикийн загвар зэрэг хамаарна.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД

Допингийн эсрэг хөтөлбөрийн хүрээн дэх техникийн болон гүйцэтгэлийн хэсэгт хэрэглэгдэх олон улсын стандартуудыг Энэхүү дүрэмд гарын үсэг зурагсад болон засгийн газрууд зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулж, сайжруулах бөгөөд түүнийг нь ДДЭА батална. Олон улсын эдгээр стандартуудыг Допингийн эсрэг хөтөлбөрийн техникийн болон гүйцэтгэлийн хэсгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Допингийн эсрэг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан нийцүүлэх зорилгоор боловсруулна. Олон улсын стандартуудыг Дүрэмд нийцүүлэн дагаж мөрдөх ёстой. ДДЭА-ын Гүйцэтгэх зөвлөл тодорхой асуудлаар гарын үсэг зурагсад, засгийн газрууд болон бусад сонирхолын бүлгүүдтэй зөвлөлдсөний дараа олон улсын стандартуудыг өөрчлөх эрхтэй. Олон улсын стандартууд буюу түүнд оруулах бүх өөрчлөлт нь ДДЭА-ийн цахим хуудсанд байрших бөгөөд олон улсын стандартууд болон түүнд оруулах өөрчлөлтөд заасан мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Олон улсын стандартын тухай тайлбар: олон улсын стандартуудад Энэхүү дүрмийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л техникийн заалтыг тусгана. Олон улсын стандартуудыг гарын үсэг зурагч, засгийн газар, бусад сонирхолын бүлгүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр шинжээчид боловсронгуй болгож, бие даасан салангид баримт бичгүүдэд тусгаж болно. ДДЭА-гийн гүйцэтгэх зөвлөл нь дүрмэнд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр цаг үеийн өөрчлөлтийг Олон улсын стандартуудад оруулж байх нь чухал.

ШИЛДЭГ АРГА БАРИЛЫН ЗАГВАР

Энэхүү дүрэм болон олон улсын стандартад үндэслэсэн шилдэг арга барилын загварыг Допингийн эсрэг төрөл бүрийн салбарт орчин үеийн дэвшилтэт шийдэл олох зорилгоор боловсруулна. Гарын үсэг зурагчид болон бусад сонирхолын бүлгийн хувьд ДДЭА-гаас эдгээр загвар, зааврыг зөвлөмж хэлбэрээр гаргах бөгөөд тэр нь заавал дагаж мөрдөх үүрэг хүлээлгэхгүй. Допингийн эсрэг баримт бичгийн загварыг үйлдэхээс гадна ДДЭА нь гарын үсэг зурагсдад сургалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна.

Шилдэг арга барилын загварын тухай тайлбар:

Эдгээр загвар бичиг баримтуудыг түүний оролцогчид сонголт хийж болохуйц байдлаар сонголттойгоор боловсруулна. Зарим оролцогч журам, зохицуулалтын загвар болон бусад шилдэг арга барилын загварыг байгаа чигээр нь батлуулахаар сонгож болно. Зарим нь загварыг өөрчлөлт оруулан батлахаар шийдвэрлэж болно. Мөн бусад оролцогчид Энэхүү дүрмээр тодорхойлсон ерөнхий зарчим болон тусгай нөхцлүүдэд нийцүүлэн өөрийн журмыг тус тус боловсруулахаар сонголт хийж болно.

Допингийн эсрэг ажлын тодорхой хэсэгтэй холбоотой загвар бичиг баримт болон зааврыг нийт оролцогчдын шаардлагыг хүлээн зөвшөөрсөн хэрэгцээ, хүлээлтэд тулгуурлан боловсруулан сайжруулна.

ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ДҮРМИЙН ТУЛГУУР ҮНДЭСЛЭЛ

Допингийн эсрэг хөтөлбөр нь спортын үнэт зүйлс ба түүнийг хадгалахад чиглэгдэнэ. Эдгээр үнэт зүйлсийг ихэнх тохиолдолд “Спортын амин сүнс” гэж нэрлэнэ. Энэ нь хүн бүрийн байгалийн авъяасыг төгөлдөржүүлэх зорилгоор дамжуулан хүн бүрийн дагаж мөрдөх олимпийн хөдөлгөөний мөн чанар, бидний хэрхэн шударга тоглохын баталгаа юм. Спортын амин сүнс гэдэг нь бидний спортоор дамжуулан олж авах үнэт зүйлсээр тодорхойлогдох этгээдийн үзэл санаа, бие цогцос, оюун ухааны баяр бахдал мөн:

- Ёс суртахуун болон шударга, үнэнч байдал
- Эрүүл мэнд
- Ур чадвар
- Зан суртахуун болон боловсрол
- Баяр баясгалан, сэтгэл ханамж
- Багийн ажиллагаа
- Үнэнч сэтгэл
- Хууль тогтоомжийг хүндэтгэх
- Өөрийгөө болон өрсөлдөгчөө хүндэтгэх
- Эр зориг
- Нийтэч байдал болон эв нэгдэл

Допинг бол спортын амин сүнсний эсрэг зүйл мөн.

Дүрэм нь спортын амин сүнснийг хөгжүүлэхийн тулд допингтой тэмцэхэд Допингийн эсрэг байгууллага бүрээс тамирчин, залуучууд, тамирчинд туслах хүмүүст зориулсан боловсролын болон урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийг шаардана.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ДОПИНГИЙН ХЯНАЛТ

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү дүрмийн I хэсэгт Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын холбоод, Үндэсний Олимпийн хороод, Үндэсний паралимпийн хороод, том тэмцээний зохион байгуулах хороо, Допингийн эсрэг үндэсний байгууллага зэрэг өөрсдийн эрх хэмжээний хүрээнд Допингийн эсрэг журам батлах, хэрэгжүүлэх буюу гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагуудын дагаж мөрдөх тусгайлсан журам, зарчмуудыг тусгасан болно. Эдгээр бүх байгууллагыг цаашид Допингийн эсрэг байгууллага гэнэ.

Дүрмийн бүх заалт нь Допингийн эсрэг байгууллага бүр, тамирчин эсвэл бусад хүмүүсийн зайлшгүй дагаж мөрдөх зүйл болно. Дүрэм нь допингийн эсрэг байгууллага бүрээс баталсан болон батлах допингийн эсрэг дүрэмд заасан хэрэгцээг өөрчлөх эсвэл орлохгүй.

Дүрмийн зарим заалтыг Допингийн эсрэг байгууллагууд өөрийн гаргах журамд өөрчлөлтгүйгээр тусгаж болох хэдий ч, Дүрмийн бусад заалт нь Допингийн эсрэг байгууллагуудаас батлах журамд уян хатан зохицуулалт хийж өгөхийг үүрэг болгосон үндсэн зарчмыг тодорхойлох буюу Допингийн эсрэг өөрийн дүрмэндээ тусгах шаардлагагүйгээр Допингийн эсрэг байгууллагуудад дагаж мөрдүүлэх шаардлагыг тогтоож болно.

Допингийн эсрэг журам бол тэмцээний дүрмийн нэгэн адил тэмцээн зохион байгуулахад шаардлагатай зүйлшгүй дүрмийн нэг юм. Тамирчид үүнийг тэмцээнд оролцох нөхцөл гэдэг утгаар хүлээн авна.

Гарын үсэг зурагч бүр өөрсдийн засгийн газрын байгууллага түүний гишүүн байгууллагын хүрээнд тамирчин, түүнд холбоотой хүмүүст зориулан дүрэм, журам боловсруулан батлан мэдээлэх ба харъяалах допингийн эсрэг байгууллагын допингийн эсрэг дүрмийг зөвшөөрөн дагаж мөрдөнө.

Гарын үсэг зурагч бүр өөрсдийн засгийн газрын байгууллага түүний гишүүн байгууллагын хүрээнд тамирчин, тамирчины хамараалтай этгээдэд зориулан дүрэм, журам боловсруулах ба дүрмийн шаардлага, эрхийн хүрээнд тэдний хувийн мэдээллийг түгээх, дүрмийг дагаагүй тамирчин, тамирчины хамараалтай этгээдэд зохих шийтгэлийг ногдуулах талаар тусгана.

Допингийн эсрэг журам нь эрүүгийн шүүн таслах ажиллагааны буюу хөдөлмөрийн асуудалд хэрэглэгдэх шаардлага болон хууль зүйн стандартуудад нийцүүлэх буюу хязгаарлалтанд хамаарагдахгүй. Энэхүү дүрмэнд тусгасан бодлого болон наад захын стандартууд нь спортод шударгаар хандах ашиг сонирхол бүхий оролцогчдын өргөн хүрээнд хийх зөвшилцлийг тогтоох бөгөөд тэдгээрийг шүүхийн байгууллагууд этгээддэтгэн үзвэл зохино.

Танилцуулгын тухай тайлбар:

Дүрмийн заалтууд нь 23.2.2 заасан өөрчлөлтгүйгээр допингийн эсрэг байгууллагуудыг нэгтгэнэ. Жишээ нь

Гарын үсэг зурагч бүх этгээд Допингийн эсрэг журмын зөрчлийн талаар нэгэн ижил шийдвэр гаргаж, нэгэн адилаар нотлох үүрэг хүлээж, нэгэн ижил Допингийн эсрэг журмын зөрчилд нэгэн ижил үр дагавар оногдуулна гэдэг нь ихээхэн чухал асуудал юм.

Олон улсын Холбоо, эсвэл үндэсний хэмжээнд болон Спортын арбитрын шүүхийн өмнө хэрэг хянан хэлэлцэгдэх үед ч гэсэн эдгээр бие даасан журмууд нь ижил байх ёстой.

23.2.2-т заагдаагүй дүрмийн заалтууд одоо ч хүчин төгөлдөр үйлчлэх байгаа ч Допингийн эсрэг байгууллагууд агуулгын хувьд үгчлэн заавал хэрэгжүүлэх шаардлагагүй. Эдгээр заалтууд ерөнхийдөө 2 хэсэгт хуваагдана.

Нэгдүгээрт, Допингийн эсрэг байгууллагуудад шууд үйлчлэх боловч тэд өөрийн дүрэмдээ давтан оруулах шаардлагагүй заалтууд. Жишээ нь: Допингийн эсрэг байгууллагууд 5 дугаар бүлэгт зааснаар заавал шинжилгээг төлөвлөх, авах боловч өөрийн дүрмэндээ давтан оруулах шаардлагагүй. Хоёрдугаарт, Тогтмол хүчин төгөлдөр үйлчлэх боловч Допингийн эсрэг байгууллага өөрийн дүрмийн дагуу уян хатан байдлаар хэрэгжүүлж болох заалтууд, Жишээ нь: Гарын үсэг зурагч этгээдүүд хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа болон үр дүнгийн зохицуулалтын талаар адил журам хэрэглэх шаардлагагүй. Өнөөдрийн нөхцөлд Олон улсын өөр өөр холбоод болон үндэсний эрх бүхий өөр өөр этгээдүүд нь үйлчлэлийн болон бусад байдлаар мөн өөр хоорондоо ялгаатай хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны журам болон үр дүнгийн журам хэрэглэж байна. Энэхүү дүрмээр заавал нэгэн ижил хэрэг хэлэлцэх журам болон хүрэх үр дүнгийн журам хэрэглэхийг шаардахгүй хэдий ч Гарын үсэг зурагч этгээдүүдийн ялгаатай хандлагууд нь Дүрмийн зарчмуудыг хангасан байхыг шаардана.

Гарын үсэг зурагч этгээд бүр өөрийн захиргааны тамирчин, бусад этгээд, гишүүн байгууллагуудын хувийн мэдээллийг дүрмэнд зөвшөөрөгдсөний дагуу тараах, допингийн эсрэг дүрмийг дагаж мөрдөх, дүрмийг дагаж мөрдөөгүй тамирчин, бусад этгээдэд зохих шийтгэл оноох боломж олгох зорилго бүхий дүрэм, журмыг батлана.

Эдгээр спортын тусгай дүрэм, журам нь допингийн эсрэг дүрмийг хэрэгжүүлэх зорилготой байх ба эрүүгийн болон иргэний хууль дүрмээс ялгаатай байна. Тэдгээр нь үндэсний аливаа шаардлага болон хуулийн стандартыг өөрчлөх, хязгаарлах ёсгүй бөгөөд тэнцвэртэй байдлын болон хүний эрхийн зарчмуудыг хүндэтгэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийн процесст хэрэглэгдэнэ.

Хуулийн тухайн тохиолдлын баримтыг хянан хэлэлцэх үед бүх шүүх, арбитрын шүүх бүрэлдэхүүн болон бусад хамаарах этгээд нь дүрмийн хүрээнд дэхь допингийн эсрэг ялгаатай байдлыг мэдэж, хүндэтгэн үзэх бөгөөд тэдгээр дүрэм нь шударга спорт бий болгох сонирхол бүхий сохирхолын бүлгийн эрх ашгийг төлөөлнө.

1 ДҮГЭЭР БҮЛЭГ: ДОПИНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Допинг гэж энэхүү дүрмийн 2.1-ээс 2.10-д заасан Допингийн эсрэг журмын зөрчил нэг буюу түүнээс дээш удаа гарсан тохиолдлыг хэлнэ.

2 ДУГААР БҮЛЭГ: ДОПИНГИЙН ЭСРЭГ ЖУРМЫН ЗӨРЧИЛ

Тамирчин ба тамирчины хамараалтай этгээд нь допингийн эсрэг дүрмийн зөрчил гэж юуг хэлэх, ямар бодис, аргууд хориглосон бодисын жагсаалтанд ордгийг мэдэж байх үүрэгтэй.

Дараахь тохиолдлуудад Допингийн эсрэг журам зөрчигдсөнд тооцно:

Энэ зүйлийн зорилго нь үүссэн нөхцөл байдал тодорхойлох буюу эдгээрээс чухам аль нь Допингийн эсрэг журмыг зөрчиж буйг тогтооход оршино. Эдгээр нэг буюу түүнээс дээш тодорхой журмууд нь зөрчигдсөн эсэхийг тогтоох нөхцөл байдалд үндэслэн Допингийн хэргийг хэлэлцэх ажиллагааг явуулна.

2.1 Тамирчны дээжнээс хориглосон бодис, эсвэл түүний хувирал буюу шинж тэмдэг илэрсэн.

2.1.1 Өөрийнхөө биед хориглосон бодис шингээхгүй байх нөхцөл байдлыг хангах нь тамирчны хувийн үүрэг мөн. Түүний дээжээс хориглосон бодис, эсвэл түүний хувирал буюу шинж тэмдэг илэрсний хариуцлагыг тамирчин өөрөө хүлээнэ. 2.1-д заасны дагуу Допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн эсэхийг тогтооход тамирчин тэдгээрийг хэрэглэх болсон санаа, гэм буруу, хайхрамжгүй эсвэл зориудаар хэрэглэсэн эсэхийг нотлох шаардлагагүй.

Энэ зүйлд зааснаар тамирчин буруугүй байсан ч допингийн эсрэг дүрэм зөрчигдсөнд тооцно. Уг заалт нь спортын арбитрын шүүхээс хатуу хариуцлага оногдуулах шийдвэр гаргахад лавлагаа болно. Тамирчны бурууг 10 дугаар бүлэгт заасан допингийн эсрэг дүрмийн зөрчлийн үр дагавар гэсэн тодорхойлолтын хүрээнд авч үзнэ. спортын арбитрын шүүх энэ зарчмыг баримталж байна.

2.1.2 Дараахи тохиолдлуудад допингийн эсрэг дүрмийн 2.1 заалт зөрчигдсөн нь нотлогдсон гэж үзнэ. Үүнд: тамирчны А сорьцонд Хориотой бодис, түүний дүрс хувирал, шинж тэмдэг илрэх ба тамирчин Б сорьцоо шинжлүүлэхээс татгалзснаар Б сорьц шинжлэгдээгүй. Эсвэл тамирчны Б сорьц шинжлэгдэж, Б сорьцын дүн нь А сорьцод олдсон хориотой бодис, түүний дүрс хувирал, шинж тэмдэг илэрсэн болохыг дахин батлах; дээжийн В сорьцийг 2 саванд хуваан шинжилсэн ч хоёр дахь савны шинжилгээ нь хориглосон бодис, түүний дүрс хувирал байгааг батлах

2.1.2-ийн тайлбар: Допингийн эсрэг байгуулага үр дүнг тооцох үед тамирчин Б сорьцоо шинжлүүлэхээс татгалзсан тохиолдолд ч Б сорьцыг шинжлүүлэх сонголтыг нээлттэй үлдээх үүрэгтэй.

2.1.3 Дээрхи бодисоос гадна хориглосон жагсаалтанд хэмжээг нь тухайлан заасан аль нэг хориглосон бодис, түүний дүрс хувирал, шинж тэмдэг тамирчны дээжинд илэрвэл допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэж үзнэ.

2.1.4 2.1 бүлгийн ерөнхий дүрмийн дагуу Хориглосон жагсаалт эсвэл олон улсын стандартад тухайн хориглосон бодисноос өөрөөс нь гаргаж авдаг бодиснуудыг үнэлэх тусгай шалгуурыг баталж болно.

2.2 Хориглосон бодис, эсвэл хориглосон арга хэрэглэх буюу хэрэглэхийг завдах

2.2.1 Өөрийнхөө биед хориглосон бодис шингээхгүй байх нөхцөл байдлыг хангах болон хориглосон арга хэрэглэхгүй байх нь тамирчны хувийн үүрэг мөн. Төлөвлөж, санамсаргүй, үл тоомсорлож, эсвэл зориудаар хэрэглэсэн эсэхээс үл хамааран тамирчин Хориотой арга, хориотой бодис хэрэглэсэн гэсэн допингийн эсрэг дүрмийг зөрчсөнд тооцно.

2.2-ийн тайлбар: Хориотой бодис, Хориглосон арга хэрэглэх, хэрэглэхийг хориглох тохиолдлыг ямар ч найдвартай аргаар тогтоож болно. 3.2 зүйлд тэмдэглэсэнээр 2.1 т заасан допингийн эсрэг дүрмийн зөрчлийг батлахаас өөр бөгөөд гэрчийн мэдүүлэг, баримтын нотолгоо, тамирчны биологийн паспортын хэсэг болохын хувьд цуглуулсан мэдээллийг багтаасан урт хугацааны судалгааны дүгнэлт, 2.1 –т заасан хориотой бодис илрүүлэх бүх шаардлагыг бүрэн хангаагүй бусад шинжилгээний мэдээлэл зэрэг тамирчны оролцотой бусад найдвартай аргаар хориотой бодис хэрэглэсэн, хэрэглэхийг оролдсоныг тогтоож болно. Тухайлбал хэрэглээ нь А дээжийн шинжилгээний найдвартай аналитик мэдээлэл (В дээжийн баталгаажуулах шинжилгээ хийгээгүй), эсвэл Допингийн эсрэг байгууллагаас бусад дээжийн баталгааны дутагдлын талаар хангалттай тайлбар гаргаж өгсөн үед зөвхөн В дээжийн дүнг үндэслэн тогтоогдож болно..

2.2.2 Хориотой бодис, хориотой арга хэрэглэсэн эсвэл хэрэглэхийг оролдсон нь амжилтай эсвэл амжилтгүй болсон эсэх нь баримт болохгүй. Харин Хориотой бодис эсвэл хориотой арга хэрэглэсэн эсвэл хэрэглэхийг оролдсон нь допингийн эсрэг дүрмийн зөрчил болно.

2.2.2-ийн тайлбар: Хориотой бодис, хориотой арга “Хэрэглэхийг оролдох” заалтыг төлөвлөгөөтэй зөрчөөгүйг тамирчин нотлох шаардлагатай. Төлөвлөгөө нь 2.1 бүлэг болон Хориотой бодис, хориотой арга хэрэглэх гэсэн 2.2 бүлэгт заасан, допингийн эсрэг дүрмийг зөрчих зорилгогүй байсан гэдгийг нотлох шаардлагатай. Хориглосон бодис хэрэглэх гэсэн допингийн эсрэг дүрмийн зөрчлийг тухайн бодис нь тэмцээний үед хэрэглэхийг хориглоогүй, тамирчин тэмцээний бус үед түүнийг хэрэглэсэнээс бусад тохиолдолд тооцно. (Харин Хориотой бодис, түүний дүрс хувирал, шинж тэмдэг нь тэмцээний үеийн шинжилгээнд илэрч 2.1 зүйлд заасан дүрэм зөрчигдсэн бол уг бодисыг хянан шийдвэрлэнэ.)

2.3 Дээж өгөхөөс зайлсхийх, татгалзах, дээжээ өгөхгүй байх

Мэдэгдэл хүлээн авснаас хойш ямар нэгэн тодорхой шалтгаангүйгээр дээж өгөхөөс зайлсхийх, татгалзсан, эсвэл өгөөгүй энэ заалтыг хэрэглэнэ

2.3-ийн тайлбар: Тухайлбал, тамирчин Допингийн эсрэг шинжилгээ авах гэсэн оролдсон эрх бүхий этгээдээс нуугдсан тохиолдолд түүний тухайн үйлдлийг нь Допингийн эсрэг журам зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй. Дээж өгөхөөс зайлсхийсэн нь тухайн тамирчны санаатай үйлдэл гэж үзэх үед “дээж өгөхөөс татгалзсан, эсвэл өгөөгүй” зэргийг тамирчны санаатай эсвэл хайхрамжгүй үйлдэл гэж тодорхойлно.

2.4 Байршлын мэдээллийн алдаа

Шинжилгээний бүртгэлийн санд бүртгэлтэй байгаа тамирчин 12 сарын хугацаанд 3 удаа шинжилгээ өгөхгүй байх эсвэл байршлын тухай мэдээллээ явуулаагүй байх тохиолдолд

2.5 Допингийн хяналтын аль нэг хэсэгт хөндлөнгөөс оролцох буюу хөндлөнгөөс оролцохоор завдах

Хориотой арга хэрэглэх гэсэн тодорхойлолтонд багтсанаас бусад тохиолдолд допингийн хяналтын үйл ажиллагааг тасалдуулсантай холбоотой тохиолдлууд. Хөндлөнгөөс оролцох гэдэгт допингийн хяналтын ажилтныг санаатайгаар болон санамсаргүйгээр саатуулах, саатуулахыг оролдох, допингийн эсрэг байгууллагыг хуурамч мэдээллээр хангах, гэрчийг айлган сүрдүүлэх, айлган сүрдүүлэхийг оролдох зэргийг хамруулна.

2.5-ийн тайлбар: Тухайлбал, шинжилгээний үеэр Допингийн хяналтын хуудасны дугаарыг өөрчлөх буюу Б дээжийг шинжилж байх үед Б савыг гэмтээх, Гаднаас өөр бодисыг дээж өгөх зорилгоор нэмэх зэрэг үйлдлүүд багтана.

Допингийн хяналтын үед допингийн хяналтын ажилтныг болон бусад этгээдийг гутаан доромжилсон хөндлөнгөөс оролцох гэсэн тодорхойлолтонд хамаарахгүй үйлдлийг спортын байгууллагын сахилгын дүрмийн дагуу арга хэмжээ авна.

2.6 Хориглосон бодис болон аргыг эзэмших:

2.6.1 4.4 дэх хэсэгт заасны дагуу эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгогдсон буюу өөр бусад хүлээж авахуйц шалтгаан байгаа зэргээс бусад тохиолдолд тэмцээний болон тэмцээний бус үед хэрэглэхийг хориглосон арга, хориглосон бодисыг хэзээ нэгэн цагт ашиглах.

2.6.2 4.4 дэх хэсэгт заасны дагуу эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгогдсон буюу өөр бусад хүлээж авахуй шалтгаан байгаа зэрэг шалтгааныг тамирчныг дэмжих ажилтан тогтоосноос бусад тохиолдолд тэмцээний үед хэрэлэхийг хориглосон арга, хориглосон бодис, эсвэл тамирчин, тэмцээн, бэлтгэл сургуулилттай холбоотой тэмцээний бус үед хэрэглэхийг хориглосон бодис, хориглосон бодисыг ашиглах.

2.6.1, 2.6.2 заалтын тайлбар: Тухайн этгээд эмчийн заавар, жорын дагуу эмчилгээний зорилгоор (тухайлбал чихрийн шижинтэй хүүхдэд инсулин худалдан авч өгөх гэх мэт) авснаас бусад тохиолдлууд (жишээ нь найз нөхөд, хамаатан садандаа өгөх зорилгоор худалдан авах зэрэг) нь зөвшөөрөгдөх үндэслэл болохгүй.

2.6.2 тайлбар: Багийн эмч нь хурц болон яаралтай нөхцөл байдлыг арилгах зорилгоор хориотой бодис тээвэрлэх зэрэг нь зөвшөөрөгдөх үндэслэл болно.

2.7 Аливаа хориглосон бодис, эсвэл аргыг худалдах худалдахыг завдах

2.8 Хориглосон бодис, хориглосон аргыг тэмцээний үед тамирчныг хэрэглэхийг тушаах, тэмцээний бус үед хэрэглэхийг хориглосон бодис, хориглосон аргыг тэмцээний бус үед хэрэглэхийг тамирчинд зааварлах, зааварлахыг завдах

2.9 Хамтран үйлдэх

Туслах, дэмжих, зоригжуулах, хуйвалдах, уруу татах, нууцлах болон бусад хэлбэрээр допингийн эсрэг дүрмийг хамтран зөрчих, допингийн эсрэг дүрмийг зөрчихийг оролдох, өөр этгээдийн тусламжтайгаар 10.12.1 заалтыг зөрчих

2.10 Хориглосон хамтын ажиллагаа

Тамирчин, бусад этгээд мэргэжлийн болон спортод хамааралтай чадавхиа өөрчлөх зорилгоор допингийн эсрэг байгууллагын мэдэлд байгаа дараахи этгээдтэй хамтран ажиллах:

2.10.1 Допингийн эсрэг байгууллагын мэдэлд байгаа эрх хасуулсан шийтгэлийн хугацаа нь үргэлжилж байгаа

2.10.2 Дүрмийн дагуу үр дүнгийн зохицуулалтын үйл явц үргэлжилж байгаагийн улмаас эрх хасах шийтгэл эцэслэн зарлагдаагүй байгаа, гэмт хэрэг болон сахилгын зөрчил гаргасан нь илэрсэн, допингийн эсрэг дүрэм зөрсөн нь нотлогдсон этгээд. Тухайн этгээдийн шийтгэх хугацаа нь гэмт хэргийн болон сахилгын шийтгэл оноосон тухай шийдвэр гарснаас 6 сараас доошгүй хугацаагаар хүчин төгөлдөр байх

2.10.3 2.10.1, 2.10.2-т заасан хувийн нөцөл байдлууд эхлэх, эсвэл үргэжилж байгаа

Тамирчин болон бусад этгээдийн эрх хасуулсан нөцөл, хамтран ажилласанаас үүсэх үр дагаварын талаар энэ зүйлийг хэрэглэхийн тулд тамирчин, бусад этгээд нь тамирчин болон бусад этгээд ДДЭА-тай зөвлөлдсөний үндсэн дээр допингийн эсрэг байгууллагаас урьдчилан бичгээр зөвлөгөө авах шаардлагатай. Ингэснээр тамирчин болон бусад этгээд энэ харилцаанаас зайлсхийж болно. Допингийн эсрэг байгууллага мэдэгдэл авсан тамирчин болон дэмжигч 2.10.1 ба 2.10.2-т тодорхойлсон шалгуурыг түүнд хэрэглэхгүй байх талаар 15 хоногтын дотор тайлбарлаж, зохих зөвлөгөө өгнө.

(17 дугаар зүйл болон энэ заалтыг тамирчны эрх хасагдах хугацаа 25 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болохоос өмнө ч хэрэглэгдэнэ.)

Энэ зүйл нь 2.10.1 2.10.2-т тодорхойлогдсон мэргэжлийн болон спортод хамааралгүй ямар нэг харилцаа үүсгэсэн тамирчин, дэмжигч этгээдэд хамаарахгүй.

Допингийн эсрэг байгууллага нь 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан шалгуурыг хангаж байгаа тамирчин болон бусад этгээдийн талаар мэдэж байх шаардлагатай бөгөөд уг мэдээллийг ДДЭА-т илгээнэ.

10.2-ийн тайлбар: Тамирчин болон бусад этгээд нь допингийн эсрэг дүрэм зөрчсөний улмаас эрхээ хасуулсан эсвэл гэмт хэрэгт холбогдсон эсвэл допингтой холбоотой мэргэжлийн шийтгэл авсан дасгалжуулагч, багш, эмч болон бусад тамирчныг дэмжигч этгээдтэй хамтран ажиллахыг хориглоно. Хамтран ажиллах хэлбэр гэдэгт бэлтгэл хийх, стратеги, техник, хоол, эмнэлгийн зөвлөгөө авах, эмчилгээ хийлгэх, шинжилгээний зорилгоор биеэсээ дээж өгөх, өөрийн төлөөлөгч, агентаар ажиллуулах зөвшөөрөл олгох зэрэг болно. Хориглосон ажиллагаа нь хэлбэрээс үл хамаарна.

3 ДУГААР БҮЛЭГ: ДОПИНГ ХЭРЭГЛЭСЭН ЭСЭХИЙГ НОТЛОХ

3.1 Нотлох үүрэг, түүний стандарт

Допингийн эсрэг байгууллагууд нь Допингийн эсрэг журам зөрчигдсөн эсэхийг тогтоох үүрэг хүлээнэ. Нотолгооны стандарт нь Допингийн тухайн эсрэг байгууллагаас Допингийн эсрэг журмын зөрчлийг хянан хэлэлцэх эрх бүхий этгээдээс түүний ноцтой эсэхийг тогтоож үзэхэд хангалттай үндэслэлтэй байхаар томъёологдоно. Энэхүү стандарт нь аль ч тохиолдолд боломжит байдлын туйлын тэнцлээс их боловч үндэслэл бүхий эргэлзээний нотолгооноос бага түвшинд байна. Энэхүү дүрмээр Допингийн эсрэг журам зөрчсөн хэмээн буруутгагдаад байгаа Тамирчин болон бусад этгээдэд энэ талаархи таамаглал болон тодорхой үйл баримт болон нөхцөл байдлыг няцаах үүрэг оногдуулсан үед уг стандарт нь боломжит байдлын тэнцвэрээр тодорхойлогдоно.

3.1-ийн тайлбар: Энэхүү нотолгооны стандартыг ихэнхи оронд мэргэжлийн алдаа бүхий хэргүүдэд хэрэглэгддэг стандартуудтай жиших үүргийг Допингийн эсрэг олон улсын байгууллага хариуцна.

3.2 Нөхцөл байдлыг тогтоох болон таамаглах арга

Допингийн эсрэг журмын зөрчилтэй холбогдох нөхцөл байдлыг зөвшөөрөх зэрэг найдвартай арга хэрэгслийн тусламжтайгаар тогтооно. Допингийн хэрэгт дараахь нотолгооны журмуудыг ашиглаж болно:

3.2-ийн тайлбар: Допингийн эсрэг байгууллага нь тамирчны мэдүүлэг, гуравдагч этгээдийн өгсөн гэрчийн баталгаат мэдүүлэг, зохих баримт бичгийн нотолгоо, 2.2 бүлгийн тайлбарт дурдсан А, Б сорьцийн шинжилгээний зохих хариу, эсвэл тамирчны цус, шээсний дээж, биологийн паспортаас цуглуулсан мэдээлэл зэрэгт үндэслэн 2.2 -т заасан допингийн эсрэг зөрчигдсөн эсэхийг тогтооно.

3.2.1 ДДЭА-аас холбогдох эрдэм шинжилгээний багтай зөвлөлдсөн болон туришлтын дараа баталсан шинжилгээний арга эсвэл шийдвэр нь шинжиллэх ухааны хувьд хүчин төгөлдөр болно. Аливаа тамирчин эсвэл тамирчныг дэмжигч этгээд өмнөх нөхцөл байдлаас хамаарч шинжлэх ухааны хүчин төгөлдөр байдлыг эсэргүүцэж, няцаалт өгөхдөө эхлээд эсэргүүцэж буй үндэслэлээ ДДЭА-т мэдээлнэ. Спортын арбитрын шүүх ДДЭА-ийн хүсэлтээр мэргэжлийн шинжээч томилж, уг эсэргүүцэлд үнэлгээ хийлгэнэ. ДДЭА ийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш болон ДДЭА нь спортын арбитрийн шүүхийн мэдээлэл

хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор ДДЭА нь шүүгчийн зөвлөмж гарах хүртэл эсвэл ажиллагаанд ямар нэг үр дүн гарах хүртэл ажиллагаанд оролцох эрхтэй.

3.2.2 ДДЭА-аас магадлан итгэмжлэгдсэн бөгөөд ДДЭА-аас баталсан бусад лабораториуд лабораторийн шинжилгээний олон улсын стандартын дагуу дээжийн шинжилгээ болон хяналтын журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна. Тамирчин эндээс гарсан таамаглалыг олон улсын стандартуудад заасан үндэслэлийн дагуу няцааж болно.

Хэрэв тамирчин олон улсын стандартуудын тусламжтайгаар тухайн таамаглалыг няцаасан тохиолдолд Допингийн эсрэг олон улсын байгууллагаас тухайн үндэслэлүүд нь Сөрөг аналитик илэрцэд хамаарахгүй гэдгийг нотлох үүрэг хүлээнэ.

3.2.2-ийн тайлбар: Лабораторийн олон улсын стандартаас нотлох баримт цуглуулах үүргийг Тамирчин хүлээнэ. Хэрэв Тамирчин ингэсэн тохиолдолд, түүний олсон үндэслэлүүд нь шинжилгээний үр дүнд нөлөөлөхгүй гэдгийг хэргийг шүүн хэлэлцэх эрх бүхий этгээдийн өмнө нотлох үүргийг Допингийн эсрэг байгууллага хүлээнэ.

3.2.3 Сөрөг аналитик илэрц болон Допингийн эсрэг бусад журмын зөрчилтэй холбогдохгүй Шинжилгээний олон улсын стандарт, допингийн эсрэг бусад дүрэм, дүрмийн хүрээнд бий болсон бодлого, допингийн эсрэг байгууллагын дүрмэнд заасан үндэслэлүүд нь тухайн гарсан нөлөө, үр дүнг няцаах боломжгүй. Хэрэв тамирчин нь Шинжилгээний үеэр Олон улсын стандартууд допингийн эсрэг бусад бодлогын үндэслэлээ ашигласан тохиолдолд Допингийн эсрэг байгууллага нь тэдгээр үндэслэлүүд Сөрөг аналитик илэрцэд үндэслэсэн допингийн эсрэг дүрэм болон Допингийн эсрэг дүрмийн бусад зөрчлийг тогтоох үйл баримтын үндэслэл зэрэгт хамаарахгүй гэдгийг нотлох үүрэг хүлээнэ.

3.2.4 Тамирчин, тамирчныг дэмжих ажилтан уг шийдвэр нь шударга ёсыг зөрчиж байгааг нотолсоноос бусад тохиолдолд шүүхийн шийдвэр эсвэл шүүхийн мэргэжлийн ур чадварын дүнд нотлогдсон баримтууд нь уг баримтанд хамаарал бүхий тамирчин, тамирчныг дэмжих ажилтны эсрэг хөдөлшгүй нотолгоо болно.

3.2.5 Шүүх бүрэлдэхүүн нь тамирчин болон бусад этгээдий хэрэг хянан шийдвэрлэх хурлаас өмнө урьдчилан болон хурлын үеэр (шууд биечлэн болон утсаар шүүх бүрэлдэхүүнд) хүсэлт гаргасны дараахи татгалзал болон шүүх бүрэлдэхүүнээс тавьсан асуултанд хариулсан байдал, эсвэл Допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрэм зөрчсөнийг зарласан зэрэгт үндэслэн допингийн эсрэг дүрэм зөрчсөн тамирчин болон бусад этгээд дүрмийн зөрчлийн талаар сөрөг дүгнэлт гаргаж болно.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ: ХОРИГЛОСОН ЖАГСААЛТ

4.1 Хориглосон жагсаалтыг хянах болон хэвлэн нийтлэх

ДДЭА-аас шаардлагатай үед буюу 1 жилээс ихгүй хугацааны дотор Хориглосон жагсаалтыг Олон улсын стандарт хэлбэрээр нийтлүүлнэ. Хориглосон жагсаалт болон түүний хянан шинэчлэн найруулсан хувилбаруудын агуулгыг бичгэн хэлбэрээр үйлдэх бөгөөд түүнийг Гарын үсэг зурагч болон засгийн газруудад санал авах зорилгоор

хүргүүлнэ. Жил бүр Хориглосон жагсаалт болон түүний шинэчлэн найруулсан хувилбаруудыг ДДЭА-аас Гарын үсэг зурагч болон засгийн газруудад хүргүүлж эдгээрийг тухайн байгууллага бүрийн болон ДДЭА-ийн цахим хуудсан дээр тавих бөгөөд Гарын үсэг зурагч бүр тухайн жагсаалтыг өөрийн гишүүн байгууллагууд болон албадад хүргүүлэх талаар ажиллана. Хориглосон жагсаалт, эсвэл бусад хувилбаруудад өөрөөр заагаагүй бол Допингийн эсрэг байгууллагаас уг жагсаалтыг нийтлүүлснээс хойш гурван сарын дараа Допингийн эсрэг байгууллагаас өөр бусад үйл ажиллагаа эрхлэн явуулах шаардлагагүйгээр хүчин төгөлдөр болно.

4.1-ийн тайлбар: Шаардлага гарсан бол хэдийд ч гэсэн Хориглосон жагсаалтыг шинэчлэн найруулах буюу хэвлэн гаргана. Гэсэн хэдий ч урьдчилан таамаглалын үүднээс өөрчлөлт орсон эсэхээс үл хамааран шинэ Хориглосон жагсаалтыг жил бүр хэвлэнэ. ДДЭА хүчин төгөлдөр жагсаалтыг цахим хуудсан дээрээ байрлуулна.

Хориглосон жагсаалт нь Спорт дахь Допингийн эсрэг конвенцийн салшгүй хэсэг байна. ДДЭА нь Хориглосон жагсаалтын ямар нэг өөрчлөлтийг ЮНЕСКО-гийн ерөнхий захиралд мэдээлнэ.

4.2 Хориглосон жагсаалтанд тусгагдсан Хориглосон бодис болон Хориглосон арга

4.2.1 Хориглосон бодис ба хориглосон арга

Тэмцээний өмнө биеийн чадавхийг сайжруулахын тул аль ч үед (тэмцээний үеэр буюу тэмцээний бус үед) хориглогдох, эсвэл зөвхөн тэмцээний үеэр тухайн хориглосон бодис болон арга барилыг хэрэглэснээр хувиргах чадвартайд тооцогдох хориглосон бодис болон хориглосон аргыг л Хориглосон жагсаалтад оруулна. Олон улсын холбоодоос зөвлөмж болгосны дагуу Хориглосон жагсаалтыг ДДЭА тодорхой нэр бүхий спортын хүрээнд өргөтгөж болно. Хориглосон бодис болон Хориглосон арга барилыг Хориглосон жагсаалтанд ерөнхий категорчилсан (анаболик бодис гэх мэт) буюу тодорхой бодис болон арга барилын ангилал хэлбэрээр тодорхойлж болно.

4.2.1-ийн тайлбар:

Тэмцээний үеэр авсан дээжнээс хориоглосон бодис, түүний дүрс хувирал илрэхээс бусад тохиолдолд зөвхөн тэмцээний үеэр хэрэглэхийг хориглосон бодисуудыг тэмцээний бус үед хэрэглэсэн бол түүнийг допингийн эсрэг дүрэм зөрчсөн гэж үзэхгүй.

4.2.2 Тусгайлан заагдсан бодисууд

10 дугаар бүлэгт зориулж, Тусгайлан заагдсан бодисууд гэж хориотой жагсаалтанд байгаа Анаболикийн төрлийн бодисууд, гормон, түүний идэвхижүүлэгчид ба хор тайлагчид, хурдасгагчдаас бусад бүх бодисуудыг нэрлэнэ. Тусгайлан заагдсан бодисуудын ангилал нь Хориотой аргад хамаарахгүй.

4.2.2-ийн тайлбар: 4.2.2-т дурдсан тусгайлан заагдсан бодисууд нь ямар ч нөхцөлд допингийн төрлийн бусад бодисоос чухал бус эсвэл аюулгүй гэсэн утга илэрхийлэхгүй. Харин эдгээр нь тамирчны спортын ур чадвараа ахиулахаас бусад зорилгоор хэрэглэдэг энгийн бодисууд юм.

4.2.3 Хориотой бодисын шинэ бүлэг

4.1 дэхь заалтын дагуу ДДЭА хориотой бодисын жагсаалтыг хориотой бодисын шинэ бүлэг нэмж өргөжүүлсэн, ДДЭА-ийн гүйцэтгэх зөвлөл аль нэг эсвэл бүх хориотой бодисыг Хориотой бодисын шинэ ангилалд дотор тодорхойлох ба 4.2.2 заалтын дагуу Тусгайлан заагдсан бодист хамрагдана.

4.3 Хориглосон жагсаалтанд тусгагдсан бодис болон арга барилыг тогтоох шалгуур

Хориглосон жагсаалтанд оруулах бодис болон арга барилыг тогтоохдоо ДДЭА дараахь шалгууруудыг харгалзан үзнэ.

4.3.1 Бодис болон арга барил нь дараахь гурван шалгуурын хоёрыг хангасан байх ёстой гэж ДДЭА дангаараа үзсэн тохиолдолд тухайн бодис болон арга барилыг Хориглосон жагсаалтанд оруулах тухай харгалзан үзнэ.

4.3.1.1 тухайн бодис болон арга барил нь спортын үр дүнг бодитойгоор нэмэгдүүлэх буюу нэмэгдүүлдэг гэдгийг тогтоосон эм зүйн нөлөөл, эсвэл туршлага, эсвэл эмийн, эсвэл шинжлэх ухааны нотолгоо;

4.3.1.2 тухайн бодис буюу арга барилын хэрэглээ нь Тамирчны эрүүл мэндэд эрсдэл үзүүлдэг гэдгийг тогтоосон эм зүйн нөлөөлөл, эсвэл туршлага, эсвэл эмийн, эсвэл шинжлэх ухааны нотолгоо;

4.3.1.3 тухайн бодис болон арга барилын хэрэглээ нь энэхүү дүрмийн удиртгал хэсэгт тодорхойлсон спортын үзэл санаанд үл нийцнэ гэдгийг ДДЭА-аас тогтоосон.

4.3.2 Тухайн бодис болон арга барил нь бусад төрлийн Хориглосон бодис болон Хориглосон аргуудын хэрэглээг халхавчилдаг гэдгийг эм зүйн нөлөөлөл, эсвэл туршлага, эсвэл эмийн эсвэл шинжлэх ухааны нотолгоогоор ДДЭА-аас тогтоосон тохиолдолд түүнийг Хориглосон жагсаалтанд оруулна.

4.3.2-ийн тайлбар: Жил бүр үйл ажиллагааны хэсэг болохын хувьд ДДЭА бүх гарын үсэг зурагчид, засгийн газрууд, бусад сонирхосон этгээдийг хориотой жагсаалтын агуулгын талаар санал ирүүлэхийг урина.

4.3.3 ДДЭА-аас гаргасан Хориглосон жагсаалт болон бүх цаг үеийн туршид эсвэл зөвхөн тэмцээний үед хэрэглэхийг хориглосон бодисын ангилалд багтсан Хориглосон бодис болон Хориглосон арга барил эцсийнх байх бөгөөд түүнийг Тамирчин, эсвэл бусад этгээд тухайн бодис болон арга барил нь ямар ч бодисыг халхавчлахгүй буюу спортын үр дүнг дээшлүүлэхгүй, эрүүл мэндэд хохирол учруулахгүй буюу эсвэл спортын үзэл санааг зөрчөөгүй гэдэг үндэслэлээр эсэргүүцэж болохгүй.

4.4 Эмчилгээний зорилгоор чөлөөлөх

4.4.1 Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын дагуу эмчилгээний зорилгоор чөлөөлөх батламж олгогдсон бол шинжилгээгээр илрсэн хориглосон бодис, түүний дүрс хувирал болон хориглосон бодис, хориглосон арга хэрэглэх, хэрэглэхийг оролдох, эзэмших, эзэмшихийг оролдох, зааварлах, зааварлахыг оролдох үйлдлийг допингийн эсрэг дүрэм зөрчсөнд тооцохгүй.

4.4.2 Олон улсын зэрэглэлийн бус тамирчин эмчилгээ зорилгоор чөлөөлүүлэх хүсэлтийг Үндэсний допингийн эсрэг байгууллагадаа гаргана. Хэрэв Үндэсний допингийн эсрэг байгууллага хүсэлтийг хүлээн авахаас татгалзвал 13.2.2, 13.2.3 дахь хэсэгт заасны дагуу үндэсний шүүх байгууллагад давж заалдах эрхтэй.

4.4.3 Олон улсын зэрэглэлийн тамирчин өргөдлөө олон улсын холбоондоо гаргана.

4.4.3.1 Тамирчны Үндэсний Допингийн эсрэг байгууллагаасаа авсан эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартад нийцэж байвал олон улсын холбоо уг баталгааг хүлээн зөвшөөрнө. Хэрэв олон улсын холбоо нь уг баталгаа эмчилгээний зорилгоор чөлөөлөх стандартад нийцэхгүй байна гэж үзвэл түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах ба хүлээн зөвшөөрөөгүй шалтгаанаа тамирчин болон үндэсний допингийн эсрэг байгууллагад яаралтай мэдээлнэ. Тамирчин татгалзсан тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ДДЭА-т дахин хянуулах хүсэлт гаргаж болно. ДДЭА дахин хянахаар хүсэлтийг хүлээн авсан бол Үндэсний допингийн эсрэг байгууллагаас олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь ДДЭА-ийн шийдвэр гарах хүртэл үндэсий хэмжээнд тэмцээний болон тэмцээний бус(Олон улсын тэмцээнд хүчингүй) үед хүчинтэй хэвээр байна. ДДЭА хянан хэлэлцэх хүсэлт гаргаагүй бол эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь хянан хэлэлцэх 21 хоногийн хугацаа дуусмагц аль ч түвшинд хүчингүй болно.

4.4.3.2 Хэрэв тамирчин үндэсний допингийн эсрэг байгууллагаас эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа аваагүй тохиолдолд уг баталгааг авахаар олон улсын холбоондоо шууд хандан аль болох хурдан хүсэлт гаргана. Хэрэв олон улсын холбоо (олон улсын холбоог төлөөлөхөөр зөвшилцсөн тохиолдолд үндэсний допингийн эсрэг байгууллага) тамирчны өргөдлийг хүлээн авахаас татгалзсан бол энэ тухай шалтгаанаа тамирчинд цаг алдалгүй мэдэгдэнэ.Хэрэв олон улсын холбоо тамирчны хүсэлтийг хүлээн авч баталгаа олгосон тохиолдолд тамирчин болон үндэсний допингийн эсрэг байгууллагад мэдэгдэх бөгөөд үндэсний допингийн эсрэг байгууллага уг баталгаа нь эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын шалгуурт нийцэхгүй байна гэж үзвэл түүнийг хянан хэлэлцүүлэхээр мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ДДЭА-т хандана. Үндэсний допингийн эсрэг байгууллага олон улсын холбооноос олгосон баталгааг хянан хэлэлцүүлэхээр ДДЭА-т хандсан үед уг баталгаа нь ДДЭА-аас шийдвэр гарах хүртэл олон улсын хэмжээнд тэмцээний болон тэмцээний бус үед (үндэсний хэмжээнд хүчингүй) хүчинтэй байна. Үндэсний допингийн эсрэг агентлаг ДДЭА-т хянан хэлэлцүүлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд олон улсын холбооноос олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь үндэсний хэмжээнд хянан хэлэлцэх 21 хоногийн хугацаа дуустал хүчинтэй байна.

4.4.3-ийн тайлбар: Өвчний түүх болон эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын шалгуурт заасан бусад мэдээлэл хангалтгүй байсан шалтгаанаар олон улсын холбоо нь үндэсний допингийн эсрэг байгууллагаас олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хүлээн зөвшөөрөхөөс татгалсан тохиолдолд шийдвэрийг ДДЭА хянан хэлэлцэхгүй. Харин материалыг гүйцэд бүрдүүлж олон улсын холбоонд дахин хандаж болно.

Олон улсын холбоо үндэсний зэрэглэлийн тамирчнаас шинжилгээ авахаар сонгосон тохиолдолд түүнд Үндэсний допингийн эсрэг байгууллагаас олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

4.4.4 Том тэмцээн зохион байгуулах хороо нь дараахи тохиолдлуудад тэмцээнтэй холбоотойгоор хориглосон бодис, хориглосон арга хэрэглэсэн гэж үзвэл тамирчнаас эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа шаардаж болно:

4.4.4.1 Тамирчин эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа аваагүй тохиолдолд том тэмцээний зохион байгуулах хороо нь уг баталгааг авах хүсэлт гаргах боломжийг тамирчинд бүрдүүлж өгөх шаардлагатай. Энэ тохиолдолд олгогдсон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь зөвхөн тухайн тэмцээний үед хүчинтэй.

4.4.4.2 Тамирчинд үндэсний допингийн эсрэг байгууллагаас эсвэл олон улсын холбооноос олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа нь эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын шалгуурт нийцэж байвал том тэмцээний зохион байгуулах хороо түүнийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв том тэмцээний зохион байгуулах хороо уг баталгааг шалгуурт нийцэхгүй байна гэж үзвэл түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах ба шалтгаанаа тамирчинд хурдан мэдэгдэнэ.

4.4.4.3 Том тэмцээний зохион байгуулах хороо нь тамирчинд олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд тамирчин энэ асуудлын талаар зохион байгуулах хорооноос томилсон хараат бус комисст гомдол гаргах онцгой эрхтэй. Хэрэв тамирчин гомдол гаргаагүй (гомдлыг хүлээн аваагүй) бол тухайн тэмцээний үед хориглосон бодис, аргыг хэрэглэхгүй байхыг хичээх бөгөөд тухайн бодисын хувьд үндэсний допингийн эсрэг байгууллага эсвэл олон улсын холбооноос олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх аливаа баталгаа нь тухайн тэмцээнээс бусад үед хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.4.4.3-ийн тайлбар: Спортын арбитрын шүүхийн Ad Hoc хэлтэс, тэмцээний зохион байгуулах хорооноос томилсон түүнтэй адилтгах эрх бүхий хараат бус комисс, эсвэл ДДЭА дээрхи үүргийг гүйцэтгэхээр зөвшилцөж болно. ДДЭА 4.4.6-д заасны дагуу тэмцээнтэй холбоотой олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг дурын хугацаанд хянан хэлэлцэх эрхийг (үүрэг хүлээхгүй) хадгална.

4.4.5 Допингийн эсрэг байгууллага хориотой бодис, эсвэл хориотой арга хэрэглэсэн олон улсын болон үндэсний зэрэглэлийн тамирчнаас эмчилгээний зорилгоор дээж авахаар сонгосон тохиолдолд түүнд буцаан хэрэглэгдэх боломжтой эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа хүсэх зөвшөөрөл олгоно.

4.4.6 ДДЭА тамирчин үндэсний допингийн эсрэг байгууллагаас олгосон баталгааг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тухай олон улсын холбооны шийдвэрийн талаар тамирчин эсвэл үндэсний допингийн эсрэг байгууллагаас гаргасан гомдлыг заавал хянан хэлэлцэнэ. Түүнчлэн ДДЭА олон улсын холбооноос олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааны талаар тамирчин эсвэл үндэсний допингийн эсрэг байгууллагаас гаргасан гомдлыг зайлшгүй хянан хэлэлцэнэ. ДДЭА бусад эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрлийг дурын хугацаанд олгох үед нь эсвэл олгохоос нь өмнө хянан хэлэлцэж болно. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэр нь эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын шалгуурт нийцэж байвал түүнийг ДДЭА саатуулж болохгүй. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэр нь шалгуурт нийцэхгүй бол гомдлыг буцаана.

4.4.6-ийн тайлбар: Гомдол хянан хэлэлцэгдэж, буцаагдсан тохиолдолд ДДЭА 4.4.6 болон (b)-ийн дагуу хянан хэлэлцэх үйл ажиллагаатай холбоотой гарсан бүх зардлыг нэхэмжлнэ.

4.4.7 Олон улсын холбооноос (Олон улсын холбоог төлөөлөхөөр зөвшилцсөн бол Үндэсний допингийн эсрэг байгууллага) гаргасан эмчилгээний зорилгоор чөлөөлөх тухай ДДЭА-гаар хянан хэлэлцэгдсэн, хэлэлцэгдээгүй, хянан хэлэлцэх шатанд буцаагдсан шийдвэрийн талаар тамирчин эсвэл үндэсний допингийн эсрэг байгууллага спортын арбитрын шүүхэд гомдол гаргаж болно.

4.4.7-ийн тайлбар: Энэ нь тохиолдолд давж заалдах шийдвэр нь олон улсын холбооноос гаргасан эмчилгээний зорилгоор чөлөөлөх тухай шийдвэр байна. Хянан хэлэлцэгдсэн, хянан хэлэлцэгдэж байгаа болон буцаагдсан тухай ДДЭА-ийн шийдвэрийг тооцохгүй. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийн тухай давж заалдах хугацаа нь уг шийдвэрийн талаар ДДЭА-т мэдэгдсэн үеэс эхэлнэ. Шийдвэр ДДЭА-аар хянан хэлэлцэгдсэн болон хэлэлцэгдээгүй аливаа тохиолдлуудад ДДЭА давж заалдсан гомдлын талаар мэдэгдэл хүлээн авах бөгөөд цаашдын ажиллагаанд оролцож болно.

4.4.8 Тамирчин, үндэсний допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоо эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг буцаасан тухай ДДЭА-ийн шийдвэрийн талаар спортын арбитрын шүүхэд гомдол гаргах онцгой эрхтэй.

4.4.9 Эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа гаргах, баталгааг хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөл олгосон шийдвэрийг хянан хэлэлцүүлэх зэрэгтэй холбоотой цаг хугацаандаа зохих ёсоор илгээгдээгүй өргөдөл, гомдолтой холбоотой аливаа үйлдлийн алдаа нь түүнийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

4.5 Хяналтын хөтөлбөр

ДДЭА нь Гарын үсэг зурагч бусад этгээд болон зсгийн газруудтай зөвлөлдсөний үндсэн дээр Хориглосон жагсаалтан дээр байхгүй ч спортод сөргөөр нөлөөлж болзошгүй гэсэн бодисуудыг хянах Хяналтын хөтөлбөрийг батлан гаргаж болно. ДДЭА нь тухайн бодисонд хийсэн шинжилгээний талаар дэлгэрэнгүй нийтэлнэ. Лабораториуд нь мэдээлэгдсэн хэрэглээ болон бодисын илэрцийн тохиолдлын талаар ДДЭА-д тухайн дээж

тэмцээний үеэр эсвэл тэмцээний бус үеэр авагдсанаас үл хамааран улирал тутам спортын төрөл болгоноор мэдээлнэ. Эдгээр илтгэлүүдэд тодорхой төрлийн дээжид холбогдох нэмэлт мэдээлэл агуулагдахгүй. ДДЭА нь дор хаяж жил бүр нэмэлт бодист холбогдох спортын талаархи статистик мэдээллүүдийг Олон улсын холбоод болон Үндэсний Допингийн эсрэг байгууллагуудад мэдээлнэ. Нэр бүхий спортод холбогдох тамирчдын талаархи мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг ДДЭА хүлээнэ. Хяналтанд орсон мэдээлэгдсэн хэрэглээ болон бодисын илэрц нь Допингийн зөрчил болохгүй.

5 ДУГААР БҮЛЭГ: ШИНЖИЛГЭЭ БА МӨРДӨН ШАЛГАЛТ

5.1 Шинжилгээ, мөрдөн шалгалтын зорилго

Шинжилгээ, мөрдөн шалгалт нь зөвхөн допингийн эсрэг зорилгоор ашиглагдана.

5.1.1 Шинжилгээ нь дүрмийг чанд дагаж мөрдөж буй тамирчин (дагаж мөрдөөгүй) наас хориглосон бодис, хориглосон арга илэрсэн эсэх тухай дүгнэлт гаргахад зориулагдаж хийгдэнэ.

5.1.2 Мөрдөн шалгалт нь:

- a. 2.1 ба 2.2 –ийн дагуу допингийн эсрэг дүрмийн зөрчлийг тодорхойлох явцад 7.4 болон 7.5-т заасан гаж болон шинжилгээний бус илэрцтэй холбоотой асуудал (ялангуяа шинжилгээний үр дүн) үүссэн тохиолдолд
- b. 2.2-2.10-т заасан допингийн эсрэг дүрмийн зөрчлийг шалгаж байхад допингийн эсрэг дүрэм зөрчсөнтэй холбоотой 7.6 ба 7.7-д заасан асуудал үүссэн(ялангуяа шинжилгээний бус үр дүн) тохиолдолд

5.2 Шинжилгээний хүрээ

Тамирчин бүр эрх бүхий допингийн эсрэг байгууллагад дурын цагт, дурын газар шинжилгээ өгөхөд бэлэн байх шаардлагатай.

Тэмцээний үед шинжилгээ авах үндэслэл, хязгаарыг 5.3 зүйлд тодорхойлсон.

5.2.1 Үндэсний Допингийн эсрэг байгууллага бүр тухайн улсын иргэн, оршин суугч, спортын байгууллагын гишүүн тамирчин бүрээс тэмцээний болон тэмцээний бус үед шинжилгээ авах эрхтэй.

5.2.2 Олон улсын холбоо бүр нь өөрийн дүрмийн дагуу зохион байгуулж байгаа эсвэл удирдаж байгаа тэмцээнд оролцож буй эсвэл өөрийн гишүүн, эсвэл гишүүн холбоонд харьяалагдах тамирчин бүрээс тэмцээний болон тэмцээний бус үед шинжилгээ авах эрхтэй.

5.2.3 Олон улсын Олимпийн Хороо, Олон улсын паралимпийн хороо зэрэг том наадам зохион байгуулагчид нь өөрийн тэмцээнд оролцож буй тамирчдаас тэмцээний үеийн зохион байгуулах тэмцээндээ оролцох тамирчидаас тэмцээний бус үеийн шинжилгээ авах эрхтэй.

5.2.4 ДДЭА нь 20 дугаар бүлэгт заасны дагуу тэмцээний болон тэмцээний бус үеийн шинжилгээ авах эрхтэй.

5.2.5 Допингийн эсрэг байгууллага нь зодог тайлаагүй байгаа болон эрх хасуулах шийтгэлийн хугацаа нь дуусаагүй байгаа зэрэг дурын тамирчныг эрхийнхээ дагуу шинжилгээ авахаар дуудаж болно

5.2.6 Олон улсын холбоо болон том наадам зохион байгуулах хороо нь шинжилгээ авах эрхийг допингийн эсрэг байгууллагад төлөөлүүлсэн эсвэл гэрээ байгуулсан тохиолдолд допингийн эсрэг байгууллага нь өөрийн зардлаар нэмэлт дээж авах, шууд лабораторид илгээн нэмэлт шинжилгээ хийлгэх ажлыг гүйцэтгэж болно. Нэмэлт дээж авсан, нэмэлт шинжилгээ хийлгэсэн тохиолдолд энэ тухайгаа олон улсын холбоо, том наадам зохион байгуулах хороонд мэдээлнэ.

5.2-ийн тайлбар: Шинжилгээ авах нэмэлт эрх нь гарын үсэг зурагчдын 2 талын болон олон талт гэрээгээр зохицуулагдана. Тамирчин шинжилгээ өгөх боломжтой гэж өөрөө тодрхойлсон 60 минут, тамирчин оройн 11 цагаас өглөөний 6 цагийн хооронд шинжилгээ өгөхийн өмнө гэсэн тохиолдлуудлаас бусад нөхцлийг допингийн эсрэг байгууллага допингтой холбоотой гэж сэжиглэх үндэслэл болно. Энэ сэжиг нь шинжилгээ авсан, авах оролдлогод үндэслэн дурдсан хугацаанд допингийн эсрэг дүрмийн зөрчлөөс хамгаалах үндэслэл болохгүй

5.3 Тэмцээний шинжилгээ

5.3.1 Дор дурдсанаас бусад тохиолдолд тэмцээний туршид зөвхөн нэг л байгууллага тэмцээний байранд дээр тэмцээний үеийн шинжилгээг хариуцна. Олон улсын тэмцээний үед тухайн тэмцээнийг голлон зохион байгуулагч олон улсын байгууллага дээж цуглуулах илгээх, шинжлүүлэх ажлыг хариуцна. (Тухайлбал Олимпийн наадамд Олон улсын олимпийн хороо, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд тухайн спортын олон улсын холбоо, панамерикийн наадмын үед Пан Америкийн спортын холбоо..)Үндэсний хэмжээний тэмцээнд тухайн улсын допингийн эсрэг байгууллага дээж цуглуулах, илгээх, шинжлүүлэх ажлыг хариуцна.

Тэмцээн зохион байгуулагчдын хүсэлтээр тэмцээний байрнаас гадна авах аливаа шинжилгээг тухайн байгууллага зохион байгуулна.

5.3.1-ийн тайлбар: Олон улсын тэмцээн зохион байгуулагчид тэмцээний туршид тэмцээний байрнаас гадна авах шинжилгээг Үндэсний допингийн эсрэг байгууллагаар авхуулахаар зохион байгуулдаг.

5.3.2 Шинжилгээ авах эрх бүхий боловч тэмцээний үеийн шинжилгээг авах, илгээх, шинжлүүлэх ажлыг шууд хариуцаагүй допингийн эсрэг байгууллага тэмцээний үеэр ажиллахыг хүсвэл эхлээд уг ажлыг хийх зөвшөөрөл авах тухай зөвшилцлийг тухайн тэмцээний зохион байгуулагчтай хийнэ. Допингийн эсрэг байгууллага тэмцээн зохион байгуулагч байгууллагаас хариу аваагүй тохиолдолд ДДЭА-аас баталсан журмын дагуу шинжилгээг авахад хэрхэн хамтран ажиллах талаар ДДЭА-т хүсэлт гаргана. ДДЭА тухайн

тэмцээнийг зохион байгуулагчтай зөвшилцөлгүйгээр эл асуудлаар баталгаа өгөхгүй. ДДЭА-аас гаргасан шийдвэр нь эцсийнх бөгөөд давж заалдах эрхгүй. Эрх олгосноос бусад тохиолдолд тэмцээний бус үеийн шинжилгээ авахад хэрэглэгдэнэ.

Тэмцээн зохион байгуулагч эрх олгосноос бусад тохиолдолд авсан шинжилгээний үр дүнгийн удирдлагын ажлыг Допингийн эсрэг байгууллага хариуцна.

5.3.2-ийн тайлбар: ДДЭА үндэсний допингийн эсрэг байгууллагад олон улсын тэмцээнд дээр ажиллах эрх олгохын өмнө тухайн тэмцээний зохион байгуулагч байгууллагатай зөвшилцөнө. Олон улсын холбоонд эрх олгохоос өмнө үндэсний хэмжээний тэмцээн дээр шинжилгээ авах ажлыг хийлгэх ба ДДЭА тухайн улсын үндэсний допингийн эсрэг байгууллагатай зөвшилцөж, шинжилгээ авах тэмцээн болон газрыг шийдвэрлэнэ. Бусад байгууллагатай байгуулсан гэрээгээр дээж авах эсвэл бусад допингийн хяналтын ажлыг хариуцуулахаар сонгосон тохиолдолд допингийн эсрэг байгууллага дээж авах ажлыг зохион байгуулж болно.

5.4 Шинжилгээ хийх төлөвлөгөө

5.4.1 ДДЭА олон улсын холбоо болон бусад допингийн эсрэг байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартын хүрээнд тухайн спортын төрөлд илүү их нөлөө үзүүлдэг хориотой бодис, аргын эрсдлийн үнэлгээг тооцсон техникийн баримт бичгийг батлана.

5.4.2 Шинжилгээ авах эрх бүхий допингийн эсрэг байгууллага бүр эрсдлийн үнэлгээг боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлэх ба шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн спортын төрөл, тамирчны зэрэглэл, дээж цуглуулах болон шинжилгээний төрөл, дээж шинжлэх хэлбэр зэргийн зохистой харьцааг хадгалан шинжилгээ авах төлөвлөгөө боловсруулна. Допингийн эсрэг байгууллага бүр шинжилгээ авах төлөвлөгөөнийхөө хуулбарыг ДДЭА-т илгээнэ.

5.4.3 Шинжилгээний үр нөлөөг дээшлүүлэх, шаардлагагүй шинжилгээг давтан авахаас зайлсхийх зорилгоор шинжилгээний төлөвлөгөөг ДДЭА-аас баталсан ADAMS болон бусад системээр дамжуулан хийнэ.

5.5 Шаардлага

Бүх шинжилгээг Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартын дагуу хийнэ.

5.6 Тамирчны байршлын тухай мэдээлэл

Олон улсын холбооны болон үндэсний допингийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэлийн санд багтсан тамирчин бүр Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартын дагуу байршлын тухай мэдээллээ өгнө. Олон улсын холбоо, Допингийн эсрэг байгууллага тухайн тамирчин болон байршлын мэдээллийг цуглуулах ажлыг зохицуулна. Олон улсын холбоо, допингийн эсрэг байгууллага бүр ДДЭА-аас баталсан ADAMS болон бусад системийг ашиглаж болох ба мэдээллийн санд багтах тамирчдын нэр, түүнд оруулах шалгуур тодорхой байх шаардлагатай. Тамирчныг шинжилгээний

бүртгэлийн санд оруулах, түүнээс хасахдаа тамирчинд мэдэгдэнэ.Шинжилгээний бүртгэлийн санд багтсан тамирчид нь байршлын тухай мэдээллээ ДДЭА-аас баталсан ADAMS болон бусад системээр дамжуулан ДДЭА болон 5.2-т заасан шинжилгээ авах эрх бүхий допингийн эсрэг байгууллагад ирүүлнэ.Ирүүлсэн мэдээлэл нь бүх цаг үеийн турш чанд нууцлалтай байх бөгөөд допингийн хяналтыг төлөвлөх, зохицуулах,зохион байгуулах, тамирчны биологийн паспорт болон шинжилгээний үр дүнтэй холбоотой мэдээллээр хангах,допингийн эсрэг дүрмийн бодит зөрчил болон зөрсөн байж болох сэжигийг мөрдөн шалгахад туслах зорилгоор хэрэглэгдэж,Хувийн нууц ба хувийн мэдээллийг хамгаалах олон улсын стандартын дагуу зохих зорилгоо биелүүлсний дараа хурдан устгана.

5.7 Зодог тайлсан тамирчин спортод эргэн ирэх

5.7.1 Олон улсын болон үндэсний шинжилгээний бүртгэлийн санд багтсан тамирчин зодог тайлаад спортдоо дахин эргэн ирэхийг хүсвэл олон улсын холбоо болон Үндэсний допингийн эсрэг байгууллагадаа бичгээр мэдэгдэл өгснөөс шинжилгээ өгөхөд бэлэн болох хүртлээ 6 сарын турш олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээнд оролцохыг хориглоно. Энэхүү чанд заалт нь тамирчинд хэт шудрага бус санагдсан тохиолдолд ДДЭА олон улсын холбоо болон үндэсний допингийн эсрэг байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр 6 сарын хугацаанд бичгээр баталгааа өгч болно. 13 дугаар бүлэгт заасны дагуу эл шийдвэрийг давж заалдаж болно.

5.7.1.1 5.7.1 дэхь заалтыг зөрчсөнөөр бий болсон тэмцээний үр дүнг хүчингүй болгоно.

5.7.2 Эрх хасуулсан шийтгэл нь үргэлжилж байгаа тамирчин зодог тайлаад спортдоо дахин эргэн ирэхийг хүсвэл олон улсын холбоо болон Үндэсний допингийн эсрэг байгууллагадаа бичгээр мэдэгдэл өгснөөс шинжилгээ өгөхөд бэлэн болох хүртлээ 6 сарын турш (Хэрэв 6 сараас ихгүй хугацаа үлдсэн бол зодог тайлсан өдрийн байдлаар шийтгэлийн үлдсэн хугацаатай тэнцүү) олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээнд оролцохыг хориглоно.

5.8 Мөрдөн шалгалт ба мэдээлэл цуглуулах

Допингийн эсрэг байгууллага нь Шинжилгээ,мөрдөн шалгах олон улсын стандартын дагуу дор дурдсан зүйлийг хийх нөхцлийг бүрдүүлнэ:

5.8.1 Үр ашигтай, зохих харьцаа бүхий шинжилгээний төлөвлөгөө зохиох, зорилтот шинжилгээ төлөвлөх,допингийн эсрэг дүрэм зөрчигдөх боломжийг мөрдөн шалгах зорилгоор боломжит бүх эх үүсвэрээс мэдээлэл цуглуулах, олж авах, үнэлэх,боловсруулах

5.8.2 7.4 ба 7.5 заалтын дагуу гаж илэрц болон шинжилгээний бус илэрцийг мөрдөн шалгах

5.8.3 Допингийн эсрэг зөрчлийг илрүүлэх үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор баримт цуглуулах явцад 7.6 ба 7.7 заалтын дагуу шинжилгээний ба шинжилгээний бус

аливаа бусад мэдээлэл эсвэл допингийн эсрэг дүрмийн зөрчил байж болзошгүй таамгийг мөрдөн шалгах

6 ДУГААР БҮЛЭГ: ДЭЭЖИЙГ ШИНЖЛЭХ

Дээжийг шинжлэхдээ дараахи зарчмуудыг баримтлана.

6.1 Магадлан итгэмжлэгдсэн болон батлагдсан лабораторийг ашиглах

2.1 заалтыг хангах зорилгоор Дээжийг зөвхөн ДДЭА-аас итгэмжлэгдсэн эсвэл бусад байдлаар баталгаа олгосон бусад лабораторид шинжилнэ. ДДЭА-аас итгэмжлэгдсэн эсвэл баталгаат аль лабораторид дээж шинжлүүлэхийг тухайн асуудалд үүрэг хүлээн оролцож буй Допингийн эсрэг байгууллага сонгоно.

6.1-ийн тайлбар: Зардал болон газар зүйн байршлаас шалтгаалан ДДЭА магадлан итгэмжлэлгүй лабораторид тухайлсан шинжилгээ хийх зөвшөөрөл олгож болно. Тухайлбал: Цусны шинжилгээг авсанаас заагдсан хугацаанд лабораторид хүргэх шаардлагатай байдаг. ДДЭА тухайн лабораторид зөвшөөрөл өгөхөөс өмнө стандартын шаардлагын дагуу шинжилгээ хийх, хүлээн авах өндөр түвшний боломж бүрдүүлнэ.

2.1 заалт зөрчигдсөнийг зөвхөн ДДЭА-аас итгэмжлэгдсэн буюу түүнээс тусгайлан эрх бүхий баталгаа олгосон бусад лабораторийн шинжилгээний хариуг үндэслэн тогтооно. Бусад бүлгийн зөрчсөн эсэхэд бусад лабораторийн шинжилгээний дүнг харгалзан тооцож болно.

6.2 Дээж шинжлэх зорилго

Допингийн эсрэг дээж шинжлэх үйл ажиллагааны зорилго нь Хориглосон жагсаалтанд багтсан хориглосон бодис, хориглосон аргыг илрүүлэх 4.5 заалтыг мөрдөхтэй холбогдох бусад бодисыг илрүүлэх эсвэл тамирчны шээс, цус, бусад дээжинд ДНХ, геномын өөрчлөлтүүд болон бусад байж болох үзүүлэлтүүдийг илрүүлэхэд Допингийн эсрэг байгууллагад туслахад оршино. Дээжийг цаашид шинжлэхэд зориулж авч, хадгалж болно.

6.2 тайлбар: Тухайлбал холбогдох мэдээллийг шууд зорилтот шинжилгээнд ашиглах, эсвэл 2.2 заалтын дагуу допингийн эсрэг дүрмийн зөрчлийн үйл ажиллагааг явуулах эсвэл аль алинд нь ашиглана.

6.3 Дээжийг судлах

Ямар ч дээжийг тамирчны бичгээр өгсөн зөвшөөрөлгүй судалгааны зорилгоор шинжлэхийг хориглоно. 6.2-т зааснаас бусад зорилгоор шинжилсэн дээжийг устгах ба үүнийг тухайлсан тамирчинд мэдэгдэж болохгүй.

6.3-ийн тайлбар: Ихэнхи тохиолдолд эмнэлгийн практикт нэргүй дээжийг чанарын нотолгоо, чанарыг сайжруулах, хүн амын талаар судалгаа хийхэд ашигладаг.

6.4 Дээжийг шинжлэх, түүнийг илтгэж тайлагнах стандарт

Лаборатори нь дээжийг шинжилж үр дүнг нь лабораторийн шинжилгээний Олон улсын стандартын дагуу мэдээлнэ.

Дор дурдсанаас бусад тохиолдолд шинжилгээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор 5.4.1-т заасан техникийн бичиг баримт нь тухайн спортын төрөлд зориулсан дээжийн шинжилгээний эрсдлийн үнэлгээнд суурилж бичигдэх ба лаборатори үүний дагуу шинжилгээг хийнэ:

6.4.1 Допингийн эсрэг байгууллага нь техникийн баримт бичигт дурдсанаас илүү дэлгэрэнгүй олон үзүүлэлтийг шинжлүүлэх хүсэлтийг лабораторид хандан гаргаж болно.

6.4.2 Допингийн эсрэг байгууллага нь улсынхаа болон спортынхоо тусгай шалтгаан, шинжилгээний төлөвлөгөөнөөс шалтгаалан ДДЭА зөвшөөрсөн тохиолдолд техникийн бичиг баримтанд зааснаас бага үзүүлэлтийг шинжлүүлэх тухай хүсэлтийг лабораторид гаргаж болно.

6.4.3 Лаборатори нь лабораторийн олон улсын стандартын дагуу дээж шинжлэх техникийн бичиг баримтанд заагаагүй хориглосон бодис, хориглосон арга эсвэл шинжилгээ авах хүсэлтээр шинжилгээ хийж болох бөгөөд гарсан зардлыг өөрсдөө хариуцна. Тухайн шинжилгээний үр дүнг зарлах бөгөөд энэ нь бусад шинжилгээний үр дүнтэй ижил хүчинтэй, үр дагавартай байна.

6.4-ийн тайлбар: Энэ зүйлийн зорилго нь дээжийн шинжилгээг үр дүнтэй допинг илрүүлэлтийг үр ашигтай болгох зорилгоор ухаалаг шинжилгээний зарчмыг өргөтгөхөд оршино. Допингтой тэмцэх боломжит нөөц хязгаарлагдмал болон хүлээн зөвшөөрөх, зарим спорт болон улсад авах дээжийн тоог нэмэх, шинжлэгдэх боломжтой дээжийн тоог хасахыг хүлээн зөвшөөрнө.

6.5 Дээжийг цаашид шинжлэх

2.1 бүлэгт заасан допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн эсэхийг үндэслэх зорилгоор аливаа дээжийг цаашид шинжилж болох бөгөөд үр дүнгийн удирдлагыг хариуцаж байгаа допингийн эсрэг байгууллага А болон Б сорьцийг шинжлүүлэхийн өмнө тамирчинтай мэдэгдэнэ.

Допингийн Эсрэг Байгууллага эсвэл ДДЭА аас өгсөн чиглэлийн дагуу дахин авсан дээжийг 6.2 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дахин шинжилж болно. Дээж дахин шинжлэх шалтгаан ба нөхцөл нь Лабораторийн болон Шинжилгээ мөрдөн шалгалтын олон улсын стандартын шаардлагад нийцсэн байна.

7 ДУГААР БҮЛЭГ: ҮР ДҮНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Үр дүнгийн зохицуулалт хийж буй Допингийн эсрэг байгууллага бүр дараахь зарчмуудад нийцүүлэн Допингийн эсрэг журмын бодит зөрчлийн тухай урьдчилан хянан хэлэлцэх ажиллагаа явуулна.

7 дугаар зүйлийн тайлбар: Гарын үсэг зурагч этгээд бүр сөрөг аналитик илэрцийн үр дүнгийн зохицуулалтын талаар өөр өөрийн хандлагыг баримталж байна. Хэдийгээр тэдгээр хандлагууд нь жигд бус ч гэсэн тэдгээрийн олонхи нь үр дүнгийн зохицуулалтыг үр дүнтэй болгодог гэдэг нь нотлогдсоор байна. Энэхүү дүрэмд тухайн Гарын үсэг зурагч этгээдүүдийн үр дүнгийн зохицуулалтын систем бүрийг тусгаагүй. Гэхдээ энэ зүйлээр үр дүнгийн зохицуулалтыг шударга байлгахтай холбоотой тулгуур зарчмуудыг тодорхойлж өгсөн. Гарын үсэг зурагч этгээдүүдийн Допингийн эсрэг дүрмүүд нь эдгээр зарчмуудтай нийцэж байх ёстой. Допингийн эсрэг байгууллагын эхлүүлсэн допингийн эсрэг бүх хэрэгт шүүх ажиллагаа явуулах шаардлагагүй. Үүнд: тамирчин болон бусад этгээд дүрмийн хүрээнд олгогдох шийтгэлийг зөвшөөрсөн эсвэл допингийн эсрэг байгууллага уян хатан шийтгэл оноохоор шийдвэрлэсэн зэрэг тохиолдлууд багтана. Хүлээн зөвшөөрсний үндсэн дээр олгогдсон шийтгэлийн бүх тохиолдлуудад 13.2.3, 14.2.2-т заасан давж заалдах эрх талуудад хадгалагдах ба 14.3.2-т зааснаар зарлан мэдээлэгдэнэ.

7.1 Үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах хариуцлага

7.1.1 ба 7.1.2 т зааснаас бусад тохиолдолд дээж цуглуулсан допингийн эсрэг байгууллагын (Дээж цуглуулахад оролцоогүй боловч допингийн эсрэг дүрэм зөрчсөн, допингийн эсрэг дүрэм зөрчсөнөө зөвшөөрсөн тамирчин болон бусад этгээдэд анхны мэдэгдлийг өгсөн допингийн эсрэг байгууллага) дүрмийн дагуу үр дүнгийн удирдлага болон хянан хэлэлцэх үйл ажиллагааны хариуцлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ. Уг байгууллагуудын зохион байгуулсан энэ бүлэг болон 8 дугаар бүлэг, 23.2.2-т заасны дагуу үр дүнгийн удирдлага болон хянан хэлэлцэх үйл ажиллагааг өөрчлөлт оруулалгүйгээр дагаж мөрдөнө. Допингийн эсрэг байгууллага болон үр дүнгийн удирдлагыг хариуцсан допингийн эсрэг байгууллагын хооронд маргаан үүсвэл ДДЭА маргааныг таслах ба маргааны талаар гаргасан ДДЭА-ийн шийдвэрийг аль допингийн эсрэг байгууллага шийдвэр гарсан талаар мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор спортын арбитрын шүүхэд давж заалдаж болно. Давж заалдсан тухай гомдол нь спортын арбитрын шүүх хүлээн авч шүүгч томилохоос өмнө саадгүйгээр хянан үзнэ.

5.2.6 зүйлд заасны дагуу допингийн эсрэг байгууллага нэмэлт дээж авахаар сонгодсон тохиолдолд тухайн байгууллага дээж авах, илгээх, шинжлүүлэх ажлыг зохион байгуулна. Допингийн эсрэг байгууллага зөвхөн лабораторид нэмэлт дээжийг өөрийн зардлаар хийх болсон тохиолдолд олон улсын холбоо, том тэмцээн зохион байгуулах хороо нь дээж цуглуулах, илгээх Допингийн эсрэг байгууллагыг сонгоно.

7.1-ийн тайлбар: Зарим тохиолдолд допингийн эсрэг байгууллага дүрмийн дауу дээж цугдуулах, илгээх, шинжлүүлэх ажлыг хийх ба үр дүнгийн удирдлагыг өөр байгууллага хариуцдаг.(үндэсний холбоо гэх мэт) Энэ тохиолдолд дүрэмтэй нийцүүлэн тухайн байгууллагын журмаар допингийн эсрэг байгууллагын хүлээх хариуцлагыг баталгаажуулах шаардлагатай.

7.1.1 Тухайн үндэсний допингийн эсрэг байгууллагад тухайн улсын иргэн бус, оршин суугч бус, спортын байгууллагын гишүүн бус тамирчнаас дээж авах эрх олгоогүй, үндэсний допингийн эсрэг байгууллага нь эл эрхийг хүлээн авахаас татгалзсан бол үр дүнгийн удирдлагыг олон улсын холбоо эсвэл олон улсын холбооны дүрмийн дагуу томилогдсон гуравдагч этгээд гүйцэтгэнэ.

ДДЭА –аас авсан шинжилгээ болон илэрсэн допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотой үр дүнгийн удирдлага, хянан хэлэлцэх үйл ажиллагааг ДДЭА-аас томилсон допингийн эсрэг байгууллага гүйцэтгэнэ. Олон улсын олимпийн хороо, олон улсын паралимпийн хороо болон бусад том тэмцээн зохион байгуулагчдын авсан шинжилгээ, илрүүлсэн допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотой үр дүнгийн удирдлага, хянан хэлэлцэх ажлыг тэмцээнээс хасах, үр дүн, оноог хүчингүй болгох, медаль шагналыг хураах допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотой зардлыг төлүүлэх зэрэг үр дагавартай холбогдуулан олон улсын холбоо гүйцэтгэнэ.

7.1.1 –ийн тайлбар: Тухайн тамирчны болон бусад этгээдийн харьяалагдах олон улсын холбоо нь үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах допингийн эсрэг байгууллага байхгүй байх эрсдлээс сэргийлж өөрөө допингийн эсрэг байгууллага байгуулж болно. Олон улсын холбоо нь өөрийн допингийн эсрэг дүрмийг тухайн тамирчин болон бусад этгээдийн харьяалах үндэсний допингийн эсрэг байгууллагад хүргэнэ.

7.1.2 Байршлын тухай мэдээлэлтэй (мэдээллээ өгөхгүй байх эсвэл шинжилгээ өгөөгүй байх) холбоотой үр дүнгийн удирдлагыг олон улсын холбоо эсвэл шинжилгээ, мөрдөн шалгах олон улсын стандартын дагуу тухайн тамирчны байршлын тухай мэдээлэл цуглуулж буй үндэсний допингийн эсрэг байгууллага гүйцэтгэнэ. Допингийн эсрэг байгууллага мэдээллээ өгөөгүй болон шинжилгээ өгөөгүй тухай мэдээллийг ДДЭА-аас баталсан ADAMS болон бусад системээр дамжуулан мэдээнэ. Эдгээр нь бусад холбогдох допингийн эсрэг байгууллагад өгөх боломжтойгоор хийгдэнэ.

7.2 Сөрөг аналитик илэрцэд хийх хяналт

А сорьцоос сөрөг аналитик илэрц гарсны дараа Допингийн эсрэг байгууллага үр дүнгийн зохицуулалтын талаар тодорхой үүрэг хүлээх бөгөөд дараахь асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд: (а) эмчилгээний зориулалтаар хэрэглэгдэхүйц эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгогдсон эсэх, (б) эсвэл Сөрөг аналитик илэрцийн үр дүнг хүчингүй болгоход хэрэглэгдэх үндэслэл. Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандарт болон лабораторийн шинжилгээнд буй зэргийг тус тус тогтооно.

7.3 Хяналтын дараа хийх мэдэгдэл

Хэрэв 7.2 заалтын дагуу хийгдсэн эхний хяналтаар эмчилгээний зориулалтаар хэрэглэгдэхүйц эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгогдоогүй буюу Сөрөг аналитик илэрцийн үр дүнг хүчингүй болгох үндэслэл илэрсэн үед, Допингийн эсрэг байгууллага дараахь зүйлийг 14.1.1, 14.1.2 болон өөрийн дүрмэнд заасны дагуу Тамирчинд нэн даруй мэдэгдэнэ. Үүнд: (а) Сөрөг аналитик илэрцийн тухай, (б) Допингийн эсрэг журам зөрчигдсөн тухай (с) Б сорьцийг шинжлүүлэх талаар тамирчин хүсэлт гаргах эрхтэй эсвэл тухайн В сорьцийн шинжилгээг дахин шинжлэх шаардлагатай тул энэ талаар тамирчин

хүсэлт гаргах боломжгүй болсон тухай, (d) Хэрэв тамирчин эсвэл Допингийн эсрэг байгууллага Б сорьцийг шинжлүүлэх талаар хүсэлт гаргасан тохиолдолд шинжилгээ хийх хуваарьт өдөр,цаг газрын тухай (e) Хэрэв уг хүсэлтийг гаргасан бол тамирчин эсвэл тамирчны төлөөлөгч лабораторийн Олон улсын стандартад тусгайлан заасан хугацаанд Б сорьцийг нээх, шинжлэх үйл ажиллагаанд оролцох боломжтой тухай (f) Тамирчин лабораторийн олон улсын стандартын дагуу шаардагдах мэдээлэл бүхий лабораторийн А болон Б сорьцтой холбоотой баримт бичгийн хуулбарыг гаргуулан авах эрхтэй эсэх тухай асуудал тус тус орно. Хэрэв Допингийн эсрэг байгууллага илэрсэн сөрөг илэрц нь допингийн эсрэг дүрмийн зөрчил биш гэж үзвэл энэ тухайгаа тамирчин болон 14.1.2-т заасан допингийн эсрэг байгууллагад мэдээлнэ.

Тамирчин допингийн эсрэг дүрмийг зөрчсөн тухай мэдэгдэл хүлээн авсан бүх тохиолдолд 7.9.1-т заасан түр түтгэлзүүлэх эрхийн дагуу үр дүнг тооцохгүй бөгөөд тамирчинд шийдвэр гарах хүртэл түр түтгэлзүүлэлтийг хүлээн зөвшөөрөх боломжийг олгоно.

7.4 Гаж илэрцэд хийх хяналт

Лаборатори нь олон улсын лабораторийн стандартын дагуу зарим шалтгааны улмаас бие дотор нийлэгждэг бөгөөд Гаж илэрц гэж нэрлэгддэг цаашид дахин судлах шаардлагатай хориотой бодис илэрсэн талаар мэдээлдэг. Допингийн эсрэг байгууллага гаж илэрц бүхий хариуг авмагц үр дүнгийн зохицуулалтыг хийхийн тулд дараахи зүйлийг хянан тодруулах үүрэгтэй. Үүнд: (a) эмчилгээний зориулалтаар хэрэглэгдэхүйц эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгогдсон эсвэл эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын дагуу олгогдох гэж байгаа эсэх, (b) эсвэл Сөрөг аналитик илэрцийн үр дүнг хүчингүй болгоход хэрэглэгдэх үндэслэл. Шинжилгээ,мөрдөн шалгалтын олон улсын стандарт болон лабораторийн шинжилгээнд буй зэргийг тус тус тогтооно. Хэрэв зохих зөвшөөрөл, үндэслэл тогтоогдоогүй бол допингийн эсрэг байгууллага цааш шаардлагатай судалгааг хийнэ.Судалгаа дууссаны дараа гаж эсэхээс үл хамааран мөрөг илэрц гарсан тухай тамирчин болон 14.1.2-т заасан допингийн эсрэг байгууллагад мэдээлнэ. Тамирчныг 7.3 –т заасан мэдээллээр хангана.

7.4-ийн тайлбар: Энэ бүлэгт тодорхойлсон “шаардлагатай мөрдөн шалгалт” нь нөхцөл байдлаас хамаарна. Тухайлбал тамирчны биед нийлэгждэг тестостерон/эпитестостероны харьцаа, уг гаж илэрц нь мөрдөн шалгалт эхлэхээс өмнө батлагдсан тохиолдол...

7.4.1Допингийн эсрэг байгууллага дараахи шалтгаануудын аль нэгээс бусад тохиолдолд судалгаа дуусч, шийдвэрлэгдэх хүртэл гаж илэрцийг сөрөг аналитик илэрц гэж мэдээлж болохгүй. Үүнд:

(a) Хэрэв допингийн эсрэг байгууллага 7.4-т заасан судалгаагаар Б сорьцийг зохих ёсоор шинжлэнэ гэсэн дүгнэлт гаргасан бол тамирчинд гаж илэрцийн тухай болон 7.3 (d-f) –т тодорхойлсон мэдээллүүдийг өгсний дараа Б сорьцийг шинжлүүлэх ажлыг зохион байгуулна.

(b) Хэрэв Допингийн эсрэг байгууллага аль нэг олон улсын тэмцээний өмнө тамирчид дотор нь гаж илэрц гарсан этгээд байгаа эсэхийг мэдэхийг хүссэн тухай Олон улсын тэмцээний зохион байгуулах хороо эсвэл Олон улсын тэмцээнд оролцох багаа сонгох гэж байгаа спортын байгууллагаас хүсэлт хүлээн авсан бол гаж илэрцийн талаархи эхний

мэдээллийг тамирчинд өгсний дараа тэмцээний зохион байгуулах хороо, спортын байгууллагуудад тодорхойлолт гаргаж өгнө.

7.4.1(b) тайлбар: 7.4.1(b)-д тодорхойлогдсон шалтгааны улмаас авах арга хэмжээний хувилбарууд нь Тэмцээний зохион байгуулах хороо эсвэл спортын байгууллагын дүрмээр зохицуулагдана.

7.5 Паспортын гаж илэрц болон паспортын илэрцийн хяналт

Паспортын гаж илэрц болон паспортын илэрцийн хяналтыг шинжилгээ болон мөрдөн шалгалтын болон лабораторийн олон улсын дагуу хийнэ. Допингийн эсрэг байгууллага хяналтыг допингийн эсрэг дүрмийн зөрчил, зөрчил гаргасан үндэслэлд тулгуурлан дүрмийн дагуу хийх ба допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн тухай тамирчин яаралтай мэдэгдэнэ. 14.1.2-т заасны дагуу бусад допингийн эсрэг байгууллагад мэдээлнэ.

7.6 Байршлын тухай мэдээллийн алдааны хяналт

Байршлын тухай мэдээлэл болон шинжилгээ өгөөгүй байх алдааны хяналтыг Шинжилгээ, мөрдөн шалгах стандартын дагуу хийнэ. Олон улсын холбоо эсвэл Үндэсний Допингийн эсрэг байгууллага 2.4 заалт зөрчигдсөнийг шалгалтаар нотлох ба 2.4-т заасан допингийн эсрэг дүрмийг зөрчсөн тухай тамирчинд яаралтай мэдэгдэнэ. 14.1.2-т заасны дагуу допингийн эсрэг бусад байгууллагад мэдэгдэнэ.

7.7. Допингийн эсрэг дүрмийн 7.1-7.6 –т хамаарахгүй бусад зөрчлийг хянах

Энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан Допингийн эсрэг бодлого, эсвэл Допингийн эсрэг байгууллага өөр бусад байдлаар тохиромжтой гэж үзсэн тохиолдолд Допингийн эсрэг байгууллага болон түүнээс байгуулсан хянан шалгах эрх бүхий байгууллагууд нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно. Допингийн эсрэг байгууллагаас тухайн тамирчин, эсвэл шийтгэл хүлээх бусад этгээдүүдэд зөрчигдсөн гэх Допингийн эсрэг журам болон түүний үндэслэлийн талаар мэдэгдэнэ. Бусад допингийн эсрэг байгууллагуудад 14.1.2-т заасны дагуу мэдэгдэнэ.

7.1, 7.6, 7.7-ийн тайлбар: Тухайлбал олон улсын холбоо нь ердийн нөхцөлд тамирчны харьяалагдах үндэсний холбоогоор нь дамжуулж тамирчинд мэдэгддэг.

7.8 Өмнөх допингийн эсрэг дүрмийн зөрчлийн тодорхойлолт

Допингийн эсрэг байгууллага нь дээр дурдсаны дагуу допингийн эсрэг дүрмийг зөрчсөнийг баталсныхаа дараа тамирчинд мэдэгдэхээс өмнө ДДЭА-аас баталсан ADAMS болон бусад системээр дамжуулан ДДЭА болон бусад холбогдох допингийн эсрэг байгууллагаас өмнөх допингийн эсрэг дүрмийн зөрчлийн талаар лавлагаа авна.

7.9 Түр түдгэлзүүлэлтэд хэрэглэгдэх зарчмууд

7.9.1 Сөрөг аналитик илэрц гарсны дараа түр түдгэлзүүлэх эрх

Тэмцээн голлон зохион байгуулагч, баг сонгох үүрэг бүхий этгээд, холбогдох олон улсын холбоо, попингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотойгоор үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах эрх бүхий бусад допингийн эсрэг байгууллага гэсэн гарын үсэг зурагчид нь тусгайлсан бодисоос бусад хориотой бодис, хориотой арга илэрсэн тухай мэгдэл хүлээн авсан тохиолдолд ашиглах дүрмийг батлах ба түр түдгэлзүүлэлтийг 7.2, 7.3, 7.5-т заасан хяналт, мэдэгдлийг хийсний дараа даруй оногдуулна. Тамирчин хэрэг хянан хэлэлцэх үед бохирдсон бүтээгдэхүүнээс шалтгаалан дүрмийг зөрчихөд хүрсэн гэдгээ нотолж чадвал эрхийн дагуу оногдох түр түдгэлзүүлэлтийг хүчингүй болгож болно. Бохирдсон бүтээгдэхүүнээс шалтгаалан зөрчил гаргасан тухай тамирчны баталгааг үндэслэн түр түдгэлзүүлэлтийг хүчингүй болгохгүй гэсэн хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний шийдвэрийг давж заалдах боломжгүй.

Гэвч тамирчин дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулж болохгүй. Үүнд: (a) түр зуурын түдгэлзүүлэлтийн өмнө, эсвэл цаг хугацааны үндэслэл дээр түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулсны дараа Түр зуурын хянан хэлэлцэх ажиллагаа явуулах боломж олгогдсон, (b) цаг хугацааны хамаарлаас болж түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулсны дараа 8 дугаар зүйлд заасны дагуу нэн даруй хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх олгогдсон зэрэг асуудал орно.

7.9.2 Түр түдгэлзүүлэлтийг тусгайлсан бодис, бохирдсон бүтээгдэхүүнд сөрөг аналитик илэрц гарах эсвэл допингийн эсрэг дүрмийн бусад зөрчлийн үед оноох

Гарын үсэг зурагч этгээд нь өөрөө эрх мэдлийнхээ хүрээнд зохион байгуулах арга хэмжээ, эсвэл мөн өөрөө тодорхой үүрэг хүлээдэг багийг сонгох ажиллагааг хариуцдаг байх эсвэл гарын үсэг зурагч нь олон улсын холбоо байх эсвэл үр дүнг зохицуулах эрхтэй байх, допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн сэжиг гарах эсвэл допингийн эсрэг дүрмийн зөрчилд түр түдгэлзүүлэх зөвшөөрөл олгох тухай журам батлана Түр түдгэлзүүлэлт нь тамирчныг В сорьц шинжлүүлэхээс эсвэл 8 дугаар бүлэг -т заасан шүүхийн эцсийн хуралдаан болох хүртэл байна.

Гэвч тамирчин дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулж болохгүй. Үүнд: (a) түр зуурын түдгэлзүүлэлтийн өмнө, эсвэл цаг хугацааны үндэслэл дээр түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулсны дараа Түр зуурын хянан хэлэлцэх ажиллагаа явуулах боломж олгогдсон, (b) цаг хугацааны хамаарлаас болж түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулсны дараа 8 дугаар зүйлд заасны дагуу нэн даруй хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх олгогдсон зэрэг асуудал орно.

Хэрэв түр зуурын түдгэлзүүлэлт нь А сорьцийн Сөрөг аналитик илэрц дээр үндэслэгдэн оноогдсон боловч Б сорьцийн (Тамирчин эсвэл том наадам зохион байгуулагч эсвэл олон улсын холбоо хүсэлт гаргасан үед) шинжилгээ түүнийг батлаагүй тохиолдолд 2.1 заалтийг зөрчсөн гэж үзэн түдгэлзүүлэлтийг үргэлжлүүлж болохгүй. Тамирчин болон тухайн

тамирчны баг 2.1 дэхь заалтын зөрчлөөс шалтгаалан тэмцээнээс хасагдсан боловч Б сорьцийн шинжилгээ А сорьцийн шинжилгээг баталаагүй, энэ нь тэмцээнд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй бол тамирчин болон түүний баг тэмцээнд эргэн орох ба үргэлжлүүлж болно.

7.9-ийн тайлбар: Допингийн эсрэг байгууллага түр түтгэлзүүлэлтийг дангаар оноохын өмнө эхлээд дүрмэнд заасан дотоод хяналтыг хийж дуусгана. Гарын үсэг зурагч түр түтгэлзүүлэлт оноосон хэдий ч түр түтгэлзүүлэхээс өмнө эсвэл түр түтгэлзүүлэлт оноосны дараа даруй түр түтгэлзүүлэлтийг хянан хэлэлцэх эсвэл түр түтгэлзүүлэлт оноосны дараа даруй эцсийн хурдасгасан хянан хэлэлцэх ажиллагаа явуулах боломжоор тамирчныг хангана. Тамирчин 13.2.3 заалтын дагуу давж заалдаж болно.

В дээжийн шинжилгээ А дээжийн шинжилгээний хариуг батлахгүй байх онцгой шалтгаан гарсан үед түр түтгэлзүүлсэн тамирчныг уг шалтгаанаар наадмын үеэр дараагийн тэмцээндээ орохыг зөвшөөрнө. Үүнтэй адилаар багийн спортод олон улсын холбооны дүрмээс хамаарч баг нь тэмцээнээ үргэлжлүүлж байгаа бол тамирчин багийнхаа дараагийн тэмцээнүүдэд оролцож болно.

Тамирчин 10.11.3, 10.11.4-т зааснаар эцсийн байдлаар оноогдсон эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн эрх хасах шийтгэлийн ямар хугацаанаас бусад тохиолдолд түр түтгэлзүүлэлтийн мэдэгдэл хүлээн авна.

7.10 Үр дүнгийн удирдлагын шийдвэрийг мэдэгдэх

Допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрэм зөрчигдсөнийг баталсан, баталгааг хүчингүй болгосон, түр түтгэлзүүлэлт оноосон, тамирчин, бусад этгээд хэрэг хянан шийдвэрлүүлэхгүйгээр оноосон шийтгэлийг зөвшөөрсөн зэрэг бүх тохиолдолд допингийн эсрэг байгууллага 14.2.1-т заасны дагуу 13.2.3-т заасны дагуу давж заалдах эрх бүхий бусад допингийн эсрэг байгууллагад мэдэгдэнэ.

7.11 Спортоос зодог тайлах

Хэрэв тамирчин эсвэл бусад этгээд үр дүнгийн зохицуулалтын үйл ажиллагаа үргэлжилж байх үед зодог тайлсан бол Допингийн эсрэг байгууллага үр дүнгийн зохицуулалтын үйл ажиллагааг дуусгах эрхтэй. Хэрэв тамирчин болон бусад этгээд үр дүнгийн зохицуулалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө зодог тайлбал Допингийн эсрэг байгууллага тамирчин болон бусад этгээдийн дүрмийг зөрчсөн цаг хугацаанд хамааруулан үр дүнгийн зохицуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах эрхтэй.

7.11-ийн тайлбар: Ямар нэг допингийн эсрэг байгууллагын эрх мэдлээ хэрэгжүүлэхээс өмнөх тамирчин болон бусад этгээдий шийдвэр нь допингийн эсрэг дүрмийн зөрчил гэж тооцогдохгүй харин тэдний спортын байгууллагын гишүүнчлэлээсээ татгалзах хуулийн үндэслэл болж болно.

8 ДУГААР БҮЛЭГ: ХЭРГИЙГ ШУДАРГААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ БОЛОН ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ ЭРХ

8.1 Шударгаар хянан хэлэлцэх

Үр дүнгийн зохицуулалтын талаар үүрэг хүлээсэн Допингийн эсрэг байгууллага бүр Допингийн эсрэг журам зөрчсөн гэм буруутайд тооцогдож буй этгээдийн хэргийг шударгаар, цаг алдалгүй ялгаварлалгүйгээр хянан хэлэлцэнэ. Эрх хасах хугацааны шалгааныг тайлбарыг багтаасан ца хугаанаас шалтгаалан гарсан шийдвэрийг 14.3-т заасны дагуу нийгэд зарлан мэдээлнэ.

8.1-ийн тайлбар: Энэ бүлэг нь үр дүнгийн удирдлагын ажиллагааны явцад тамирчин болон бусад этгээдээс хэргийг цаг хугацаанд нь шударга, ялгаварлалгүйгээр хянан хэлэлцэх боломжоор хангахыг шаардана. Эдгээр зарчмууд нь хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай тунхаглалын 6.1-т дурдагдсан ба олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн. Энэ бүлэг нь допингийн эсрэг байгууллага бүрийн хянан хэлэлцэх дотоод дүрмийг хавчин шахах зорилгогүй харин тэднийг хянан хэлэлцэх үйл ажиллагаандаа уг зарчмыг хэрэглэхийг баталгаажуулна.

8.2 Хянан шийдвэрлэх үйл ажиллагаа

Допингийн эсрэг байгууллага, мөн хянан хэлэлцүүлэг явуулж буй эрх бүхий байгууллагын холбогдох журмаар зөвшөөрөгдсөн тохиодолд тодорхой үйл явдалтай холбогдон явуулах хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулж болно.

8.2-ийн тайлбар: Жишээ нь: Тамирчныг тэмцээнд оролцуулж болох эсэхийг тодорхойлох, эсвэл зөрчил нь тэмцээний үеэр тамирчны үзүүлсэн амжилт хүчинтэй байхад нөлөөлөх эсэх, тэмцээнээ үргэлжлүүлж болох эсэхийг тогтоохын тулд том тэмцээний үеэр хянан хэлэлцэх үйл ажиллагааг түргэвчилсэн байдлаар хийж болно.

8.3 Хянан шийдвэрлэх ажиллагааг цуцлах

Тамирчины алдаа илэрхий байх, Допингийн эсрэг байгууллага журмандаа тусгайлсан заасан цаг хугацаанд допингийн эсрэг дүрэм зөрчсөн талаархи мэдэгдлийг хүлээн авахаас татгалзвал хянан хэлэлцэх үйл ажиллагааг хийхээс татгалзаж болно.

8.4 Шийдвэрийг мэдээлэх

Үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах үүрэг бүхий Допингийн эсрэг байгууллага хэргийг хянан хэлэлцээд гарсан шийдвэр, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа цуцлагдсан бол түүний шалтгаан, авсан арга хэмжээний талаархи тайлбарыг тамирчин болон 13.2.3-т заасны дагуу давж заалдах эрх бүхий бусад допингийн эсрэг байгууллагад 14.2.1-т заасны дагуу мэдээлнэ.

8.5 Спортын арбитрын шүүхээс өмнө нэг удаа хянан хэлэлцэх

Олон улсын болон үндэсний зэрэглэлийн тамирчин допингийн эсрэг дүрмийг зөрчсөн нь батлагдсан тохиолдолд тамирчин, үр дүнгийн удирдлагыг хариуцаж буй допингийн эсрэг байгууллага, ДДЭА, эхний хэрэг хянан шийдвэрлэсэн тухай шийдвэрийг спортын арбитрын шүүхэд давж заалдах эрх бүхий допингийн эсрэг байгууллага харилцан зөвшилцсөний үндсэн дээр өмнө нь хянан хэлэлцэх шаардлагагүйгээр шууд спортын арбитрын шүүхэд шууд шилжүүлж болно.

8.5-ийн тайлбар: Зарим тохиолдолд олон улсын болон үндэсний хэмжээнд спортын арбитрын шүүхээс өмнө хэрэг хянан болон дахин хэлэлцэхэд гарах зардал чухал байдаг. Энэ бүлэгт тодорхойлсон талууд бүгд нэг л удаа хэргийг хянан хэлэлцүүлэх сохирхолтой байвал тамирчин, допингийн эсрэг байгууллага 2 удаагийн хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд нэмэлт зардал гаргах шаардлагагүй болно. Допингийн эсрэг байгууллага спортын арбитрын шүүхийн хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд талын хувиар эсвэл ажиглагчаар оролцох хүсэлтэй бол энэ тухай эрхийг баталгаажуулсан хянан хэлэлцэх ажиллагааны шийдвэрийг шаардаж болно.

9 ДҮГЭЭР БҮЛЭГ: ХУВИЙН ҮР ДҮНГ ТООЦОХГҮЙ БАЙХ

Ганцаарчилсан спортын тэмцээний үеэр авсан шинжилгээнд допингийн эсрэг дүрмийн зөрчил илэрсэн бол медаль, шагналыг хураах, оноо хүчингүй болох зэрэг тухайн тэмцээнд үзүүлсэн бүх үр дүнг хүчингүй болгоно.

9 дүгээр зүйлийн тайлбар: Багийн спортын хувьд багийн гишүүний авсан аливаа шагналыг хүчингүй болгоно. Харин багийг хасахыг 11 дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ. Ганцаарчилсан спортын багийн төрөлд шагнал авсан багийн нэг юмуу хэд хэдэн гишүүн допингийн эсрэг дүрмийг зөрчсөн бол олон улсын спортын холбооны дүрмийн дагуу шийтгэлийг багт нь ногдуулна.

10 ДУГААР БҮЛЭГ: ХУВИЙН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ

10.1 Допингийн эсрэг журмыг зөрчих үед гарсан үр дүнг тооцохгүй байх

Допингийн эсрэг журмыг тэмцээний үеэр зөрчсөн, эсвэл тэмцээнтэй холбогдон зөрчил гаргасан тохиолдолд тухайн үйл ажиллагааг зохион явуулж буй эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн 10 дугаар зүйлийн 1-ийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайн тамирчны хүртсэн медаль, авсан оноо болон шагналыг хураах зэргээр тухайн тэмцээний эцсийн үр дагаварт тамирчны хүрсэн бүх үр дүнг тооцохгүй буюу хүчингүй болгоно.

Бусад үр дүнг тооцохгүй байхад харгалзан үзэх хүчин зүйл гэдэгт тухайн тамирчны гаргасан Допингийн эсрэг журмын зөрчлийн ноцтой эсэх, мөн тамирчны өөр тэмцээнд оролцохдоо өгсөн шинжилгээ сөрөг гарсан зэргийг оруулна.

10.1-ийн тайлбар: 9 дүгээр зүйл (Хувийн үр дүнг тооцохгүй байх)-ийн дагуу хийсэн шинжилгээний дүн нэмэх гарсан тохиолдолд тухайн тамирчны спортын ганцаарчилсан төрөл (100 метрийн араар даллах сэлэлт гэх мэт)-д хүрсэн үр дүнг тооцохгүй буюу хүчингүй болгох бол энэ зүйлээр тамирчны тухайн уралдааны үеэр хүрсэн бүх үр дүнг хүчингүй болгоно (Усан спортын Олон улсын холбооны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн гэх мэт).

10.1.1 Хэрэв Тамирчин тухайн Допингийн эсрэг журмын зөрчилд санаатай, эсвэл хайхрамжгүй зэрэг ямар нэгэн байдлаар буруугүй гэдгээ нотолсон бол тухайн тамирчны Допингийн эсрэг журам зөрчсөн гэх тэмцээнээс бусад тэмцээнд тамирчны үзүүлсэн амжилт нь түүний зөрчсөн Допингийн эсрэг журманд нөлөөлөхөөс бусад тохиолдолд бусад тэмцээнд тамирчны үзүүлсэн амжилтыг хэвээр хадгална.

10.2 Хориглосон бодис болон Хориглосон арга илрэх, хэрэглэх, хэрэглэхийг оролдох, эзэмшсэний төлөө эрхийг нь хасах

2.1, 2.2, 2.6 заалтын зөрчлийн хувьд эрх хасах хугацааг дор дурдсанаар тогтоох ба хугацааг хөнгөрүүлэх болон түр түтгэлзүүлэх үед 10.4, 10.5, 10.6 заалтыг баримтална.

10.2.1 Дараахи тохиолдлуудад дөрвөн жилээр эрхийг хасна:

10.2.1.1 Тамирчин болон бусад этгээд допингийн эсрэг дүрэм зөрчсөн нь санаатай үйлдэл бус гэдгийг нотолсноос бусад тохиолдолд допингийн эсрэг дүрмийн зөрчил нь тусгайлсан бодис ангилалд хамаарахгүй бол

10.2.1.2 Допингийн эсрэг дүрмийн зөрчил нь тусгайлсан бодис ангилалд хамаарсан ч допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрмийн зөрчил нь санаатай үйлдэл гэдгийг нотолсон

10.2.2 10.2.1-т зааснаас бусад тохиолдолд эрх хасах хугацаа хоёр жил байна:

10.2.3 10.2, 10.3 зүйлд хэрэглэж байгаа “санаатай” гэдэг нэр томъёог тамирчин хууран мэхэлсэн гэж ойлгоно. Уг нэр томъёонд мэдсэн хирнээ допингийн эсрэг дүрмийг зөрчсөн эсвэл допингийн эсрэг дүрмийг зөрчихөд гарах үр дүн, эрсдлийг мэдэж байсан болон илтэд үл тоосон тамирчин, бусад этгээдийг хамруулан ойлгоно.

Зөвхөн тэмцээний үед хэрэглэхийг хориглосон бодис илэрснээс шалтгаалсан допингийн эсрэг дүрмийн зөрчлийг тухайн бодис нь тусгайлсан бодист хамаарсан, тамирчин уг хориглосон бодисыг тэмцээний бус үед хэрэглэсэн бол санаатай гэж үзнэ.

Зөвхөн тэмцээний үед хэрэглэхийг хориглосон бодис илэрснээс шалтгаалсан допингийн эсрэг дүрмийн зөрчлийг тухайн бодис нь тусгайлсан бодист хамаарсан, тамирчин уг

хориглосон бодисыг тэмцээний бус үед хэрэглэхдээ спортын амжилтаа сайжруулахаас бусад зорилгоор хэрэглэсэн бол санаатай гэж үзэхгүй.

10.3 Допингийн эсрэг дүрмийн бусад зөрчилд ногдуулах шийтгэл

10.5, 10.6 зүйлийг хэрэглэхээс бусад тохиолдолд 10.2 –т зааснаас өөр допингийн эсрэг дүрмийн зөрчилд оногдуулах шийтгэл эрх хасах хугацаа нь дараахи байдлаар тодорхойлогдоно.

10.3.1 2.3, 2.5 зүйлийн зөрчлийн хувьд тамирчин дээж өгөөгүй тохиолдоос шалтгаалсан допингийн эсрэг зөрчил нь санаатай (10.3.2 зүйлд тодорхойлсон) байгаагүй гэдгээ нотолсоноос бусад тохиолдолд эрх хасах хугацаа нь дөрвөн жил байна. Санаатай зөрчөөгүй гэдгийг нотлосон тохиолдолд хоёр жилээр эрх хасна.

10.3.2 2.4 зүйлийг зөрчсөн тохиолдолд эрх хасах хугацаа нь хоёр жил байна. Тамирчны гаргасан алдааны зэрэглэлээс хамаарч уг хугацааг 1 жил хүртэл хугацаагаар богиносгож болно. Байршлын тухай мэдээллээ сүүлийн мөчид өөрчилсөн эсвэл шинжилгээ өгөхөөс зайлсхийх ородлого хийсний улмаас түр түтгэлзүүлэх шийтгэл авсан тамирчинд энэ зүйлд заасан хоёр жилээс нэг жилийн хооронд дахь эрх хасах хугацааг хэрэглэхгүй.

10.3.3 2.7 , 2.8 зүйлийг зөрчсөн тохиолдолд уг зүйлийн ноцтой байдлаас шалтгаалан зөрчилд хамгийн багадаа 4 жилээс насан туршид нь эрх хасах хүртэл шийтгэл оногдуулна. 2.7, 2.8 зүйлийн зөрчлийг насанд хүрээгүй этгээдийн хувьд ноцтойд тооцох ба хэрэв тамирчныг дэмжих ажилтан тусгай бодисоос бусад шалтгаанаар зөрчил гаргасан бол түүнд насан туршид нь эрх хасах шийтгэл онооно. Түүнчлэн 2.7, 2.8 заалтын зөрчил нь спортын бус хууль дүрмийг давхар зөрчсөн бол эрх бүхий мэргэжлийн болон хуулийн байгууллагад мэдээлнэ.

10.3.3-ийн тайлбар: Тамирчны сэргээх хэрэглэх ажиллагаатай холбогдсон буюу түүнийг нь нуун дарагдуулсан этгээдэд тухайн Допинг хэрэглэсэн тамирчинд оногдуулснаас илүү хатуу шийтгэл оногдуулна. Эрх бүхий спортын байгууллагуудаас эрхийн хасалтын батламжийг хүчингүй болгох, гишүүнчлэлээс хасах болон спортоос бусад үр шим хүртэх боломжгүй байдлаар хязгаарлах болсон тул тухайн хэрэгт хамаатай Тамирчныг дэмжигч ажилтнуудыг эрх бүхий байгууллагуудад мэдээлэх нь Допинг хэрэглэх явдлыг зогсооход чухал түлхэц болно.

10.3.4 2.9 зүйлийг зөрчсөн бол зөрчлийн ноцтой байдлаас хамааран хоёроос дөрвөн жил хүртлэх хугацаагаар эрх хасах шийтгэл онооно.

10.3.5 2.10 зүйлийг зөрчсөн бол хоёр жилийн хугацаагаар эрх хасах шийтгэл оноох ба тамирчин болон бусад этгээдийн гаргасан алдааны болон бусад тохиолдлын шалтгааны зэрэглэлээс хамааран хугацааг 1 жил хүртэл хугацаагаар бууруулж болно.

10.3.5-ийн тайлбар: 2.10 зүйлд тодорхойлсон бусад “бусад этгээд” гэсэн ойлголтонд хувьд хүн биш 12 дугаар бүлэгт заасан хуулийн этгээдийг хамруулна.

10.4 Буруугүй, эсвэл хайнга хандаснаас шалтгаалсан эрх хассан шийтгэлийн хугацааг цуцлах

Хэрэв тамирчин эсвэл бусад этгээд буруугүй эсвэл хайнга хандсанаас дүрэм зөрчсөнөө нотолсон тохиолдолд түүний эрхийг хасах арга хэмжээг хүчингүй болгоно.

10.4-ийн тайлбар:

Энэ зүйл болон 10.5.2 зүйлийг допингийн эсрэг дүрмийн зөрчил гэлгийг тодорхойлох боломжгүй нөхцөлд үүссэн тохиолдолд шийтгэл онооход хэрэглэнэ.Тэдгээрийг зөвхөн онцгой тохиолдолд ашиглана. Тухайлбал буруугүй эсвэл хайнга хандсан гэдгээ тамирчин нотолж тэр өрсөлдөгчөө хоролж байна гэсэн үг.Нөгөө талаар дараахи шалтгаанууд Буруугүй эсвэл хайнга хандсан гэдэг үндэслэлээр шийтгэл хасагдах үндэслэл болохгүй.

(a) Тамирчин нэр хаяггүй, эсвэл бохирдсон витамин, нэмэлт тэжээл (тамирчин уусан эмээ болон бохирдсон тэжээл хэрэглэх боломжоос татгалзах үүрэгтэй (2.1 бүлэг)) хэрэглэсэнээс шалтгаалж шинжилгээний хариу эерэг гарах (b) Тамирчны эмч, дасгалжуулагч түүнд мэдэгдэлгүйгээр хориотой бодис хэрэглүүлэх, (Тамирчин эмнэлгийн ажилтнуудынхаа тэдэнд ямар нэг хориотой бодис, өгөхгүй байх сонголт, зөвлөгөөний үр дагаварыг өөрөө хариуцна.) (c) Гэр бүлийнхэн, дасгалжуулагч, эсвэл тамирчны хүрээлэлд байдаг бусад хүмүүс хоол унданд нь ямар нэг зүйл хийж хорлох, Гэхдээ энэ нь онцгой тохиолдлын онцлох баримтаас хамаарч буруугүй эсвэл хайнга хандах гэсэн заалтад үндэслэгдэн 10.5 зүйлийн хүрээнд шийтгэлийг богиносгох үр дүн болж болно.

10.5 Буруугүй, эсвэл хайнга хандаснаас шалтгаалсан эрх хассан шийтгэлийн хугацааг бууруулах

10.5.1 Тусгайлсан бодис, бохирдсон бүтээгдэхүүнд хамаарах 2.1, 2.2, 2.6 зүйлд заасан зөрчлүүдэд оноосон шийтгэлийн хугацааг багасгах

10.5.1.1 Тусгайлсан бодис

Допингийн эсрэг дүрмийн зөрчил нь тусгайлсан бодист хамаарч, тамирчин эсвэл бусад этгээд түүнийг хайнга хандсанаас хэрэглэсэн эсвэл буруугүй гэдээ нотолж чадвал алдааны зэрэглэлээс хамаарч хамгийн багадаа эрх хасалгүйгээр сануулга өгөх ба хамгийн ихдээ хоёр жилээр эрх хасах шийтгэл онооно.

10.5.1.2 Үл мэдэгдэх бүтээгдэхүүн

Тамирчин болон бусад этгээд буруугүй эсвэл хайнга хандсанаас болсон гэдгийг болон хориотой бодис нь бохирдсон бүтээгдэхүүнээс илэрсэн гэдгийг нотолж чадвал алдааны зэрэглэлээс хамаарч хамгийн багадаа эрх хасалгүйгээр сануулга өгөх ба хамгийн ихдээ хоёр жилээр эрх хасах шийтгэл онооно.

10.5.1.2-ийн тайлбар: Алдааны зэрэглэлийн тогтоох үед тухайлбал тамирчин бохирдсон бодисыг допингийн хяналтын хуудсанд тэмдэглүүлсэн байвал энэ нь хөнгөрүүлж үзэх шалтгаан болно.

10.5.2 Буруугуй, эсвэл хайнга хандсан шалтгааныг 10.5.1-тэй холбогдуулан авч үзэх

Тамирчин болон бусад этгээдийн гаргасан зөрчилд 10.5.1 заалтыг хэрэглэх боломжгүй бөгөөд тамирчин Буруугуй, эсвэл хайнга хандсан гэдгээ нотолсон бол 10.6 заалтын дагуу шийтгэлийг хөнгөрүүлэх, цуцалж болно. Бусал тохиолдолд алдааны зэрэглэлээс хамааран эрх хасах хугацааг багасгаж болно. Эрх хасах хугацааг нийт хугацааны хоёрны нэгээс бага хэмжээгээр багасгаж болохгүй. Бүх насаар нь эрх хасах бусад нөхцөл үүссэн тохиолдолд энэ зүйлийн хүрээнд 8 жилээс бага хугацаагаар хөнгөрүүлж болохгүй.

10.5.2-ийн тайлбар: Зорилго нь допингийн эсрэг дүрмийн зөрчлийн (2.5, 2.7, 2.8, 2.9 зүйл) эсвэл тухайлан заасан шийтгэлийн (10.2.1 зүйл) нэг элемент болсон эсвэл тамирчны алдаанаас шалтгаалж эрх хасах шийтгэл хэдийнэ оноогдсоноос бусад тохиолдолд 10.5.2 зүйлийг допингийн эсрэг дүрмийн ямар ч зөрчилд хэрэглэж болно.

10.6 Эрх хасах шийтгэлийн хугацааг цуцлах, багасгах, түтгэлзүүлэх эсвэл алдаанаас өөр шалтгаанаас үүсэх бусад үр дагавар

10.6.1 Допингийн эсрэг журмын зөрчлийг илрүүлэх буюу тогтоох бодит оролцоо

10.6.1.1 Бусад этгээдийн оролцоотойгоор бий болсон Допингийн эсрэг зөрчил гаргах эсвэл уг зөрчил нь гэмт хэрэгийн шинжтэй үйлдэл болохыг тогтооход тамирчин, тамирчныг дэмжигч этгээд Допингийн эсрэг байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх болон засан хүмүүжүүлэх байгууллагад бодитойгоор дэмжлэг үзүүлж дараахи үр дүн гарсан бол үүнд: i) Допингийн эсрэг байгууллага бусад этгээдийн тусламжтайгаар допингийн эсрэг зөрчлийг илрүүлсэн эсвэл хэрэг үүсгэсэн бол, ii) гэмт хэрэгтэй тэмцэх болон засан хүмүүжүүлэх байгууллага бусад этгээдийн үйлдсэн хэргийг илрүүлсэн эсвэл хэрэг үүсгэсэн болон үр дүнгийн зохицуулалт хийх эрх бүхий допингийн эсрэг байгууллагад бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээлэл ирсэн зэрэг болно. Үр дүнгийн зохицуулалтыг хийх эрх бүхий Допингийн эсрэг байгууллагаас 13 дугаар бүлэгт заасан давж заалдсан хэргийн шийдвэр гарахаас өмнө эсвэл давж заалдах хугацаа дууссан тохиолдолд түүнд оногдуулсан эрхийн хасалтын хэмжээг багасгаж болно. Допингийн эсрэг байгууллага 13 дугаар бүлэгт заасны дагуу давж заалдсан хэргийн шийдвэр гарсны дараа, эсвэл давж заалдах хугацаа дууссан үед шийтгэлийн хэмжээг багасгах шийдвэр гаргахдаа ДДЭА болон холбогдох олон улсын холбооны зөвшөөрлийг авна. Тухайн тамирчин, тамирчныг дэмжигч этгээдийн зөрчсөн допингийн эсрэг дүрмийн нөхцөл байдал, тэдний үзүүлсэ тусламжийн спорт дахь допингийн эсрэг нөлөөлөх ач холбогдол зэрэгт үндэслэн багасагах хэмжээг тогтооно. Эрх хасах хугацааг үндсэн шийтгэлийн $\frac{3}{4}$ ихгүй хэмжээгээр богиносгож болно. Хэрэв тухайн тамирчны эрхийг насан туршид нь хассан тохиолдолд энэ бүлгийн хүрээнд 8 жилээс багагүй хугацаа болгож бууруулна.

Хэрэв допингийн эсрэг байгууллага тамирчин бусад этгээдийн эрх хасах хугацааг түтгэлзүүлэхээр бодит мэдээлэл өгөхөөр хамтран ажиллах, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхдээ алдаа гаргасан бол Допингийн эсрэг байгууллага эрхийг түтгэлзүүлэх анхны хугацааг сэргээн тогтооно. Допингийн эсрэг байгууллагаас гаргасан анхны хугацааг

сэргээн тогтоосон болон сэргээн тогтоохгүй тухай шийдвэрийг эрх бүхий аливаа этгээд 13 дугаар бүлэгт заасны дагуу давж заалдах эрхтэй.

10.6.1.2 ДДЭА 13 дахь бүлэгт заасны дагуу давж заалдсан тухай эцсийн шийдвэр гарсан зэрэг үр дүнгийн удирдлагын аль шатанд үр дүнгийн удирдлагыг хариуцаж буй допингийн эсрэг байгууллагын хүсэлтээр эсвэл допингийн эсрэг дүрэм зөрчсөн нь батлагдсан тамирчин болон бусад этгээдийн хүсэлтээр бодит мэдээллээр хангасан тамирчин болон бусад этгээдийн эрх хасах шийтгэл болон бусад үр дагаварыг түтгэлзүүлэх талаар зохих ёсоор авч үзнэ

Онцгой тохиолдолд ДДЭА бодит мэдээллээр хангасны төлөө эрх хасах шийтгэлийн хугацаа болон бусад үр дагаварыг энэ бүлэгт зааснаар өөрөөр түтгэлзүүлэх эсвэл эрх хасахгүй байх, эсвэл шагналын мөнгийг буцаан олгохгүй эсвэл нэмэлт төлбөр төлөхгүй байх зөвшөөрөл өгч болно.

ДДЭА-ийн баталгаа нь энэ бүлэгт өөрөөр заасны дагуу өөрчлөгдөж болно. Энэ бүлэгт зааснаар гаргасан ДДЭА-ийн шийдвэрийг аль нэг допингийн эсрэг байгууллага 13 дугаар бүлэгт заасны дагуу давж заалдах боломжгүй.

10.6.1.3 Допингийн эсрэг байгууллага бодит мэдээллээс шалтгаалан бусад боломжит шийтгэлийн аль нэг хэсгийг түтгэлзүүлсэн бол энэ шийдвэрийг гаргасан үндэслэлээ 13.2.3 дахь зүйлд заасан давж заалдах эрх бүхий бусад допингийн эсрэг байгууллагад 14.2 зүйлийг баримтлан мэдээлнэ. ДДЭА допингийн эсрэг сайн үндэслэл хэмээн тодорхойлсон онцгой шалтгааны улмаас ДДЭА нь үүнийг зохих ёсоор нууцлах гэрээ байгуулах, бодит мэдээллийг нийтэд мэдээлэхийг хязгаарлах эсвэл хойшлуулах, бодит мэдээллийн орчныг хамгаалах гэрээг байгуулах эрхийг допингийн эсрэг байгууллагад олгоно.

10.6.1-ийн тайлбар: Тамирчин, тамирчныг дэмжигч этгээд болон бусад хүмүүс алдаагаа ухамсарлаж, допингийн эсрэг бусад зөрчлийг илрүүлэхэд хамтран ажиллах нь цэвэр спорт бий болгоход чухал үүрэгтэй.

Эдгээр нь зөвхөн дүрмийн хүрээнд зөвшөөрөгдсөн эрх хасах хугацааг богиносгуулах шалтгаанууд болно.

10.6.2 Өөр нотлох баримтгүй үед допингийн эсрэг дүрэм зөрчигдсөнийг хүлээн зөвшөөрөх

Тамирчин болон бусад хүмүүс допингийн эсрэг дүрмийг зөрчсөнөө түүний дээж допингийн эсрэг дүрмийг зөрчсөн байж болох тухай(2.1 т зааснаас бусад зөрчлийн хувьд эсвэл 7 дугаар бүлэгт заасны дагуу зөрчлөө хүлээн зөвшөөрсөн тухай эхний мэдэгдэл хүлээн авахаас өмнө) мэдэгдэл хүлээн авахаас өмнө сайн дураараа хүлээсэн бөгөөд хүлээн зөвшөөрөх үед энэ нь зөвхөн найдвартай нотолгоотой байвал шийтгэлийн хугацаа багасаж болно. Харин уг хугацаа нь үндсэн шийтгэлийн хугацааны ½-ээс бага байж болохгүй.

10.6.2-ийн тайлбар: Энэ заалт тамирчин Допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрмийг зөрчсөнийг мэдэж байж болзошгүй шалтгаанаар допингийн эсрэг дүрмийг

зөрчсөнөө хүлээн зөвшөөрөх үед хэрэглэгдэнэ. Харин тамирчин болон бусад этгээд хэрэг илрэх нь тодорхой болсныг мэдэгмэгц хийж буй үйлдэлд хэрэглэгдэхгүй. Эрх хассан хэмжээг тухайн тамирчин, бусад этгээдийн сайн дураар ирсэн эсэх магадлал дээр үндэслэн хасч болно.

10.6.3 10.2.1, 10.3.1 зүйлд заасны дагуу шийтгэл оноож болохуйц зөрчил гэж үзсэн тохиолдолд допингийн эсрэг зөрчлийг даруй тооцно. Допингийн эсрэг байгууллага шийтгэл оноож болохуйц зөрчил гэж үзсэний дараа допингийн эсрэг зөрчлийг нэн даруй баталж 10.2.1, 10.3.1-т заасны дагуу дөрвөн жилийн шийтгэлийг тамирчин болон бусад этгээдэд оноож болох ба ДДЭА болон үр дүнгийн удирдлагыг хариуцаж байгаа допингийн эсрэг байгууллагууд баталсан эсвэл сонгосон тохиолдолд тамирчны болон бусад этгээдийн зөрчлийн ноцтой байдлын зэргээс хамаарч хоёр жил хүртлэх хугацаагаар бууруулж болно.

10.6.4 Шийтгэлийг бууруулах зорилгоор олон үндэслэлийг хэрэглэх

10.6 зүйлийн дагуу дагуу эрх хасах хугацааг богиносгуулах, түтгэлзүүлэх хүсэлт гаргахаас өмнө тамирчин болон бусад этгээд 10.2,10.3,10.4,10.5 зүйлийн нэгээс дээш үндэслэлээр шийтгэлийг хөнгөрүүлэх эрх үүссэн тохиолдолд эл хугацааг 10.4, 10.5 заалтын дагуу тогтоосон байх шаардлагатай. Хэрэв тамирчин болон бусад этгээд 10.6 зүйлд заасан үндэслэлээр эрх үүссэн бол эрх хасах хугацааг бууруулж түтгэлзүүлж болно. Харин уг хугацаа нь үндсэн хугацааы дөрөвний нэгээс бага байж болохгүй.

10.6.4-ийн тайлбар:

Зохих шийтгэл нь 4 үе шатаар тодорхойлогддог. Нэгдүгээрт хянан хэлэлцэх баг допингийн эсрэг зөрчлийн хэрэг бүрээр шийтгэл оноох үндэслэлийг (10.2,10.3,10.4, 10.5) тогтооно. Хоёрдугаарт, хэрэв үндсэн шийтгэл оноох үндэслэл хангагдаж байвал хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн тамирчин болон бусад этгээдийн алдааны зэрэглэлээс шалтгаалж хэрэглэж болох шийтгэлийг тогтоох шаардлагатай.

Гуравдугаар шатанд, хянан хэлэлцэх бүрэлдэхүүн шийтгэлийг(10.6 зүйл) цуцлах, хөнгөрүүлэх, түтгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхийг тогтооно. Эцэст нь хянан хэлэлцэх баг нь 10.11 дахь заалтын дагуу шийтгэл тооцогдож эхлэх хугацааг шийднэ.

10 дугаар бүлгийг хэрхэн хэрэглэх тухай зарим жишээг 2 дугаар хавсралтаас үзнэ үү.

10.7 Хэд хэдэн зөрчил

10.7.1 Тамирчин болон бусад этгээдийн хоёр дахь удаагаа гаргсан допингийн зөрчилд оногдох эрх хасах хугацааг доорхи нөхцлөөс багагүй байхаар шийдвэрлэнэ:

a) Зургаан сар

b) 10.6 зүйлийн хүрээнд ямар нэгэн хөнгөлөлт үзүүлэлгүйгээр эхний удаа оноосон шийтгэлийн хугацааны хоёрны нэгтэй тэнцүү

c) Эхний удаагийн зөрчлийн үед 10.6 зүйлийн хүрээнд ямар нэг хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ аваагүй бол допингийн эсрэг дүрмийн хоёр дахь удаагийн зөрчилд шийтгэлийн хугацааг хоёр дахин нэмэгдүүлж олгоно.

Дээрхи үндэслэлийн дагуу оноогдсон шийтгэлийг 10.6 зүйлийн дагуу хөнгөрүүлж болно.

10.7.2 Допингийн эсрэг дүрмийн 3 дахь зөрчил нь 10.4, 10.5-ийн дагуу шийтгэлийн хугацааг цуцлах, багасгах нөхцлийг хангасан эсвэл 2.4 зүйлд хамаарахаас бусад тохиолдолд насан туршдаа эрх хасуулсан үед тохиолддог. Эдгээр тусгай тохиолдолд 8 жилээс насан турш эрх хасах арга хэмжээ авна.

10.7.3 Тамирчин болон бусад этгээд буруугй болон хайнга байдлаас шалтгаалсан гэдгээ нотолсон допингийн эсрэг дүрэм зөрчлийн хувьд энэ бүлгийг хэрэглэх зорилгоор түүнийг авч үзэхгүй.

10.7.4 Гарцаагүй магадлалтай олон тооны зөрчилд зориулсан нэмэлт журам

10.7.4.1 10.7 бүлгийн дагуу шийтгэл оноох зорилго нь Хэрэв тамирчин бусад хүмүүс Допингийн эсрэг байгууллагаас 7 дугаар бүлгийн дагуу гаргасан шийдвэр авсны дараа допингийн эсрэг дүрэм зөрчсөнийг Допингийн эсрэг байгууллага тогтоосон бол, Допингийн эсрэг байгууллага эхний зөрчлийн тухай мэдэгдэл өгсний дараа гарсан 2 дахь зөрчил үнэлэхэд оршино. Хэрэв допингийн эсрэг байгууллага үүнийг тогтоож чадаагүй бол эдгээрийг хамтад нь эхний зөрчил гэж тооцох ба илүү хатуу шийтгэл оногдуулна.

10.7.4.2 Допингийн эсрэг дүрмийн эхний зөрчилд шийтгэл оноосны дараа Допингийн эсрэг байгууллага эхний дүрмийн зөрчлийн тухай мэдэгдэл өгөхийн өмнө тамирчин болон бусад этгээдийн допингийн эсрэг дүрмийн зөрчилд хамаарах баримт илрүүлсэн бол 2 зөрчил ижил цаг хугацаанд хянан хэлэлцэгдсэн тохиолдолд шийтгэл оноох эсэх дээр үндэслэн нэмэлт шийтгэл оноож болно. Тэмцээний үр дүнг 10,8 заалтын дагуу допингийн эсрэг дүрмийн зөрчил гарсан өдрөөс хүчингүй болгоно.

10.7.5 Арван жилийн шийтгэлийн үеийн допингийн эсрэг дүрмийн хэд хэдэн зөрчил

10.7 заалтын зорилго нь арван жилийн шийтгэлийн хугацаанд ч гарсан допингийн эсрэг дүрмийн хэд хэдэн зөрчлийг хянан хэлэлцэхэд оршино.

10.8 Шинжилгээнд дээж өгсний дараа өмнөх тэмцээнд хүрсэн үр дүнг хүчингүй болгох

9 дүгээр зүйлд заасан зохицуулалтаас гадна, түр зуурын түдгэлзүүлэлт болон эрхийн хасалтыг тоож эхэлснээс хойш дээжийн шинжилгээний хариу нэмэх гарсан (тэмцээний үеийн буюу тэмцээний дараахь эсэхээс үл хамааран) өдрөөс тамирчны үзүүлсэн бүх үр дүн, эсвэл Допингтэй холбоотой зөрчил гарсан үед шударга ёсонд ямар нэгэн байдлаар нийцүүлэх ёстойгоос бусад тохиолдолд тухайн тамирчны хүртсэн медаль, авсан оноо болон шагналыг хураах зэргээр хожим хүрсэн үр дүнг бүхэлд нь хүчингүй болгоно.

10.8-ийн тайлбар: Дүрэм нь этгээдий эрхийг зөрчиж, допингийн эсрэг дүрэм зөрчсөн тамирчин болон бусад этгээдий гаргасан үйлдлээс шалтгаалан хохирсон цэвэр тамирчинд сөргөөр нөлөөлөхгүй.

10.9 Спортын арбитрын шүүхийн зардлыг гаргуулах болон мөнгөн шагналыг хураан авах

Спортын арбитрын шүүхийн зардлыг гаргуулах болон шагналын мөнгийг хураан авах нь дараахи эрэмбэтэй байна. Үүнд: нэгдүгээрт спортын арбитрын шүүхийн зардлыг төлөх, хоёрдугаарт, харьяалах олон улсын холбооны дүрмэнд заасан тохиолдолд хураагдсан мөнгөн шагналыг өөр тамирчинд шилжүүлэн олгох, гуравдугаарт, тухайн тохиодлын үр дүнгийн удирдлагыг гүйцэтгэхийн тулд допингийн эсрэг байгууллагаас гаргасан зардлыг буцаан төлүүлэх

10.10 Санхүүгийн үр дагавар

Допингийн эсрэг байгууллага өөрийн дүрмэнд допингийн эсрэг дүрмийн зөрчилд оногдуулах зардлыг буцаан төлүүлэх болон санхүүгийн шийтгэлийн оноох заалтыг хувь тэнцүүлэн тусгана. Харин допингийн эсрэг байгууллага нь санхүүгийн торгуулийг эрх хасах шийтгэлийн дээд хугацааг авсан эсвэл аль хэдийнэ шийтгэл хүлээсэн тохиолдолд ногдуулна. Санхүүгийн торгууль хувь тэнцүүлэх зарчмыг мөрдлөг болгоно. Зардлыг буцаан төлөх болон санхүүгийн шийтгэл хүлээх нь эрх хасах болон дүрмийн хүрээнд оноосон бусад шийтгэлийг хөнгөрүүлэх үндэслэл болохгүй.

10.11 Эрхийн хасалтын хугацааг тоолж эхлэх

Дор дурдсанаас бусад тохиолдолд Эрхийн хасалтын хугацааны талаар хянан хэлэлцэх ажиллагааны эцсийн шийдвэр гарсан, эсвэл тухайн шийдвэрийг эсэргүүцсэн, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа хийгээгүй бол эрхийн хасалтыг хүлээн авсан, эсвэл бусад хэлбэрээр шийтгэл оногдуулсан өдрөөс эхлэн эрхийн хасалтын хугацааг тоолж эхэлнэ.

10.11.1 Тамирчин болон бусад этгээдээс хамааралгүй хойшлох

Хянан хэлэлцэх болон допингийн хяналтын бусад үйл ажиллагаа нь тамирчин болон бусад хүмүүсээс хамаараалгүй хойшилсон бол шийтгэлийн хугацааг шинжилгээ өгсөн өдрөөс эхлэн эсвэл допингийн эсрэг өөр дүрэм зөрчсөн өдрөөс эхлэнэ тоолно. Эрх хассан хугацаа дуусаагүй эсвэл дахин сэргээсэн үед үзүүлсэн бүх амжилтыг хүчингүйд тооцно.

10.11.1-ийн тайлбар: 2.1 зүйлд зааснаас бусад допингийн эсрэг дүрмийн зөрчил гарсан үед допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрмийн зөрчлийг илүүрэх, баримтыг баталгаажуулах, ялангуяа тамирчин болон бусад этгээд илрүүлэхэд саад хийсэн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд удаан хугацаа шаардагдаж болно. Энэ тохиолдолд энэ бүлэгт заасан шийтгэлийн хугацааг эртнээс тооцож эхлэх уян хатан зохицуулалтыг хэрэглэхгүй.

10.11.2 Цаг хугацааг хүлээн зөвшөөрөх

Тамирчин болон бусад хүмүүс допингийн эсрэг байгууллагаас тогтоосон допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол (Тамирчин тэмцээндээ оролцохоос өмнө, бүх тэмцээнд хамаарна.) шийтгэлийн хугацааг шинжилгээ өгсөн өдрөөс эхлэн эсвэл допингийн эсрэг өөр дүрэм зөрчсөн өдрөөс эхлэнэ тоолно.

Гэхдээ хамгийн багадаа шийтгэлийн $\frac{1}{2}$ -тэй тэнцэх хугацааг тамирчин болон бусад хүмүүст шийтгэл оноосон тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцоход энэ бүлгийг хэрэглэнэ. Энэ заалт шийтгэлийн хугацаа 10.6.3 зүйлд заасны дагуу нэгэнт хөнгөрсөн тохиолдолд хэрэглэгдэхгүй.

10.11.3 Түр түтгэлзүүлэх, эрх хасах шийтгэлд итгэлцэл эрх олгох

10.11.3.1 Хэрэв эрхийг түр түтгэлзүүлэх шийтгэл оноогдсон бөгөөд тамирчин болон бусад этгээд түүнийг хүлээн авсан бол тамирчин болон бусад этгээд эрх хасах ямар нэг эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд эрхийг итгэлцлийн дагуу түр түтгэлзүүлнэ. Хэрэв шийдвэрийн дагуу эрх хасах хугацаа эхэлсэн уг шийдвэрийг давж заалдахаар болсон бол тамирчин болон бусад этгээд давж заалдсан тухай шийдвэр гарах хүртэл итгэлцэлийн эрх хүлээн авна

10.11.3.2 Хэрэв тамирчин болон бусад этгээд үр дүнг зохицуулах эрх бүхий допингийн эсрэг байгууллагаас бичгээр өгсөн мэдэгдлийг сайн дураар бичгээр хүлээн зөвшөөрсөн болон түр түтгэлзүүлэлтийг хүндэтгэсэн үед ямар нэг шийтгэл оноох хүртэл эрхийг түр түтгэлзүүлэх шийтгэлийг итгэлцлийн үндсэн дээр онооно. Түр түтгэлзүүлэлтийг хүлээн зөвшөөрсөн тухай тамирчны болон бусад этгээдийн бичгээр өгсөн мэдүүлгийн хуулбарыг допингийн эсрэг дүрмийн зөрчил батлагдсан тухай мэдэгдэл хүлээн авах эрх бүхий 14.1-т заасан бүх байгууллагуудад илгээнэ.

10.11.3.2-ийн тайлбар: Тамирчин түр түтгэлзүүлэлтийг хүлээн зөвшөөрөх нь хэрэгээ өөрөө хүлээсэн гэсэн үг биш бөгөөд тамирчны эсрэг аз туршсан таамаглал гаргахад ашиглагдахгүй.

10.11.3.3 Эрх хасах хүртэл түр түгэлзүүлэх итгэлцэх шийдвэр нь түр түгэлзүүлэлт үйлчилж эхлэх өдрөөс өмнө ямар нэг хугацаанд эсвэл тамирчин тэмцээнд оролцохгүй болон багийн бүрэлдэхүүнд багтаагүйгээс шалтгаалан сайн дураар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд үйлчлэхгүй.

10.11.3.4 Багийн спортын хувьд бусад шударга байдлыг хангах шаардлагаас өөр тохиолдолд эрх хасах шийтгэл хүлээсэн багийн шийтгэлийн хугацааг эрх хасах тухай хянан хэлэлцсэн эцсийн шийдвэр гарсан өдрөөс эсвэл эрх хасах шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн эсвэл бусад хэлбэрээр оноогдсоны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй бол тухайн өдрөөс эхлэн тооцно. Багт оноосон түр түгэлзүүлэлтийн аль нэг үе нь шийтгэлийн бүхий л хугацаанд итгэлцэлийн эрх олгоход үйлчилнэ.

10.11-ийн тайлбар: Уг заалтыг тамирчнаас хамаарахгүй хойшлох болон тамирчин болон бусад этгээдийн сайн дураар хүлээн зөвшөөрөх гэсэн 10.11 заалт нь зөвхөн шүүхийн эцсийн шийдвэр гарахаас өмнө шийтгэлийн хугацааг тоолж эхлэх үндэслэл болно гэж илүү тодорхой болгосон.

10.12. Эрх хасуулсан үеийн байдал

10.12.1 Эрх хасуулсан үед тэмцээнд оролцохыг хориглох

Эрхээ хасуулсан этгээд нь эрхийн хасалт үргэлжлэх бүхий л хугацаанд допингийн эсрэг боловсролын болон сахилга хүмүүжлийн чанартай арга хэмжээнээс бусад тохиолдолд гарын үсэг зурагч буюу эсвэл гарын үсэг зурагчийн гишүүн байгууллагуудаас зохион байгуулж буй аливаа спортын уралдаан, тэмцээнүүд, мэргэжлийн лиг, олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээн эсвэл засгийн газрын байгууллагын зохион байгуулсан дээд зэрэглэлийн болон спортын аливаа арга хэмжээнд оролцохыг хориглоно.

Дөрвөн жилээс илүү хугацаагаар эрхээ хасуулсан этгээд эрх хасалтын дөрвөн жил дууссаны дүрмэнд гарын үсэг зурагчдын болон гарын үсэг зурагчдын гишүүдийн зүгээс хориглоогүй орон нутгийн чанартай тэмцээн, уралдаанд тамирчны хувиар оролцож болох авч тухайн тэмцээнүүд нь цаашид тухайн этгээдэд шууд болон шууд бус замаар үндэсний аварга шалгаруулах болон олон улсын тэмцээнд оролцох эрх олгох тэмцээн болохгүй бөгөөд насанд хүрээгүй эдгээдтэй аливаа хэлбэрээр ажилладаг тамирчин бусад этгээд үүнд хамрагдахгүй.

Эрх сэргээх зорилгоор шинжилгээ хийх боломжоо хадгална.

10.12.1-ийн тайлбар: Дор дурдсан 10.12.2 зүйлтэй холбоотойгоор эрхээ хасуулсан тамирчин засгийн газраас санхүүжүүлж, үндэсний холбоо, эсвэл түүний гишүүн клубын зохион байгуулж байгаа бэлтгэл, сургалт, цугларалтанд орохыг хориглоно. Түүнчлэн эрхээ хасуулсан тамирчин дүрмэнд нэгдээгүй мэргэжлийн лигийн тэмцээнд ч орж болохгүй. Дүрэмд нэгдээгүй олон улсын болон үндэсний холбооноос зохион байгуулж байгаа тэмцээнүүдэд 10.12.3-т заасан арга хэмжээ авахгүй. “Үйл ажиллагаа” гэсэн нэр томъёонд энэ бүлэгт тодорхойлсон байгууллагын албаны хүмүүс, захирал, мэргэжилтэн, ажилтан болон сайн дурын этгээдийн оролцож буй захиргааны үйл ажиллагааг ойлгоно. Нэг

спортод ногдсон торгууль нь бусад спортод мөн хамаарна. (15.1 Харилцан хүлээн зөвшөөрөх заалтыг үз)

10.12.2 Бэлтгэлдээ эргэн орох

10.12.1 заалтад тайлбарласнаар тамирчин дор дурдсанаас богино хугацаагаар багтайгаа бэлтгэл хийж, клуб болон гарын үсэг зурагчдын гишүүн байгууллагын материаллаг баазыг ашиглахыг зөвшөөрнө. Үүнд: (1) тамирчны шийтгэлийн сүүлийн 2 сар эсвэл (2) эрх хасах шийтгэлийн сүүлийн улирал

10.12.2-ийн тайлбар: Багийн олон спорт, зарим ганцаарчилсан (цанын харайлт, гимнастик гэх мэт) спортын тамирчид эрх хасах шийтгэлийнхээ дараа тэмцээнд оролцох бэлэн болох хүртлээ идэвхитэй хийх боломжгүй байдаг. Тамирчин энэ бүлэгт тодорхойлсон бэлтгэлийн хугацаанд эрхээ хасуулсан тамирчин бэлтгэл хийхээс өөр зорилгоор 10.12.1-т тодорхойлсон аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

10.12.3 Эрх хасуулсан үед тэмцээнд оролцохыг хориглох дүрмийн зөрчил

10.12.1-т заасан эрх хасуулсан үед тэмцээнд оролцохыг хориглох дүрмийн зөрчил гаргасан тамирчин бусад этгээдийн оролцсон тэмцээний үр дүн хүчингүй болох шийтгэлийн шинэ хугацааг анх оноогдсон шийтгэлийн хугацааны төгсгөлд түүнтэй тэнцүү хугацааг нэмснээр тооцно. Шийтгэлийн шинэ хугацааг тамирчин болон бусад этгээдийн алдааны зэрэглэл, болон бусад шалтгааныг үндэслэн тохируулж болно. Тамирчин энэ дүрмийг зөрчсөн эсэх, хугацааг хэрхэн тохируулахыг анхны шийтгэлийн хугацааг олгох үр дүнгийн зохицуулалтыг удирдсан Допингийн эсрэг байгууллага тогтооно. Эл шийдвэрийг 13 дугаар бүлэгт заасны дагуу давж заалдаж болно.

10.10.2-ийн тайлбар:

Хэрэв тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд дүрэм зөрчихөд тусласан бол Допингийн эсрэг байгууллага эрхийнхээ хүрээнд дүрмэндээ заасан шийтгэлийг 2.9 заалтыг зөрчсөн гэж үзэн тухайн тамирчиныг дэмжигч этгээд болон бусад этгээдэд оноож болно.

10.12.4 Шийтгэлийн хугацаанд санхүүгийн тусламж үзүүлэхээс татгалзах

Түүнчлэн Гарын үсэг зурагч, гарын үсэг зурагчийн гишүүн байгууллага засгийн газрууд нь 10.4 эсвэл 10.5 зүйлд тодорхойлсонын дагуу хөнгөрүүлсэн хэрэгт хамаарахгүй допингийн эсрэг аль нэг зөрчил гаргасан этгээдд хүрэх зарим болон бүх спорттой хамаатай санхүүгийн тусламж, спортод хамаарах бусад үр ашигт хориг тавина.

10.13 Шийтгэлийг автоматаар хэвлэн нийтлэх

Шийтгэлийн хүчин төгөлдөр хэсэг бүрийг 14.3-т заасны дагуу автоматаар хэвлэн нийтлэнэ.

10 дугаар бүлгийн тайлбар: Шийтгэлийн уялдаа холбоо нь допингийн эсрэг маш их хэлэлцэгдэж, шинээр гарч ирсэн зүйл юм. Уялдаа холбоо гэдэг нь тохиолдол бүрийн онцгой баримтыг баталгаажуулахад ижил дүрэм, шалгуурыг хэрэглэнэ гэсэн үг юм. Шийтгэлийн уялдаа холбоог шаардахын эсрэг маргаан нь спортын ялгаанаас тухайлбал зарим спортод тамирчин мэргэжлийн түвшинд өрсөлдөж маш их хэмжээний орлого олдог байхад заримд нь жинхэнэ сонирхогч байдаг. Эдгээр тамирчдын хувьд спортын замнал нь богино байдаг тул эрх хасах шийтгэлийн стандарт хугацаа нь үндэсний уламжлалт хэв шинжтэй болон тамирчны замнал нь урт байдаг спортынхны хувьд илүү үр нөлөөтэй, ач холбогдолтой байдагт үндэслэгддэг. Уялдаа холбоог хэрэглэх үндсэн маргаан нь нэг улсын ижил спортын тамирчид адил шалтгааны улмаас ижил хориотой бодис хэрэглэсэн нь шинжилгээгээр илэрэхэд спортоос хамааран ялгаатай шийтгэл хүлээлгэх тохиолдолд гардаг.Түүнчлэн зарим тохиолдолд допинг хэрэглэсэн этгээдтэй илүү хүлээцтэй, зөөлөн харьцах батлагдаагүй боломжийг зарим спортын байгууллагад олгох зорилгоор зарим үед шийтгэлийг уян хатан байлгахар хянан үздэг. Шийтгэлийн уян хатан байдлыг дутуу хэрэглэснээс олон улсын холбоо болон хууль зүйн зөрчил үүсдэг.

11 ДҮГЭЭР БҮЛЭГ: БАГТ УЧРУУЛАХ ҮР ДАГАВАР

11.1 Багийн спортын шинжилгээ

Аливаа багийн нэгээс олон гишүүн спортын үйл ажиллагаатай холбоотойгоор 7 дугаар зүйлд заасан зөрчлийг бий болгосон байж магадгүй гэсэн мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд дүрмийн дагуу тусгайлан шинжилгээг зохион байгуулна.

11.2 Багийн спортод учруулах үр дагавар

Хэрэв багийн спортын төрлийн аль нэг багийн 2 буюу түүнээс дээш гишүүн тэмцээний үеэр допингийн эсрэг дүрмийг зөрчсөн нь илэрсэн бол тэмцээнийг зохион байгуулагчид багт зохих шийтгэлийг ногдуулна.(Тухайлбал оноог хүчингүй болгох, тэмцээнээс хасах, бусад...) түүнчлэн дүрмийн зөрчил гаргасан хувь тамирчинд зохих шийтгэл онооно.

11.3 Тэмцээнийг зохион байгуулагчид Багийн спортод зориулсан хатуу шийтгэл батлах

Тэмцээнийг зохион байгуулагчид тэмцээнд хэрэглэх зорилгоор 11.2 –т зааснаас чанга шийтгэлийг тусгайлан баталж болно.

11.3-ийн тайлбар: Жишээ нь Олон улсын Олимпийн Хороо Олимпийн наадмын үеэр илэрсэн ганц тохиолдолд үндэслэн олимпийн наадмаас хасах журам баталж болно.

12 ДУГААР БҮЛЭГ: СПОРТЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ОНОГДУУЛАХ ШИЙТГЭЛ

Энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн аливаа гарын үсэг зурагч этгээд болон засгийн газруудаас өөрийн харьяалалд байдаг спортын байгууллагуудад шийтгэл оногдуулах

зорилгоор өөрсдийн болон гишүүдийн журмыг батлахад энэхүү дүрмийн аль ч заалт нөлөөлөхгүй.

12 Дугаар зүйлийн тайлбар: Энэ зүйлээр байгууллага хоорондын сахилга хүмүүжлийн эрхийн ялгааг хязгаарлахгүй

13 ДУГААР БҮЛЭГ: ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ

13.1 Давж заалдаж шийдвэрүүд

Энэхүү дүрэм болон олон улсын стандартууд түүнд нийцүүлэн баталсан бусад журмын дагуу гаргасан шийдвэрүүдийг 13.2, 13.4 дэх хэсгүүдэд заасан үндэслэлүүдийн дагуу давж заалдаж болно. Давж заалдсан шийдвэрийг хянан хэлэлцэх эрх бүхий байгууллагаас өөрөөр шийдвэрлээгүй бол давж заалдаж байгаа хугацаанд тэдгээр шийдвэрүүд нь хүчин төгөлдөр хэвээр байна. Давж заалдах ажиллагаа эхлэхээс өмнө Допингийн эсрэг байгууллагуудын журамд заасан хуучин шийдвэрүүдийг хянах ажиллагаа дууссан байх ёстой бөгөөд тухайн хянан шалгах ажиллагааг дор буюу 13.2.2 дахь хэсэгт заасан зарчмуудын хүрээнд хийх болно. (13.1.3 аас гадна)

13.1.1 Хязгаарлалтгүй хянан үзэх зорилго

Давж заалдах үед тухайн хэрэгтэй холбогдох бүх зүйлийг багтаасан хяналтын зорилго нь эхний шийдвэр гаргахаас өмнө зорилго болон материалуудыг хязгаарлалтгүйгээр, шуурхай хянан үзэхэд оршино.

13.1.2 Спортын арбитрын шүүх давж заалдах үед илэрсэн материалыг хойшлуулахгүй байх

Шийдвэр гаргах явцад спортын арбитрын шүүх нь давж заалдаж буй этгээдэд өөрийн үнэмлэмжээр ялгавартай хандлага гаргаж болохгүй.

13.1.3 ДДЭА эцсийн шатыг хүлээх шаардлагагүй байх

Бусад тал Допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааны дуусаагүй байхад давж заалдахгүй тохиолдолд ДДЭА 13 дугаар бүлгийн дагуу давж заалдах эрхтэй. ДДЭА допингийн эсрэг байгууллагын эцсийн шийдвэрийг хүлээлгүй шууд Спортын Арбитрын шүүхэд давж заалдана.

13.1.3-ийн тайлбар: Хэрэв шүүхийн шийдвэр нь Допингийн эсрэг байгууллагын дотоод үйл ажиллагааны (эхний хянан хэлэлцэх үйл ажиллагаа) сүүлийн шат дуусахаас өмнө тодорхой болж, уг байгууллагын дараагийн үйл ажиллагаанаас (удирдах зөвлөлийн хурал....) давж заалдах төлөөллийг томилж амжаагүй тохиолдолд ДДЭА допингийн эсрэг байгууллагын дотоод үйл ажиллагааны сүүлийн шатыг алгасаж Спортын арбитрын шүүхэд шууд гомдол гаргана.

13.2 Допингийн эсрэг журмын зөрчил, үр дагавар болон эрхийн түр түдгэлзүүлэлт, шийдвэр болон үндэслэлийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шийдвэрийг давж заалдах

Допингийн эсрэг журам зөрчигдсөн тухай шийдвэр, Допингийн эсрэг журамд шийтгэл оногдуулах эс оногдуулах тухай шийдвэр, Допингийн эсрэг журам зөрчигдөөгүйг тогтоосон тухай шийдвэр, допингийн эсрэг дүрмийн зөрчлийн явц нь үйл ажиллагаанд нөлөөлөх шалтгаан (жишээ, танилцуулга) болж чадахгүй тухай шийдвэр, 5.7.1 зүйлийн хүрээнд зодог тайлаад эргэн ирж буй тамирчинд 6 сарын мэдэгдэл өгөх шаардлагад баталгаа олгохгүй байх тухай ДДЭА-ийн шийдвэр, 7.1 зүйлийн хүрээнд үр дүнгийн удирдлагыг хариуцуулах тухай ДДЭА-ийн шийдвэр, хэргийг хянан шийдвэрлэхэд Допингийн эсрэг байгууллагад эрх хэмжээ дутагдаж байгаа тухай шийдвэр, Допингийн эсрэг байгууллага нь сөрөг аналитик илэрц болон гаж илэрц гэж үзэхгүй байгаа, 7.7-д заасан шалгалтын ажил дууссаны дараа допингийн эсрэг зөрчилтэй холбоотой шийдвэр хэрэгжээгүй болон түр зуурын хянан хэлэлцэх ажиллагааг тус тус зөрчсөнийх нь төлөө түр зуурын түдгэлзүүлэлт оногдуулах тухай шийдвэр, 7.9 зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой Допингийн эсрэг байгууллагын гаргасан алдаа, допингийн эсрэг дүрмийн зөрчлийг батлах үед допингийн эсрэг байгууллага дүрмийн үндэслэлийг дутуу тооцсон тухай шийдвэр, эрх хасах шийтгэлийн хугацааг түтгэлзүүлсэн, эс түтгэлзүүлсэн эсвэл 10.6.1 зүйлийн дагуу түр түтгэлзүүлсэн байгаа эрх хасах хугацааг дахин сэргээсэн, дахин сэргээгүй тухай шийдвэр, 10.12.3 зүйлийн хүрээнд гаргасан шийдвэр, допингийн эсрэг байгууллага 15 дугаар бүлгийн хүрээнд гаргасан бусад допингийн эсрэг байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тухай шийдвэрийг 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу давж заалдаж болно.

13.2.1 Олон улсын зэрэглэлийн тамирчид болон олон улсын тэмцээнийг хамруулсан давж заалдах ажиллагаа

Олон улсын уралдаан тэмцээнээс үүссэн буюу эсвэл олон улсын хэмжэний тамирчид оролцсон хэрэг маргаантай холбоотой шийдвэрийг Спортын арбитрын шүүх (САШ)-д давж заалдаж болно.

13.2.1-ийн тайлбар: хууль заасны дагуу арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон цуцлахтай холбоотой хянан хэлэлцэх асуудал үүсэхээс бусад тохиолдолд САШ-аас гарах шийдвэр эцсийнх байна.

13.2.2 Бусад тамирчин болон бусад этгээдийг хамруулсан давж заалдах ажиллагаа

13.2.1-ийг хэрэглэхгүй тохиолдлуудад Допингийн эсрэг үндэсний байгууллагаас баталсан журмын дагуу хараат бус тэгш байдлаар үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий байгууллагад давж заалдаж болно. Ийнхүү давж заалдахдаа дараах зарчмыг мөрдлөг болгоно.

- цаг тухайд нь хянан хэлэлцэх ажиллагаа явуулах
- шударга, тэгш байгууллага байх
- тухайн этгээдийн өөрийн зардлаар тусгай төлөөлөгчөөр төлөөлүүлэх эрхийн баталгааг хангах

- үндэслэл бүхий шийдвэрийг цаг тухайд нь бичгэн хэлбэрээр гаргана

13.2.2-ын тайлбар: Энэ зүйлийн зорилготой нийцүүлэх үүднээс Допингийн эсрэг байгууллагууд нь энэ бүлгийн дагуу САШ руу шууд давж заалдахаар сонголт хийж болно.

13.2.3 Давж заалдах эрх бүхий этгээд

13 дугаар зүйлийн 2.1-д заасан хэргийн хувьд дараахь этгээдүүд Спортын арбитгын шүүхэд давж заалдах эрх эдэлнэ: (a) давж заалдаж буй шийдвэрт холбогдох тамирчин болон бусад этгээд, (b) хэргийн төлөө тал (c) шийтгэл оногдуулах холбогдох Олон улсын холбоо, (d) Тухайн этгээдийн харъяалалтай эсвэл оршин суугаа улсын үндэсний допингийн эсрэг байгууллага (e) Олон улсын Олимпийн Хороо, Олон улсын паралимпийн хороо: Олимпийн наадам болон паралимпийн наадамтай холбоотой олимпийн наадам, паралимпийн наадамд оролцох эрх сэргээгдэх зэрэг шийдвэр (f) ДДЭА

13.2.2-д заасан хэргийн хувьд Допингийн эсрэг үндэсний байгууллагаас баталсан журмын дагуу үндэсний хэмжээний давж заалдах эрх бүхий байгууллагад давж заалдах эрх бүхий талуудад дараах этгээдүүд багтана: (a) давж заалдаж буй шийдвэрт холбогдох тамирчин болон бусад этгээд, (b) хэргийн нөгөө тал, (c) холбогдох Олон улсын холбоо, (d) Тухайн этгээдий харъяалалтай эсвэл оршин суугаа улсын үндэсний допингийн эсрэг байгууллага (e) Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олимпийн наадам болон паралимпийн наадамтай холбоотой болон олимпийн наадам болон паралимпийн наадамд нөлөөлөх эрхтэй холбоотой шийдвэр гарсан үед (f) ДДЭА. 13.2.2-д заасан хэргийн хувьд ДДЭА, Олон улсын Олимпийн Хороо, Олон улсын паралимпийн хороо болон харъяалах Олон улсын холбоод нь үндэсний хэмжээний давж заалдах эрх бүхий байгууллагын шийдвэрийг САШ-д давж заалдах эрхтэй. САШ- хэргийг хянан хэлэлцүүлэх хүсэлт гаргасан этгээд бүр шийдвэрийг нь давж заалдаж байгаа допингийн эсрэг байгууллагаас шаардлагатай мэдээллийг авах эрхтэй. Ийм тохиолдолд уг мэдээллүүдийг шууд САШ-д илгээнэ.

ДДЭАаас давж заалдах эцсийн хугацаа нь:

- (a) Аль нэг тал давж заалдах хүсэлт гаргасаны сүүлийн өдрөөс хойш хорин нэг хоног
- (b) ДДЭА шийдвэртэй холбогдох бичиг баримтыг бэлтгэж дууссанаас хойш хорин нэг хоног

Өөрөөр заасан ч байсан түр түтгэлзэх шийдвэрийг зөвхөн түр түтгэлзэх шийтгэл авсан тамирчин эсвэл бусад этгээд давж заалдах эрхтэй.

13.2.4 Шууд болон бусад зөвшөөрөгдсөн нэмэлт давж заалдах эрх

Дүрмийн хүрээнд САШ-д ирүүлсэн тохиолдолд аливаа хариуцагчийн шууд гомдол ба нэмэлт давж заалдах гомдлыг тусгайлан зөвшөөрнө. 13 дугаар бүлгийн дагуу давж заалдах эрх бүхий аливаа тал талуудыг сүүлийн хариулт өгөх бүрд шууд болон нэмэлт давж заалдах гомдлыг баримтжуулах шаардлагатай.

13.2.4-ийн тайлбар: 2011 оноос САШ өөрийн дүрмийн дагуу тамирчны давж заалдах эрх бүхий хугацаа дууссаны дараа допингийн эсрэг байгууллагын давж заалдах шийдвэр гарсан үед шууд гомдол гаргах богино хугацааны эрх олгож байгаатай холбоотойгоор энэ зүйл

шаардлагатай болж байна. Энэ зүйл нь бүх талуудад хэргийг бүрэн хянан хэлэлцүүлэх эрх олгож байгаа болно.

13.3. Допингийн эсрэг байгууллагын цагтаа гараагүй шийдвэрийн алдаа

Онцгой тохиолдолд Допингийн эсрэг байгууллага допингийн эсрэг дүрмийн зөрчил гарсан талаар шийдвэрийг ДДЭА аас тогтоосон эцсийн хугацаанд багтаж гаргахгүй тохиолдол бий. Иймд тохиолдолд ДДЭА шууд САШ-д давж заалдана. Хэрэв САШ-ын хянан хэлэлцэх баг допингийн эсрэг зөрчлийг нь тогтоож ДДЭА шууд давж заалдах үйл ажиллагаанд оролцсон бол өмгөөлөгч болон шүүх үйл ажиллагаанд ДДЭА-аас зарцуулсан зардлыг допингийн эсрэг байгууллага ДДЭА-т буцаан төлнө.

13.3-ийн тайлбар: Допингийн эсрэг дүрмийн зөрчлийг хянан хэлэлцэх болон үр дүнгийн зохицуулалтын үйл ажиллагаанд учрах янз бүрийн шалтгааны улмаас ДДЭА нь САШ –т шууд давж заалдахын тулд Допингийн эсрэг байгууллагад шийдвэр гаргах хатуу хугацаа тогтоох нь зохимжгүй. Харин ямар нэг арга хэмжээ авахаас өмнө ДДЭА допингийн эсрэг байгууллагатай зөвлөлдөж, яагаад шийдвэр одоог хүртэл гарахгүй байгаа талаар тайлбарлах боломж олгоно.Түүнчлэн энэ заалт нь олон улсын холбооны гишүүн холбоо нь яагаад үр дүнгийн зохицуулалтын дүнг оройтуулж байгаа талаар дүгнэлт өгөх тухай журмыг хориглодоггүй.

13.4 Эмчилгээний зориулалтаар хэрэглэх зөвшөөрөлтэй холбоотой давж заалдах

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг 4.4 зүйлд заасны дагуу онцгойлон давж заалдаж болно.

13.5 Давж заалдсан тухай шийдвэрийг мэдэгдэх

Аливаа допингийн эсрэг байгууллага 13.2.3-т заасны дагуу тамирчин, бусад этгээд болон допингийн эсрэг бусад байгууллагад 14.2-т заасны дагуу даруй мэдэгдэнэ.

13.6 Дүрмийн гурав, дөрөвдүгээр хэсгийн хүрээнд үүсэх үр дагавартай холбоотой шийдвэрийг давж заалдах

Энэхүү дүрмийн 23.5.4-д заасны дагуу дүрэм мөрдөөгүй тухай ДДЭА –ийн тайлантай холбоотой, эсвэл гурав дахь хэсэг (үүрэг болон хариуцлага)-ийн үр дагавар учруулсантай холбогдуулан тухайн үр дагавар учруулсан этгээд нь түүнд хамаарах журмын дагуу САШ-д давж заалдах эрх эдэлнэ.

13.7 Лабораторийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох тухай шийдвэрийг давж заалдах

ДДЭА-аас лабораторийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, эсвэл хүчингүй болгохтой холбоотой шийдвэрийг гагцхүү тухайн лабораториос САШ-д хандаж давж заалдах боломжтой.

13 дугаар бүлгийн тайлбар: Тухайн хэрэг маргааныг эцсийн шатанд шударга бөгөөд ил тод шийдвэрлэхэд энэхүү дүрмийн зорилт оршино. Допингийн эсрэг байгууллагууд нь өөрсдийн дүрэм, журмыг 14 дүгээр зүйлд нийцүүлэн ил тодоор батлан гарах ётсой. Тусгай этгээд, эсвэл ДДЭА зэрэг байгууллагууд тухайн шийдвэрийг давж заалдаж болно. Давж заалдах эрхээр хангагдсан ашиг сонирхол бүхий этгээдүүд болон байгууллагуудын тухай тодорхойлолтод бусад тамирчны эрхийн хасалтаас үр шим хүртэх магадлалтай тамирчид болон тэдгээрийн холбоодыг оруулахгүй.

14 ДҮГЭЭР БҮЛЭГ: НУУЦЛАЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ

Гарын үсэг зурагч этгээдүүд нь Допингийн эсрэг шинжилгээний үр дүн, түүнийг нийтэд ил болгох болон үүнтэй холбоотой аливаа хариуцлагыг хүлээн зөвшөөрөх бөгөөд дор дурдсан байдлаар бүх тамирчин болон бусад этгээдийн хувийн нууцыг хүндэтгэнэ.

14.1 Сөрөг аналитик илэрц, гаж илэрц болон Допингийн эсрэг журмын бусад батлагдсан зөрчилтэй холбоотой мэдээлэл

14.1.1 Допингийн эсрэг дүрмийн зөрчлийг тамирчин болон бусад хүмүүст мэдээлэх

Допингийн эсрэг дүрмийн батлагдсан зөрчлийг мэдээлэх хэлбэр, төрлийг үр дүнгийн удирдлагыг хариуцаж байгаа допингийн эсрэг байгууллагын дүрмээр зохицуулна.

14.1.2 Допингийн эсрэг дүрмийн зөрчлийг Үндэсний допингийн эсрэг байгууллага, Олон улсын холбоо, ДДЭА-т мэдэгдэх

Үр дүнгийн удирдлагыг хариуцаж буй допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг дүрмийн зөрчлийг баталсан тухай мэдэгдлийг тамирчин болон бусад этгээд болон тамирчны харьяалах допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоо, ДДЭА-т нэгэн зэрэг хүргүүлнэ.

14.1.3 Допингийн эсрэг дүрмийн зөрчлийн тухай мэдэгдлийн агуулга

Мэдэгдэл нь дараахи мэдээллийг агуулна. Үүнд: тамирчны нэр, улс, спорт, төрөл, тамирчны зэрэглэл, шинжилгээ тэмцээний эсвэл тэмцээний бус үед хийгдсэн эсэх, дээж авсан өдөр, лабораторийн хариу, болон Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартад шаардсан бусад мэдээлэл, эсвэл 2.1 зүйлд зааснаас бусад зөрчлийн хувьд уг дүрэм зөрчигдсөн ба зөрчлийг баталсан үндэслэлийг баталсан мэдээлэл зэрэг болно.

14.1.4 Мэдээллийн төлөв

14.1.1 зүйлийг даган мөрдөх зорилгоор допингийн эсрэг дүрмийн зөрчилд хийж буй мөрдөн шалгалт үргэлжилж байгаагаас бусад тохиолдолд Допингийн эсрэг байгууллага нь 14.1.2 зүйлийг удирдлага болгон 7, 8 13 дугаар зүйл (давж заалдах)-үүдийн дагуу аливаа ажиллагаа буюу хяналтын ажиллагаа явагдсаны дагуу ижил этгээдийн талаар буюу Допингийн эсрэг байгууллагуудын байр суурь болон шинэ илэрцийн талаархи мэдээлэл

байнга шинэчлэгдэж байх ёстой бөгөөд шийдвэрийн шалтгааны талаар үндэслэл бүхий тайлбарыг бичгээр үйлдэн хүргүүлнэ.

14.1.5 Нууцлал

Допингийн эсрэг байгууллагаас Допингийн эсрэг шинжилгээний үр дүнгийн талаар албан ёсоор олон нийтэд мэдээлэл хийх ёстой бөгөөд 14.3 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэх боломжгүй болсноос бусад үед хэргийн талаар мэдэх эрх бүхий хүлээн авч буй байгууллага нь (үндэсний олимпийн хороо, Үндэсний холбоод, багийн спортын төрлийн багууд) мэдээллийг тухайн мэдээллийг олон нийтэд түгээхийг хориглоно.

14.1.5-ийн тайлбар:

Допингийн эсрэг байгууллага бүр нууц мэдээллийг хамгаалах, мөрдөн шалгах болон нууц мэдээллийг задруулсан ажилтан, төлөөлөгчдөө хариуцлагатооцох зохицуулга бүхий өөрийн дүрэмтэй байна.

14.2 Допингийн эсрэг дүрмийн зөрчлийн шийдвэрийг мэдэгдэх болон баримт хүсэх

14.2.1 10.4,10.5,10.6,10.12.3 13.5 заалтыг дагаж мөрдөх хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийн тухай шийдвэрт уг шийдвэрийг гаргасан тухай бүрэн тайлбар, дээд хэмжээний шийтгэлийг оноогоогүй үндэслэлийг тусгана. Шийдвэр нь англи, франц хэлээр гараагүй тохиолдолд допингийн эсрэг байгууллага нь товч агуулга, шалтгааныг англи франц хэлээр орчуулан хүргүүлнэ.

14.2.2 Допингийн эсрэг байгууллага нь 14.2.1-ийн дагуу шийдвэр хүлээн авсан болон шийдвэр гаргахад хэрэгтэй бүрэн материалын хуулбар авах хүсэлтийг хүлээн авснаас 15 хоногийн дотор давж заалдах эрхтэй.

14.3 Олон нийтэд мэдээлэх

14.3.1 Дээжийн шинжилгээнээс сөрөг аналитик илэрц гарсан буюу Допингийн эсрэг бусад журам зөрчсөнд тооцогдож буй тамирчин болон бусад этгээдийн талаархи мэдээллийг шинжилгээний үр дүнгийн зохицуулалт хийх үүрэг бүхий Допингийн эсрэг байгууллагаас 7.3, 7.4, 7.5, 7.6, 7.7 дахь хэсгүүдэд заасны дагуу тамирчин, болон бусад этгээдд мэдэгдсэний дараа олон нийтэд мэдээлж болно.

14.3.2 8 дугаар зүйлд заасны дагуу 13.2.1, 13.2.2 зүйлийг үндэслэн давж заалдах шатны эцсийн шийдвэр гарсан эсвэл тухайн хянан хэлэлцэх ажиллагааг цуцалсан, Допингийн эсрэг журам зөрчигдсөн эсэхийг тогтоосон, эсвэл Допингийн эсрэг журмын зөрчилтэй холбоотой маргааныг цуг тухайд нь гаргаж тавиагүй зэрэг асуудалд дээрхи шийдвэр гарснаас хорь хоногоос хэтрэхгүй хугацаанд үр дүнгийн зохицуулалтын үүрэг бүхий Допингийн эсрэг байгууллагаас тухайн Допингийн эсрэг зөрчлийн талаар спорт, допингийн эсрэг дүрмийн зөрчил, тамирчны болон бусад этгээдийн нэр, хориотой бодис, хориотой арга, оноогдох шийтгэл зэрэг мэдээллийг олон нийтэд өгнө. Түүнчлэн ижил допингийн эсрэг байгууллага хорь хоногийн дотор давж заалдсан үр дүнгийн тухай дээрхи мэдээллийг багтаасан шийдвэрийг олон нийтэд өгнө.

14.3.3 Хянан хэлэлцэх болон давж заалдах шатны шийдвэрээр тамирчин болон бусад этгээдийн допингийн эсрэг дүрмийг зөрчөөгүй болохыг нотолсон аль ч тохиолдолд энэ тухай мэдээллийг зөвхөн тамирчин болон уг шийдвэртэй хамаатай бусад этгээдийн зөвшөөрлөөр нийтэд түгээнэ. Үр дүнг зохицуулах үүрэг бүхий допингийн эсрэг байгууллага зөвшөөрөл авах талаар бүх талын чармайлт гаргах бөгөөд , авсан тохиолдолд тамирчны болон бусад этгээдийн баталснаар шийдвэрийн дүнг эмхтгэн хэвлэн нийтэлнэ.

14.3.4 Мэдээллийг допингийн эсрэг байгууллагын вэб хуудсан дээр байрлуулах ба эрх хасах шийтгэлийн хугацааны дурын үед 1 сараас доошгүй хугацааны турш байршуулна.

14.3.5 Тамирчин болон бусад этгээд, түүний төлөөлөгчид хамааралтай олон нийтийн хүсэлтэнд хариу өгөхөөс бусад тохиолдолд Допингийн эсрэг байгууллага, ДДЭА эсвэл албан ёсны этгээд хүлээгдэж буй аливаа тусгай баримтын (үйл ажиллагааны ерөнхий тодорхойлолт ба ур чадварын эсрэг) талаар тайлбар хийхийг хориглоно.

14.3.6 Насанд хүрээгүй этгээд допингийн эсрэг дүрмийн зөрчил гаргасан нь илэрсэн бол 14.3.2-т зааснаар нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хийх шаардлагагүй. Насанд хүрээгүй этгээдтэй хамааралтай нийтэд мэдээлэх аливаа үйл ажиллагааг тухайн тохиолдлын баримт, шалтгаанаас хамааруулан хийнэ.

14.4 Статистик тайлан

Дор хаяж жилд нэг удаа Допингийн эсрэг байгууллагууд нь өөрсдийн Допингийн хяналттай холбоотой статистик тайланг хэвлүүлэн олон нийтэд хүртээмжтэй болгох бөгөөд мөнхүү тайланг дахин нэг хувь үйлдэж ДДЭА руу хүргүүлнэ. ДДЭА хамгийн багадаа жил бүр допингийн эсрэг байгууллага, лабораториос хүлээн авсан статистик тайлангийн эмхтгэлийг хэвлэнэ.

14.5 Допингинд тавигдах хяналттай холбоотой мэдээллийн төв

Олон улсын болоод үндэсний зэрэглэлийн тамирчид, шинжилгээний санд бүртгэлтэй байршлын тухайн мэдээлэл, тамирчдын биологийн паспортын мэдээллийг багтаасан Допингийн хяналтын шинжилгээний мэдээлэл болон үр дүнг хадгалах үүргийг ДДЭА хүлээнэ. Шинжилгээ авах төлөвлөлтийг хялбарчлах буюу Допингийн эсрэг байгууллагуудаас авах шинжилгээнд хамааруулах шаардлагагүй мэдээллүүдийг цэгцлэх зорилгоор Допингийн эсрэг байгууллага бүр тэмцээний үеэр эсвэл тэмцээний дараах шинжилгээний үр дүнг ADAMS болон ДДЭА-аас баталсан бусад системийг ашиглан аль болох түргэн хугацаанд ДДЭА руу илгээнэ. Шаардлагатай тохиолдолд зохих дүрмийн дагуу тамирчин, үндэсний допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоо, тамирчнаас шинжилгээ авах эрх бүхий бусад допингийн эсрэг байгууллагууд дээрхи мэдээллээр хангагдана.

Допингийн хяналтын шинжилгээ болон үр дүнгийн удирдлагын шийдвэр гаргахад зориулан мэдээллийн төвийг ашиглах боломжтой бөгөөд ДДЭА хувийн нууцыг хадгалах зарчимд тулгуурлан бүтээгдсэн мэдээллийн сангийн удирдлагын хэрэгсэл ADAMS-ийг хөгжүүлнэ. ДДЭА нь өөртөө болон ADAMS ашигладаг бусад байгууллагуудад

ашиглахад зориулагдсан хувийн нууцтай холбоотой дүрэм журам, шалгуурыг хангасан системийг боловсруулан хөгжүүлнэ. ДДЭА нь Канад улсын нууцлалын байгууллагын удирдлага дор тамирчин, тамирчин дэмжигч этгээд, допингийн эсрэг үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хариуцах ба хувийн нууц ба хувийн мэдээллийг хамгаалах олон улсын стандартын дагуу чандлан нууцлана.

14.6 Мэдээллийн нууцлал

Допингийн эсрэг байгууллага нь дүрэм болон олон улсын стандарт (Хувийн нууц болон хувийн мэдээллийг хамгаалах олон улсын стандарт багтана), холбогдох хуулийн хүрээнд допингийн эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага гарсан тохиолдолд хэрэглэх тамирчин болон бусад этгээдтэй хамааралтай, хувийн мэдээллийг цуглуулж, хадгалах, боловсруулж, олон нийтэд түгээж болно.

14.6 ийн тайлбар: Дүрмийн 22.2-т “Засгийн газар бүр допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллах мэдээлэл хуваалцах болон дүрмэнд зааснаар допингийн эсрэг байгууллагууд мэдээллээ хуваалцах боломж олгох зорилгоор хууль, эрх зүй, зохицуулга, бодлого, удирдлагын загварыг батлана” гэж заасан.

15 ДУГААР БҮЛЭГ: ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЛЭХ БА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

15.1 13 дугаар зүйлд давж заалдах эрхийн талаар тодорхойлсны дагуу шинжилгээ, гарын үсэг зурагч этгээдээс хийж буй хэрэг хянан хэлэлцэх, эсвэл өөрийн эрх хэмжээний хүрээнд энэхүү дүрэмд нийцүүлэн хийж буй аливаа эцсийн ажиллагааг дэлхийн хэмжээнд мөрдөх ба бусад гарын үсэг зурагч этгээдүүд хүлээн зөвшөөрч хүндэтгэнэ.

15.1-ийн тайлбар: Эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг допингийн эсрэг бусад байгууллага хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг 4.4 зүйл болон эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартад тодорхойлсон.

15.2 Гарын үсэг зурагч этгээдүүд, энэхүү дүрмээр зохицуулаагүй ч гэсэн бусад байгууллагуудаас батлан гаргасан хэмжигдэхүүнүүд нь энэхүү дүрэмд өөр бусад байдлаар нийцсэн тохиолдолд тэдгээрийг хүлээн зөвшөөрнө.

15.2-ийн тайлбар: Дүрмийг хүлээн зөвшөөрөөгүй байгууллагын шийдвэрийн зарим хэсэг нь дүрэмтэй нийцсэн, зарим нь нийцээгүй тохиолдолд гарын үсэг зурагчид нь уг шийдвэрийг дүрмийн зарчимд нийцүүлэхийг хичээнэ. Жишээ нь: Жишээ нь дүрмийг хүлээн зөвшөөрөөгүй байгууллага тамирчны бие хориотой бодис илэрсэнтэй холбоотой допингийн эсрэг дүрмийн зөрчил илрүүлсэн ч шийтгэлийн хугацааг дүрэмд зааснаар богино байхаар шийдсэн бол бүх гарын үсэг зурагчид допингийн эсрэг дүрмийн зөрчил илэрснийг хүлээн зөвшөөрөх ба допингийн эсрэг байгууллага хянан хэлэлцэх үйл ажиллагааг 8 дугаар бүлгийн дагуу зохион байгуулж, дүрмийн дагуу шийтгэлийн хугацааг уртсгах эсэхийг тогтооно.

16ДУГААР БҮЛЭГ: СПОРТЫН УРАЛДААНД ОРОЛЦОЖ БУЙ АМЬТАНД ХАМААРАХ ДОПИНГИЙН ХЯНАЛТ

16.1 Аливаа уралдаан тэмцээнд амьтан оролцуулж байгаа тохиолдолд тэмцээнийг зохион байгуулж буй Олон улсын холбоо нь тухайн амьтны хувьд Допингийн эсрэг журам баталж хэрэгжүүлнэ. Тухайн журамд, хориглосон бодисын жагсаалт, зохих шинжилгээний журам болон дээжээс шинжилгээ хийх зөвшөөрөл бүхий лабораториудын жагсаалтыг тусгасан байна.

16.2 Допингийн эсрэг зөрчлийг шийдвэрлэхтэй холбогдуулан, зохицуулалтын журам, хянан хэлэлцэх ажиллагааг шударгаар явуулах, үр дагавар болон спортын уралдаан тэмцээнд амьтан оролцсон зэрэг асуудлыг энэхүү дүрмийн 1, 2, 3, 9, 10, 11, 13 болон 17 дугаар зүйлүүдэд ерөнхий байдлаар нийцсэн журам батлах замаар зохицуулна.

17ДУГААР БҮЛЭГ: ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

Тамирчин болон бусад этгээд 7 дугаар бүлэгт заасны дагуу допингийн эсрэг дүрэм зөрчсөн тухай мэдэгдэл хүлээн авсан эсвэл дүрэм зөрчигдсөн нь батлагдсан өдрөөс хойш арван жилийн дотор тодорхой шалтгааны улмаас эхлээгүйгээс бусад тохиолдолд тамирчин болон бусад этгээдийн эсрэг ямарваа нэгэн үйл ажиллагаа эхлүүлж болохгүй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

БОЛОВСРОЛ, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА

18 ДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ

18.1 Тулгуур зарчим болон үндсэн зорилго

Допинггүй спортын төлөө мэдээлэл болон боловсролын хөтөлбөрийн үндсэн зарчим нь энэхүү дүрмийн танилцуулга хэсэгт тодорхойлогдсон спортын үзэл санааны мөн чанарыг Допингийн нөлөөнд автахаас урьдчилан сэргийлэхэд оршино. Үндсэн зорилго нь тамирчдыг санаатай болон санамсаргүйгээр хориглосон бодис болон хориглосон арга хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Мэдээлэх хөтөлбөр нь 18.2 зүйлд тодорхойлсон суурь мэдээллээр тамирчныг хангахад чиглэгдэнэ. Боловсролын хөтөлбөр нь урьдчилан сэргийлэх зорилготой. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг тамирчин, тамирчинг дэмжигч ялангуяа залуу тамирчдад чиглэсэн сургуульд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрөөр дамжуулан үнэ цэнэтэй болгоно.

Допингийн эсрэг байгууллага бүр мэдээлэл, боловсрол, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах бөгөөд түүний хэрэгжилтийг хангах болон түүнд үнэлэлт дүгнэлт хийнэ.

18.2 Хөтөлбөр болон үйл ажиллагаа

Энэхүү хөтөлбөр нь оролцогчдод дор хаяж дараахь асуудлаар хамгийн сүүлийн үеийн мэдээлэл өгнө:

- Хориглосон жагсаалт бүхий бодис болон арга
- Допингийн эсрэг дүрмийн зөрчил
- Допинг хэрэглэсэн үед эрүүл мэндэд учруулж болох үр дагавар
- Допингийн хяналтын үйл явц
- Тамирчны эрх үүрэг
- Эмчилгээний зорилгоор чөлөөлөх
- Этгээдсний нэмэлт тэжээлийн эрсдлийг удирдах
- Спортын үзэл санаанд допингийн учруулах хор
- Байршлын тухай бодит мэдээлэл

Энэхүү хөтөлбөрөөр Допингийн эсрэг хүчтэй нөлөөлөх орчныг бий болгох, тамирчин, бусад этгээдийн сонголтонд удаан хугацаанд эерэг нөлөө үзүүлэх гэсэн спортын үзэл санааг хөхиүлэн дэмжинэ.

Урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь хөгжлийнхөө шатанд байгаа залуу тамирчид, сургууль, спортын клуб, эцэг эх, насанд хүрсэн тамирчид, спортын зүтгэлтнүүд, дасгалжуулагчид, эмнэлгийн албаныхан хэвлэл мэдээллийнхэнд зориулагдана.

Тамирчныг дэмжигч этгээд нь Допингийн эсрэг бодлого болон дүрмийг дагахад тамирчинд туслахад зориулж өөрийгөө боловсруулна.

Гарын үсэг зурагч бүр тамирчин ба, тамирчныг дэмжигч этгээдийг допингийн эсрэг боловсролын хөтөлбөрт идэвхитэй оролцоог дэмжинэ.

18.2-ийн тайлбар: Допингийн эсрэг мэдээлэл, боловсролын хөтөлбөр нь олон улсын болон Үндэсний зэрэглэлийн тамирчдад хязгаарлалтгүй хэрэгжинэ. Хөтөлбөр нь дүрмийг хүлээн зөвшөөрөгч аливаа гарын үсэг, зурагч байгууллага, засгийн газрын эсвэл спортын байгууллагын удирдлага дор тэмцээнд оролцож байгаа залуу тамирчид зэрэг бүх хүнийг хамруулна. (Тамирчны тодорхойлолтыг үз.) Хөтөлбөр нь тамирчинг дэмжигч этгээдэд хамааралтай.

Эдгээр зарчим нь боловсрол, сургалтыг хүндэтгэх ЮНЕСКО-гийн конвенцийн бүрэлдэхүүн хэсэг болно.

18.3 Үйл ажиллагааны мэргэжлийн дүрэм

Бүх гарын үсэг зурагчид дүрэмд заасан допингийн эсрэг үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны сайн дадлага хийх, ёс зүйг төлөвшүүлэх, мэргэжлийн дүрэм хэрэгжүүлэх зорилгоор өөр хоорондоо болон засгийн газрын холбогдох байгууллага, мэргэжлийн холбоод, хүрээлэнгүүдтэй хамтарч ажиллана.

18.4 Удирдлага болон хамтын ажиллагаа

ДДЭА нь өөрийн болон допингийн эсрэг байгууллагын хөгжүүлж буй хөтөлбөр, мэдээллийн нөөцөд зориулж төвлөрсөн мэдээлийн төв байгуулах арга хэмжээ авна.

Бүх Гарын үсэг зурагч, тамирчин, бусад этгээд допинг эсрэг үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох, туршлагаа хуваацах, спорт дахь допингоос сэргийлэх хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх зорилгоор өөр хоорондоо болон засгийн газруудтай хамтран ажиллана.

19 ДҮГЭЭР БҮЛЭГ: ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА

19.1 Допингийн эсрэг судалгааны зорилго зорилт

Допингийн эсрэг судалгаа нь Допингийн хяналтын хүрээнд үр өгөөж бүхий хөтөлбөр боловсруулах болон түүний хэрэгжилтийг хянах, түүнчлэн Допингийн эсрэг аливаа боловсрол, мэдээлэл цуглуулахад ач холбогдолтой.

Гарын үсэг зурагч бүр судалгааны ажлыг идэвхижүүлэх, урамшуулах, дүрмийн зарчмуудад нийцсэн зорилгыг ханган биелүүлэхэд хэрэглэх судалгаа хийх бүх боломжит арга хэрэгсэлийг ашиглах зорилгоор өөр хоорондоо, засгийн газруудтай хамтран ажиллана.

19.2 Судалгааны төрөл

Допингийн эсрэг судалгааны төрөлд социологийн, зан үйлийн, хууль эрх зүйн болон ёс суртахууны зэрэг судалгааг анагаахын, аналитикийн болон сэтгэл зүйн дагаж мөрдөх ажиллагаанд хавсарга маягаар оруулж болно.

Физиологийн ба сэтгэл зүйн шинжлэх ухааны үндэстэй сургалтын хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх судалгааны ажил нь дүрэмд заасан зарчим болон шударга ёсыг баримталсан байхаас гадна шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд бий болж байгаа бодис болон аргын талаар судалгаа хийгдэнэ.

19.3 Судалгааны удирдлага ба үр дүнг мэдээлэх

ДДЭА Допингийн эсрэг судалгааны удирдлага зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Оюуны өмчийн эрхийн дагуу Допингийн эсрэг судалгааны үр дүнгийн хуулбарыг ДДЭА-т илгээх ба зохих гарын үсэг зурагчид болон тамирчин, бусад сонирхолын бүлгүүд түүнийг ашиглаж болно.

19.4 Судалгааны талаархи практик

Допингийн эсрэг судалгаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны практикт нийцнэ.

19.5 Хориглосон бодис болон хориглосон арга барилын удирдлага, зохицуулалт

Судалгааны ажлыг Хориглосон бодис болон хориглосон арга барилын удирдлага зохицуулалтыг тамирчдын эсрэг чиглэсэн байдлаар хийхээс зайлсхийнэ.

19.6 Үр дүнг хууль бусаар ашиглах

Допингийн эсрэг судалгааны үр дүнг буруугаар, эсвэл Допингийн зорилгоор ашиглахаас сэргийлэх үүднээс урьдчилан сэрэмжүүлэг өгнө.

ГУРАВДУГААР ХЭСЭГ:

ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

20 ДУГААР БҮЛЭГ: ГАРЫН ҮСЭГ ЗУРАГЧ ЭТГЭЭДҮҮДИЙН ХҮЛЭЭХ НЭМЭЛТ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

20.1 Олон улсын олимпийн хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.1.1 Энэхүү дүрэмд нийцүүлэн Олимпийн тоглолтын үеэр хэрэглэгдэх журам болон Допингийн эсрэг бодлого батлах, хэрэгжилтийг нь хангах

20.1.2 Олимпийн хөдөлгөөн дэх Олон улсын холбоодын үйл ажиллагааг энэхүү дүрэмд нийцүүлэхийг Олон улсын олимпийн хорооноос хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл болгон шаардах

20.1.3 Энэхүү дүрэмд үл нийцэх байгууллагуудын бүх буюу зарим олимпийн спортын санхүүжилтийг зогсоох

20.1.4 23.5 дахь хэсэгт заасан энэхүү дүрэмд үл нийцэх асуудлыг цаашид даамжруулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах

20.1.5 Хараат бус ажиглалтын хөтөлбөр баталж, хэрэгжилтийг нь хангах

20.1.6 Олимпийн наадамд оролцож буй бүх тамирчид болон дасгалжуулагч, сургагч, менежер, багийн штабын ажилтан, албаны хүмүүс, эмнэлгийн албаныхан, эмнэлгийн туслах ажилтан зэрэг тамирчныг дэмжигч бүх этгээдээс оролцож буй нөхцөл байдлаа дүрэмд нийцүүлэн гаргасан допингийн эсрэг дүрмийг дагаж мөрдөхийг зөвшөөрөхийг шаардах

20.1.7 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах

20.1.8 Зөвхөн засгийн газар нь ЮНЕСКО конвенцид нэгдсэн, түүнийг хүлээн зөвшөөрсөн, баталсан болон Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Паралимпийн Хороо, Үндэсний Допингийн эсрэг байгууллага нь дүрэмд нийцэж буй улсын Олимпийн наадам зохион байгуулахаар нэр дэвшүүлэх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх

20.1.9 Допингийн эсрэг боловсролыг идэвхижүүлэх

20.1.10 Үндэсний холбогдох байгууллага, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

20.2 Олон улсын паралимпийн хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.2.1 Энэхүү дүрэмд нийцүүлэн Паралимпийн олимпын тоглолтын үеэр хэрэглэгдэх журам болон Допингийн эсрэг бодлого батлах, хэрэгжилтийг нь хангах

20.2.2 Олимпын хөдөлгөөн дэх Олон улсын паралимпийн хороодын үйл ажиллагааг энэхүү дүрэмд нийцүүлэхийг Олон улсын паралимпийн хороогоор хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл болгон шаардах

20.2.3 Энэхүү дүрэмд үл нийцэх байгууллагуудын бүх буюу зарим Паралимпийн спортын санхүүжилтийг зогсоох

20.2.4 23 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан энэхүү дүрэмд үл нийцэх асуудлыг цааид даамжируулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах, болон

20.2.5 Хараат бус ажиглалтын хөтөлбөр баталж, хэрэгжилтийг нь хангах

20.2.6 Паралимпийн наадамд оролцож буй бүх тамирчид болон дасгалжуулагч, сургагч, менежер, багийн штабын ажилтан, албаны хүмүүс, эмнэлгийн албаныхан, эмнэлгийн туслах ажилтан зэрэг тамирчныг дэмжигч бүх этгээдээс оролцож буй нөхцөл байдлаа дүрэмд нийцүүлэн гаргасан допингийн эсрэг дүрмийг дагаж мөрдөхийг зөвшөөрөхийг шаардах

20.2.7 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах

20.2.8 Допингийн эсрэг боловсролыг идэвхижүүлэх

20.2.9 Үндэсний холбогдох байгууллага, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

20.3 Олон улсын холбоодын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.3.1 Энэхүү дүрэмд нийцэх журам болон Допингийн эсрэг бодлого батлан гаргаж түүний хэрэгжилтийг хангах

20.3.2 Харьяалах үндэсний холбоод болон бусад гишүүдийн баталсан бодлого, журам болон хөтөлбөр нь дүрэмд нийцсэн байх нь гишүүнчлэлийн нөхцөл болохыг шаардах

20.3.3 Өөрийн харьяалалд байдаг тамирчид болон тамирчдыг дэмжигч ажилтныг энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан Допингийн эсрэг журамд захирагдахыг шаардах

20.3.4 Хэрэв олон улсын холбоо буюу өөр бусад Спортын томоохон байгууллагуудаас аливаа уралдаан тэмцээнд оролцуулах шалгуур нөхцөл болгон тогтоосон тохиолдолд Олон улсын холбооны байнгын гишүүн бус тамирчид буюу аль нэг өөрийн гишүүн үндэсний холбоог дээж өгөх болон өөрсдийн байгаа газрын тухай мэдээллийг цаг тухайд өгөхийг шаардах

20.3.4-ийн тайлбар: Энд мэргэжлийн багийн тамирчдыг мөн хамааруулж болно.

20.3.5 Үндэсний холбоо нь зохион байгуулж байгаа тэмцээн уралдаан, үйл ажиллагаанд оролцож буй бүх тамирчид болон дасгалжуулагч, сургагч, менежер, багийн штабын ажилтан, албаны хүмүүс, эмнэлгийн албаныхан, эмнэлгийн туслах ажилтан зэрэг тамирчныг дэмжигч бүх этгээдээс оролцож буй нөхцөл байдлаа дүрэмд нийцүүлэн гаргасан допингийн эсрэг дүрэм, допингийн эсрэг байгууллагын үр дүнгийн удирдлагын эрхийг дагаж мөрдөхийг зөвшөөрөхийг шаардах

20.3.6 Үндэсний холбоо бүрээс допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотой аливаа мэдээллийг харьяалах үндэсний допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоонд өгөх ба мөрдөн шалгах эрх бүхий аливаа допингийн эсрэг байгууллагатай мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахад нь хамтран ажиллааг шаардана.

20.3.7 23.5 дахь хэсэгт заасан энэхүү дүрэмд үл нийцэх асуудлыг цаашид даамжруулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах

20.3.8 Олон улсын тэмцээн уралдааны тухай Хараат бус ажиглалтын хөтөлбөр батлах, хэрэгжилтийг нь хангах

20.3.9 Энэхүү дүрэмд үл нийцэх өөрийн гишүүн үндэсний холбоодын бүх буюу зарим спортын санхүүжилтийг зогсоох

20.3.10 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломж бүрдүүлэх болон насанд хүрээгүй этгээд болон нэг болон түүнээс дээш тамирчныг допингийн эсрэг дүрмийг зөрчихөд хүргэсэн нь илэрсэн тамирчныг дэмжигч этгээд оролцсон допингийн эсрэг дүрмийн аливаа зөрчлийн тохиолдол бүрт тамирчныг дэмжигч этгээдэд автоматаар мөрдөн шалгалт явуулах

20.3.11 Зөвхөн засгийн газар нь ЮНЕСКО конвенцид нэгдсэн, түүнийг хүлээн зөвшөөрсөн, баталсан болон Үндэсний Олимпын Хороо, Үндэсний Паралимпийн Хороо, Үндэсний Допингийн эсрэг байгууллага нь дүрэмд нийцэж буй улсад дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх өгдөг болох талаар бололцоотой бүх арга хэмжээг авах

20.3.12 Үндэсний холбоод нь үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах замаар допингийн эсрэг боловсролын үйл ажиллагааг идэвхижүүлэхийг шаардана

20.3.13 Үндэсний холбогдох байгууллага, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

20.3.14 7.10 зүйлийн дагуу ДДЭА-аас явуулж буй мөрдөн шалгалтын ажиллагаатай холбоотойгоор ДДЭА-тай бүрэн хэмжээнд хамтран ажиллах

20.3.15 Үндэсний холбоо нь олон улсын холбоо болон өөрийн эрхийн хүрээнд тамирчинд туслах бодит үндэслэлгүйгээр хориглосон бодис, хориглосон арга хэрэглэсэн тамирчныг дэмжигч этгээдээс урьдчилан сэргийлэх зорилгоор сахилгын дүрмийг батлахыг шаардана.

20.4 Үндэсний олимпын хороо болон Үндэсний паралимпын хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.4.1 Энэхүү дүрэмд тэдний Допингийн эсрэг бодлого болон журмууд нь нийцэж буй эсэхэд хяналт тавих

20.4.2 Үндэсний холбоодын Допингийн эсрэг бодлого болон журмууд нь энэхүү дүрэмд нийцсэн байх нь гишүүнээр элсүүлэх буюу хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл болохыг шаардах

20.4.3 Үндэсний допингийн эсрэг байгууллагын тухайн улс дахь бүрэн эрхт байдлыг хүндэтгэн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явцад хөндлөнгөөс оролцохгүй байх

20.4.4 Үндэсний холбоо бүрээс допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотой аливаа мэдээллийг харъяалах үндэсний допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоонд өгөх ба мөрдөн шалгах эрх бүхий аливаа допингийн эсрэг байгууллагатай мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахад нь хамтран ажиллааыг шаардана.

20.4.5 Олимпын наадам болон паралимпын наадамд оролцох нөхцлийг хангах зорилгоор дээж цуглуулахад бэлэн байлгахын тулд тухайн үндэсний холбооны байнгын бус гишүүн тамирчин нь олимпын наадам болон паралимпын наадамд оролцох нэрийн эхний мэдүүлэгт орсон бол шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартын шаардлагын дагуу байршлын тухай мэдээллийг нь аль болох хурдан илгээнэ.

20.4.6 Өөрсдийн Допингийн эсрэг үндэсний байгууллагатай хамтран ажиллах болон үндэсний допингийн эсрэг байгууллага байхгүй Үндэсний Олимпын Хороо нь Үндэсний Допингийн эсрэг байгууллагын үүргийг гүйцэтгэж байгаа тохиолдолд түүнийг байгуулахаар засгийн газартай ажиллах

20.4.6.1 Тухайн улсууд нь бүсийн допингийн эсрэг байгууллагын гишүүн бол үндэсний олимпын хороо нь засгийн газартайгаа хамтран ажиллаж бүсийн допингийн эсрэг байгууллагад идэвхитэй, туслах үүргийг гүйцэтгэнэ.

20.4.7 Үндэсний холбоо нь зохион байгуулж байгаа тэмцээн уралдаан, үйл ажиллагаанд оролцож буй бүх тамирчид болон дасгалжуулагч, сургагч, менежер, багийн штабын ажилтан, албаны хүмүүс, эмнэлгийн албаныхан, эмнэлгийн туслах ажилтан зэрэг тамирчныг дэмжигч бүх этгээдээс оролцож буй нөхцөл байдлаа дүрэмд нийцүүлэн

гаргасан допингийн эсрэг дүрэм, допингийн эсрэг байгууллагын үр дүнгийн удирдлагын эрхийг дагаж мөрдөхийг зөвшөөрөхийг шаардах

20.4.8 Допингийн эсрэг журам зөрчсөн тамирчин болон тамирчныг дэмжигч ажилтанд тэдгээрийн эрхийн хасалтын хугацаа үргэлжилж байх үед нь үзүүлэх зарим буюу бүх санхүүгийн тусламжийг зогсоох, болон

20.4.7 Энэхүү дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлээгүй хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний холбоод болон тэдгээрийн гишүүн байгууллагуудад үзүүлэх санхүүгийн тусламжийг зогсоох

20.4.8 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах

20.4.11 Үндэсний холбоод нь үндэсний допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах замаар допингийн эсрэг боловсролын үйл ажиллагааг идэвхижүүлэхийг шаардана

20.4.12 Үндэсний холбогдох байгууллага, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

20.4.13 Үндэсний холбоо нь олон улсын холбоо болон өөрийн эрхийн хүрээнд тамирчинд туслах бодит үндэслэлгүйгээр хориглосон бодис, хориглосон арга хэрэглэсэн тамирчныг дэмжигч этгээдээс урьдчилан сэргийлэх зорилгоор сахилгын дүрмийг батлахыг шаардана.

20.5 Допингийн эсрэг үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.5.1 Шийдвэр, үйл ажиллагааны хувьд бие даасан байна.

20.5.2 Энэхүү дүрэмд нийцэх журам болон Допингийн эсрэг бодлого батлан гаргаж түүний хэрэгжилтийг хангах

20.5.3 Допингийн эсрэг бусад байгууллагууд болон бусад холбогдох үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах

20.5.4 Допингийн эсрэг үндэсний байгууллагууд хамтран шинжилгээ хийх үйл ажиллагааг дэмжих,

20.5.5 Допингийн эсрэг судалгаа хийх явдлыг хөхиүлэн дэмжих

20.5.6 Допингийн эсрэг журам зөрчсөн тамирчин болон тамирчныг дэмжигч ажилтанд тэдгээрийн эрхийн хасалтын хугацаа үргэлжилж байх үед нь үзүүлэх зарим буюу бүх санхүүгийн тусламжийг зогсоох,

20.5.7 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах

20.5.8 Допингийн эсрэг боловсролыг идэвхижүүлэх

20.5.9 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломж бүрдүүлэх болон насанд хүрээгүй этгээд болон нэг болон түүнээс дээш тамирчныг допингийн эсрэг дүрмийг зөрчихөд хүргэсэн нь илэрсэн тамирчныг дэмжигч этгээд оролцсон допингийн эсрэг дүрмийн аливаа зөрчлийн тохиолдол бүрт тамирчныг дэмжигч этгээдэд автоматаар мөрдөн шалгалт явуулах

20.5.10 7.10 зүйлийн дагуу ДДЭА-аас явуулж буй мөрдөн шалгалтын ажиллагаатай холбоотойгоор ДДЭА-тай бүрэн хэмжээнд хамтран ажиллах

20.5-ийн тайлбар: Зарим жижиг улсын хувьд энэ бүлэгт тодрхойлсон хариуцлагыг Үндэсний Олимпийн Хороо нь Бүсийн допингийн эсрэг байгууллагад төлөөлж болно.

20.6 Томоохон тэмцээний зохион байгуулах байгууллага гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.6.1 Өөрсдийн зохион явуулж буй тэмцээн уралдааны үеэр хэрэглэгдэх бөгөөд энэхүү дүрэмд нийцсэн Допингийн эсрэг бодлого болон журмыг батлах, хэрэгжилтийг нь хангах

20.6.2 23.5 дахь хэсэгт заасан энэхүү дүрэмд үл нийцэх асуудлыг цаашид даамжируулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах, болон

20.6.3 Хараат бус ажиглалтын хөтөлбөр баталж, хэрэгжилтийг нь хангах

20.6.4 Тухайн тэмцээнд оролцож буй бүх тамирчид болон дасгалжуулагч, сургагч, менежер, багийн штабын ажилтан, албаны хүмүүс, эмнэлгийн албаныхан, эмнэлгийн туслах ажилтан зэрэг тамирчныг дэмжигч бүх этгээдээс оролцож буй нөхцөл байдлаа дүрэмд нийцүүлэн гаргасан допингийн эсрэг дүрмийг дагаж мөрдөхийг зөвшөөрөхийг шаардах

20.6.5 Допингийн хэрэг бүрт тамирчныг дэмжигч этгээд болон бусад этгээд хамааралтай эсэхийг мөрдөн шалгах эрхийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг сайтар шалгах

20.6.6 Зөвхөн засгийн газар нь ЮНЕСКО конвенцид нэгдсэн, түүнийг хүлээн зөвшөөрсөн, баталсан болон Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Паралимпийн Хороо, Үндэсний Допингийн эсрэг байгууллага нь дүрэмд нийцэж буй улсад том тэмцээн зохион байгуулах эрх өгдөг болох талаар бололцоотой бүх арга хэмжээг авах

20.6.7 Допингийн эсрэг боловсролыг идэвхижүүлэх

20.6.8 Үндэсний холбогдох байгууллага, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

20.7 ДДЭА-ын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

20.7.1 Энэхүү дүрэмтэй нийцсэн Допингийн эсрэг бодлого, журам батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах

20.7.2 Гарын үсэг зурагчдын дүрэмд нийцэж буйг хянах

20.7.3 Энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангахад хэрэглэгдэх Олон улсын стандартыг батлан гаргах

20.7.4 Дээжийн шинжилгээ авах лабораториудад итгэмжлэл олгох буюу бусад байгууллагад дээжийн шинжилгээ авах зөвшөөрөл олгох

20.7.5 Шилдэг практикийн загварыг боловсруулж, хэвлэн нийтлэх

20.7.6 Допингийн эсрэг судалгаа явуулах ажиллагааг хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэх, хянах болгон санхүүжүүлэх

20.7.7 Хараат бус ажиглалтын болон тэмцээний үеэр зөвлөгөө өгөх бусад хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх

20.7.8 Онцгой тохиолдол, ДДЭА-ийн ерөнхий захирлаас өгсөн чиглэл, Допингийн эсрэг бусад байгууллагуудаас санаачлан болон хүсэлт тавьсны дагуур олгосон эрхийн хүрээнд Допингийн хяналт хийх. хязгаарлагдмал буй лавлагаа өгөх, мөрдөн шалгах үүрэг бүхий үндэсний болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

20.7.8-ийн тайлбар: ДДЭА нь шинжилгээ авах байгууллага биш. Гэвч онцгой тохиолдолд, холбогдох допингийн эсрэг байгууллага хангалттай шийдэж чадаагүйгээс асуудал анхаарал татах түвшинд очсон үед өөрөө шинжилгээ авах эрхтэй.

20.7.9 Олон улсын холбоо, үндэсний допингийн эсрэг байгууллага, том наадам зохион байгуулагч байгууллагатай зөвлөлдөн шинжилгээ авах, дээж шинжлэх хөтөлбөрийг батлана.

20.7.10 Допингийн эсрэг зөрчил болон допинг хэрэглэх бусад үйл ажиллагааны үед өөрийн мөрдөн шалгалтыг санаачлан хийнэ

21 ДҮГЭЭР БҮЛЭГ: ОРОЛЦОГЧДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

21.1 Тамирчдын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

21.1.1 Энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан Допингийн эсрэг аливаа бодлого болон журмуудын талаар тодорхой мэдлэгтэй байх

21.1.2 Дээж өгөхөд хэзээд бэлэн байх

21.1.2-ийн тайлбар: Зарим тохиолдолд тамирчны хүний эрх, хувийн нууц, допингийн эсрэг үндэслэл зэргээс шалтгаалан дээжийг маш орой, эсвэл өглөө эрт авах тохиолдол бий. Тухайлбал тамирчин эпопротейныг /EPO/ бага тунгаар хэрэглэсэн тохиолдолд өглөө эрт илэрдэггүй талтайг мэдэж байх хэрэгтэй.

21.1.3 Допингийн эсрэг агуулгын хүрээнд аливаа зүйлийг хэрэглэхдээ хариуцлагатай хандах,

21.1.4 Эмнэлгийн ажилтнуудад Хориглосон бодис болон хориглосон арга барил хэрэглэхгүй байх талаар мэдээлэх бөгөөд хүлээн авсан эм бэлдмэлүүд нь энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан Допингийн эсрэг аливаа бодлого болон журмуудыг зөрчөөгүй байх талаар хариуцлага хүлээх

21.1.5 Гарын үсэг зурагч бус этгээд тамирчныг өмнөх 10 жилийн хугацаанд допингийн эсрэг дүрэм зөрчиж байсныг илрүүлсэн аливаа шийдвэрийг допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоонд мэдээлнэ.

21.1.6 Допингийн эсрэг зөрчлийн мөрдөн шалгалтыг хийхэд допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллана.

21.1.6-ийн тайлбар: Хамтран ажиллагаагүй шалтгаан нь дүрмийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчил биш байвал тэр нь сонирхолын бүлгийн дүрмийн дагуу сахилгын арга хэмжээ авах үндэслэл болж болно.

21.2 Тамирчдыг дэмжих ажилтны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

21.2.1 Тэдэнд болон тэдний дэмжлэг үзүүлэгч тамирчдад зориулан энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан Допингийн эсрэг аливаа бодлого болон журмуудын талаар тодорхой мэдлэгтэй байх

21.2.2 Тамирчны шинжилгээний хөтөлбөртэй хамтран ажилах

21.2.3 Допингийн эсрэг хандлагыг тогтооход шаардлагатай тамирчны үнэт зүйлс болон зан үйлийг төлөвшүүлэхэд өөрсдийн нөлөөг үзүүлэх

21.2.4 Гарын үсэг зурагч бус этгээд тамирчныг өмнөх 10 жилийн хугацаанд допингийн эсрэг дүрэм зөрчиж байсныг илрүүлсэн аливаа шийдвэрийг допингийн эсрэг байгууллага, олон улсын холбоонд мэдээлнэ.

21.2.5 Допингийн эсрэг зөрчлийн мөрдөн шалгалтыг хийхэд допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллана.

21.2.5-ийн тайлбар: Хамтран ажиллагаагүй шалтгаан нь дүрмийн хүрээнд допингийн эсрэг дүрмийн зөрчил биш байвал тэр нь сонирхолын бүлгийн дүрмийн дагуу сахилгын арга хэмжээ авах үндэслэл болж болно.

21.2.6 Тамирчныг дэмжигч этгээд бодит үндэслэлгүйгээр аливаа хориотой бодис эсвэл хориглосон аргыг хэрэглэхгүй эзэмшихгүй байх

21.2.6-ийн тайлбар: Тамирчныг дэмжигч этгээдийн бодит шалтгаангүйгээр хориотой бодис, хориглосон аргыг хэрэглэж, эзэмшсэн нөхцөл байдал нь дүрмийн хүрээнд допингийн эсрэг зөрчилтэй холбоогүй бол түүнийг спортын байгууллагын сахилгын дүрмийн хүрээнд авч үзнэ. Дасгалжуулагч болон бусад тамирчныг дэмжигч этгээд нь тамирчинд үлгэр дууриал болох ёстой. Тэд өөрийн хувийн үйлдлээ үүрэх хариуцлагатайгаа зөрчилдүүлэхгүй бол тамирчин нь допинг хэрэглэхгүй.

21.3 Бүсийн допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага

21.3.1 Гишүүн улс бүртээ дүрмэнд нийцүүлсэн журам, бодлого, хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх боломжоор хангах

21.3.2 Гишүүн байх нөхцлийг хангахын тулд Бүсийн допингийн эсрэг байгууллагын өмнө допингийн эсрэг асуудлыг хариуцах төлөөлөгчийн нэрийг тодорхой болгон тус байгууллагын гишүүнчлэлийн маягтанд гарын үсэг зурахыг тухайн улсаас шаардах

21.3.3 Бусад холбогдох үндэсний болон бүсийн допингийн эсрэг байгууллага, агентлаг болон бусад допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах

21.3.4 Үндэсний допингийн эсрэг байгууллага болон бүсийн допингийн эсрэг байгууллагууд харилцан шинжилгээ авах ажлыг дэмжих

21.3.5 Допингийн эсрэг судалгааны ажлыг дэмжих

21.3.6 Допингийн эсрэг боловсролыг дэмжих

22 ДУГААР БҮЛЭГ: ЗАСГИЙН ГАЗРЫН ОРОЛЦОО

Дүрмийн өмнө хүлээн засгийн газар бүрийн үүрэг нь 2003 оны 3 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Спорт дахь допингийн эсрэг Копенхагены тунхаглалд гарын үсэг зурсан болон ЮНЕСКО конвенцид нэгдэн орсон, хүлээн зөвшөөрсөн,соёрхон баталсан өдрөөс эхлэнэ. Дараахи заалтууд гарын үсэг зурагчдын үүргийг тодорхойлно.

22.1 Засгийн газар бүр ЮНЕСКО конвенцид нийцэх шаардлагатай бүх арга хэмжээг авна

22.2 Засгийн газар бүр допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох болон допингийн эсрэг байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох талаар хууль, журам, бодлого, удирдлагын загвар боловсруулж батлана.

22.3 Засгийн газар бүр төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад Допингийн эсрэг байгууллагын допингийн эсрэг тэмцэхтэй холбоотой хуульд хориглоогүй үйл ажиллагааны тухай мэдээлэл солилцохыг дэмжинэ.

22.4 Засгийн газар бүр допингтой холбоотой гаргасан шүүхийн аливаа шийдвэрийг хүний суурь эрх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүндэтгэн үзнэ.

22.5 Допингийн эсрэг байгууллага байхгүй байгаа улсын засгийн газар бүр түүнийг байгуулахаар үндэсний олимпийн хороотой хамтран ажиллана.

22.6 Засгийн газар бүр улсынхаа допингийн эсрэг байгууллагын бүрэн эрхт байдлыг хүндэтгэн үзэх бөгөөд үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтанд хөндлөнгөөс нөлөөлж болохгүй.

22.7 Засгийн газар бүр 22.2 зүйлд заасан нөхцлийг 2016 оны 1 дүгээр сарын 1-ны дотор хангах шаардлагатай. Бусад шаардлага нь хэдийнэ хангагдсан болно.

22.8 Засгийн газар бүр ЮНЕСКО конвенцид нэгдээгүй, түүнийг соёрхон батлаагүй, хүлээн зөвшөөрөөгүйгээс үүсэх алдаа эсвэл ЮНЕСКО конвенцид нийцэхтэй холбоотой 20.1.8, 20.3.11, 20.6.6-д заасны дагуу тэмцээн зохион байгуулахад нэр дэвшүүлэх боломжгүй болох ба бусад үр дагавар, тухайлбал ДДЭА дахь ажлын байр, албан тушаалын хохирол, эх орондоо олон улсын тэмцээн зохион байгуулахаар нэр дэвшүүлэх эрхээ хасуулах, олон улсын тэмцээнийг цуцлах,бэлэг тэмдэгийн чанартай болон бусад үр дагаварыг Олимпийн Хартийн дагуу зохицуулна.

22 дугаар бүлгийн тайлбар:

Ихэнхи засгийн газрууд төрийн бус гэрээ, дүрмийг мөрддөггүй. Тийм учраас дүрэмд гарын үсэг зурахыг хүсдэггүй. Харин Копенхагены тунхаглалд гарын үсэг зурах, ЮНЕСКО конвенцид нэгдэн орох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Механизмыг нь баталсан хэдий ч спортын байгууллага, засгийн газрын хоорондын нягт хамтын ажиллагааны дүнд дүрэмд нийцсэн хөтөлбөрөөр дамжуулан допингтой тэмцэхийг чармайх нь ялгаатай хэрэг юм. Энэ бүлэг нь аль гарын үсэг зурагч нь засгийн газраас нь хүлээлт үүсгэж буйг тодорхой болгоход чиглэгдэнэ. Харин Хүлээлт үүсгэх” гэдгийг зөвхөн засгийн газар нь ЮНЕСКО конвенцийн шаардлагыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэнээс хойших үеийг хамруулан ойлгоно.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, НИЙЦҮҮЛЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТАЙЛБАРЛАХ

23 ДУГААР БҮЛЭГ: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, НИЙЦҮҮЛЭХ БА ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

23.1 Дүрмийг хүлээн зөвшөөрөх

23.1.1 Дараахь этгээдүүд нь энэхүү дүрмийн Гарын үсэг зурагч талууд байна. Эдгээрт: ДДЭА, Олон улсын олимпийн хороо, Олон улсын холбоод, Олон улсын паралимпийн хороо, Үндэсний олимпийн хороо, Үндэсний паралимпийн хороо, том тэмцээний зохион байгуулах байгууллагууд болон Допингийн эсрэг үндэсний байгууллага тус тус орно. Эдгээр этгээдүүд нь тус бүрийн засгийн газраас зөвшөөрөл олгосны үндсэн дээр хүлээн зөвшөөрөх тухай тунхаглалд гарын үсэг зурснаар энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

23.1.1-ийн тайлбар: Гарын үсэг зурагч этгээд тус бүр хүлээн зөвшөөрөлтийн нийтлэг тунхгалалын стандарт маягтын хуулбар дээр гарын үсэг зурж түүнийгээ ДДЭА руу хүргүүлнэ. Хүлээн зөвшөөрөх үйлдлийг байгууллага тус бүрээс батлан гаргасан баримт бичгээр эрх олгосон хүрээгээр тодорхойлно. Тухайлбал, Олон улсын холбооны хувьд түүний Конгрессоор, ДДЭА-ын хувьд үүсгэн байгуулах зөвлөл гэх мэт.

23.1.2 Гарын үсэг зурагч этгээдийн удирдлагаас гадуурхи аливаа спортын байгууллагууд нь ДДЭА-ын урилгаар энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж болно.

23.1.2-ын тайлбар: Аль нэгэн засгийн газар буюу Олон улсын холбооны харьяалалд ороогүй тэдгээр мэргэжлийн багийн хувьд тэднийг энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлнэ.

23.1.3 ДДЭА нь хүлээн зөвшөөрсөн тухай бүхий л баримт бичгийн жагсаалтыг хэвлүүлэн нийтэд ил тод болгоно.

23.2 Дүрмийн хэрэгжилтийг хангах

23.2.1 Гарын үсэг зурагч этгээдүүд нь өөрсдийн эрх хэмжээ болон хүлээх үүргийн хүрээнд бодлого, журам, зохицуулалт батлан гаргах замаар энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангана.

23.2.2 Дараахи заалтууд нь гарын үсэг зурагчид нь допингийн эсрэг байгууллагуудын хийж буй допингийн эсрэг ажлын зорилгын хэрэгжилтийг ямар нэг өөрчлөлтгүйгээр хангахад хэрэглэгдэнэ.

- 1 дүгээр бүлэг (Допингийн тодорхойлолт)
- 2 дугаар бүлэг (Допингийн эсрэг дүрмийн зөрчил)
- 3 дугаар бүлэг (Допинг хэрэглэснийг нотлох)
- 4.2.2 заалт (Тусгай бодисууд)
- 4.3.3 заалт (Хориотой бодисын тухай ДДЭА-ын тодорхойлолт)
- 7.11 заалт (Спортоос зодог тайлах)
- 9 дүгээр бүлэг (Хувийн үр дүнг автоматаар хүчингүй болгох)
- 10 дугаар бүлэг (Хувь этгээдэд оноох шийтгэл)
- 11 дүгээр бүлэг (Багт ногдох үр дагавар)
- 13 дугаар бүлэг (Давж заалдах) 13.2.2, 13.6, 13.7 зүйлийн дагуу
- 15.1 дүгээр зүйл (Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх)
- 17 дугаар бүлэг (Хязгаарлалтын журам)
- 24 дүгээр бүлэг (Дүрмийг тайлбарлах)
- Хавсралт 1 (Тодорхойлолт)

Энэ жагсаалтаас өөр нэмэлт заалтыг энэ бүлгийг өөрчлөхөд нөлөө үзүүлэх гарын үсэг зурагчийн дүрмэнд тусгаж болохгүй. Гарын үсэг зурагчийн дүрэм нь энэхүү дүрмийн тайлбарыг тодорхой хүлээн зөвшөөрсөн байх бөгөөд уг тайлбарыг дүрмэнд заасантай ижил нөхцөлтэй байлгахад дэмжлэг үзүүлэх ёстой.

23.2.2-ийн тайлбар: Допингийн эсрэг байгууллагыг дүрмэнд заагдсан допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй хамааралгүйгээр допингтой холбогдсон тамирчин дэмжигч этгээдийн үйл ажиллагааны эсрэг өөрийн тусгай сахилгын дүрмийг баталж хэрэгжүүлэхэд саад учрулах зүйл дүрмэнд байхгүй. Тухайлбал дасгалжуулагчийн удирдлагаар олон тамирчин нь допингийн эсрэг дүрмийг зөрчсөн бол үндэсний болон олон улсын холбоо нь тухайн дасгалжуулагчийн эрхийг сэргээхээс татгалзаж болно.

23.2.3 Энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангах үүднээс, Гарын үсэг зурагч этгээдүүд нь ДДЭА-аас боловсруулан гаргасан Шилдэг практикийн загварыг хэрэглэх боломжоор хангагдана.

23.3 Допингийн эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Гарын үсэг зурагчид нь дүрэм болон олон улсын стандартад нийцэж буй бүх газар допингийн эсрэг дүрмийг хэрэгжүүлэх хангалттай нөөцийг бүрдүүлнэ.

23.4. Дүрэмтэй нийцэх

Гарын үсэг зурагчид нь 23.1, 23.2, 23.3 заалтын дагуу хүлээн зөвшөөрөх ба хэрэгжүүлэх хүртэл дүрэмд нийцэж буй эсэхийг авч үзэхгүй. Тэд нийцсэн үйл ажиллагаа явуулж байхдаа дүрмээс татгалзвал үүнийг хойшлуулалгүй анхаарч үзэх шаардлагатай.

23.5 Энэхүү дүрэмд нийцүүлэх ажиллагаанд үнэлгээ хийх

23.5.1 Дүрэмд нийцүүлэх үйл ажиллагааг ДДЭА буюу эсвэл түүнээс эрх олгосон бусад байгууллага үнэлгээ хийнэ. Допингийн эсрэг хөтөлбөр нь 23.3 дахь заалтын дагуу

дүрэмтэй нийцэж буй эсэхийг ДДЭА-ийн гүйцэтгэх зөвлөлөөс тогтоосон шалгуурын үндэслэн үнэлнэ. ЮНЕСКО конвенцоор хүлээсэн үүрэг хир ницэж байгааг засгийн газар хоорондын бага хурал засгийн газрын талууд ба ДДЭА тай дарахи зөвшилцлийг хийж үнэлгээ өгнө. ДДЭА засгийн газруудад гарын үсэг зурагчид дүрмийг хэрэгжүүлэх талаар, гарын үсэг зурагчдад засгийн газраараа ЮНЕСКО конвенцид нэгдэх, хүлээн зөвшөөрүүлэх соёрхон батлуулах талаар зөвлөнө.

23.5.2 Үнэлгээний ажлыг хялбаршуулах үүднээс Гарын үсэг зурагч этгээдүүд нь ДДЭА-ийн үүсгэн байгуулагчдийн зөвлөлөөс шаардсаны дагуу өөрсдийн үйл ажиллагаа дүрэмд нийцэж буй талаар илтгэлийг ДДЭА руу илгээх бөгөөд хэрэв үл нийцэх үйл ажиллагаа хийсэн тохиолдолд түүнийхээ учрыг мөн тайлбарлана.

23.5.3 23.5.2 заалтыг биелүүлэх зорилгоор ДДЭА-ын хүссэний дагуу гарын үсэг зурагчид тайлангаа ДДЭА-г ирүүлээгүй эсвэл дүрмийн бусад заалтын дагуу тайлангаа ДДЭА-г ирүүлээгүй бол дүрэмд нийцээгүй үйл ажиллагаа явуулсан гэж үзэж болно.

23.5.4 ДДЭА ийн дүрэмд нийцэж буй эсэх тухай бүх тайлан нь түүний үүсгэн байгуулагчдын зөвлөлөөр баталгаажна. ДДЭА дүрэмд гарын үсэг зурагчдыг нийцээгүй үйл ажиллагаа явуулсан гэж дүгнэхээс өмнө тэндтэй зөвлөлдөнө. ДДЭА ын дүрэмд нийцээгүй үйл ажиллагааны тухай ямар нэг тайлан гарын үсэг зурагчдад үүсгэн байгуулагчдад тайлбарыг бичгээр өгөх боломж олгосны дараа заавал үүсгэн байгуулагчдын зөвлөлийн хурлаар баталгаажна. ДДЭА –ын үүсгэн байгуулагчдын зөвлөлийн шийдвэрийг дүрэмд нийцээгүй үйл ажиллагаа явуулсан гэх гарын үсэг зурагч 13.6 заалтын дагуу давж заалдаж болно.

23.5.5 ДДЭА нь дүрэмд нийцэх үйл ажиллагааны талаархи тайланг Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын холбоод болон том тэмцээн зохион байгуулдаг байгууллагуудад илгээнэ. Түүнчлэн энэ тайланг олон нийтэд зоиулан бэлтгэх боломжтой.

23.5.6 ДДЭА нь дүрэмд үл нийцэх үйл ажиллагааны тайлбар ба онцгой нөхцөл байдлыг хэлэлцсэний дараа Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын холбоод болон Спортын үйл ажиллагаа зохион байгуулагч томоохон байгууллагуудад үйл ажиллагаагаа дүрэмд нийцүүлэх талаар зөвлөмж өгнө.

23.5.6-ийн тайлбар: ДДЭА гарын үсэг зурагчид ба засгийн газруудын допингийн эсрэг үйл ажиллагааны туршлага, нөөц боломж, хууль эрх зүйн баримт бичгийн ялгаатай талуудыг хүлээн зөвшөөрнө. Тухайн байгууллагын үйл ажиллагаа дүрэмд нийцэж буй эсэхийг авч үзэхдээ энэ асуудлыг анхаарна.

23.6 Үйл ажиллагааг дүрэмд нийцлүүлээгүйгээс гарах үр дагавар

Аль нэгэн гарын үсэг зурагчийн дүрэмд нийцээгүй үйл ажиллагаа нь 20.1.8 (Олон улсын Олимпийн Хороо), 20.3.11 (Олон улсын холбоо), 20.6.6 (Том тэмцээнийг зохион байгуулах байгууллага) заалтын дагуу аливаа тэмцээнийг зохион байгуулахаар өрсөлдөх эрхээ хасуулах үр дагаварыг авч ирж болзошгүй. Тухайлбал ДДЭА дахь ажлын байр, албан

тушаалын хохирол, олон улсын тэмцээнийг эх орондоо зохион байгуулахаар нэр дэвшүүлэх эрхээ алдах, олон улсын тэмцээн цуцлагдах, бэлэг тэмдэгийн чанартай болон олимпийн хартид заасан бусад хохирол.

Уг үр дагавараас шийтгэл оноосон шийдвэрийг гарын үсэг зурагчид нь энэхүү дүрмийн 13.6 дахь хэсэгт заасны дагуу САШ-т давж заалдаж болно.

23.7 Дүрэмд өөрчлөлт оруулах

23.7.1 Энэхүү дүрмийн нэмэлт болон өөрчлөлтийн талаар хяналт тавих үүргийг ДДЭА хариуцна. Эл ажиллагаанд тамирчид, бусад сонирхолын бүлэг болон засгийн газруудыг урьж оролцуулна.

23.7.2 ДДЭА нь энэхүү дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг санаачлах, зөвлөгөөнд зориулсан санал өгч авалцах ажлыг зохион байгуулах болон тэдгээртэй холбогдуулан тамирчид, бусад сонирхолын бүлэг болон засгийн газруудаас ирүүлсэн саналыг холбоогоор хэлэлцүүлэх ажлыг хөнгөвчлөх үүргүүдийг тус тус хүлээнэ.

23.7.3 Зохих хэмжээнд хүртэл зөвлөлдсөний дараа Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг нийт салбар болон Олимпийн хөдөлгөөний ихэнхи гишүүдийг оролцуулан ДДЭА-ыг үүсгэн байгуулах зөвлөлийн гишүүдийн олонхи буюу гуравны хоёрын саналаар батална. Өөрөөр заагаагүй бол тэдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь тэдгээрийг баталснаас гурван (3) сарын дараа хүчин төгөлдөр болно.

23.7.4 2015 оны дүрэм 2015 оны 1 дүгээр сарын 1 нээс үйлчилж эхлэх тул Гарын үсэг зурагч этгээд нь дүрэмтэй холбоотойгоор 2015 оны 1 сарын 1-нд эсвэл өмнө нь өөрийн дүрмэндээ өөрчлөлт оруулна. Гарын үсэг зурагчид нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг ДДЭА-ын үүсгэн байгуулах зөвлөл баталснаас хойш 1 жилийн дотор хэрэгжилтийг нь хангана.

23.8 Дүрмээс татгалзах

Гарын үсэг зурагч этгээдүүд нь энэхүү дүрмээс гарах тухай саналаа ДДЭА-т зургаан сарын өмнө бичгээр мэдэгдэл хийх хэлбэрээр хүргүүлнэ.

24 ДҮГЭЭР БҮЛЭГ: ДҮРМИЙГ ТАЙЛБАРЛАХ

24.1 Энэхүү дүрмийн албан ёсны эх бичвэрийг үйлдэх болон түүнийг англи, франц хоёр хэлээр үйлдэх үүргийг ДДЭА хариуцна. Англи болон франц хэл дээр үйлдэгдсэн эх бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи хэлийг баримтална.

24.2 Энэхүү дүрмийн зүйл болгонд хийсэн тайлбарууд нь Дүрмийг ойлгох буюу тайлбарлахад дэм болно.

24.3 Энэхүү дүрмийг бие даасан бичвэрийн хувиар тайлбарлах бөгөөд тухайн холбогдох Гарын үсэг зурагч этгээд болон засгийн газар хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт лавлагаа хэлбэрээр тайлбарлахыг хориглоно.

24.4 Энд хийгдсэн угтвар бичвэрүүд нь энэхүү дүрмийн хэсэг болон зүйлүүдийг ойлгомжтой болгох үүднээс хийгдсэн бөгөөд тэдгээрийг Дүрмийн салшгүй хэсэг болон эсвэл холбогдох заалтуудад нөлөөлөх зэрэг байдлаар ойлгож болохгүй.

24.5 Энэхүү дүрэм нь Гарын үсэг зурагч этгээдүүд түүнийг батлах, эсвэл хэрэгжилтийг нь хангахын өмнө тохиосон ямар нэгэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор буцаан хэрэглэгдэхгүй. Гэхдээ энэхүү дүрэм батлагдсанаас хойшхи гарсан хэд хэдэн зөрчлүүдэд шийтгэл оногдуулах зорилгоор энэхүү дүрмээс өмнөх Допингийн эсрэг зөрчлүүдийг “нэгдэх” болон “хоёр дахь” зөрчилд тооцож болно.

24.6 Допингийн эсрэг хөтөлбөрийн зорилго, зорилт, зохион байгуулалт ба I хавсралт (тодорхойлолт) болон II хавсралт (10 дугаар бүлгийн хэрэглэх жишээ) нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг мөн.

25 ДУГААР ЗҮЙЛ: ШИЛЖИХ ЗААЛТ

25.1 2015 Дүрмийн ерөнхий хэрэглээ

2015 дүрэм нь 2015 оны 1 дүгээр сарын 1 –ны өдрөөс хэрэглэгдэж эхэлнэ. (Үйлчлэх эхлэх өдөр)

25.2 10.7.5 зүйл, 17 дугаар бүлэг эсвэл “Lex Mitior” зарчмаас бусад тохиолдолд буцаж хэрэглэгдэхгүй байх

10.7.5-д заасан хэд хэдэн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор болон 17 дугаар бүлэгт заасан хязгаарлалтын журмын дагуу өмнөх зөрчилд буцаан хэрэглэж болно. Харин зөвхөн 17 дугаар бүлэгт заасан хязгаарлалтын журмын хугацаа нь үйлчилж эхлэх өдөр гэхэд дууссан байсан тохиолдолд хэрэглэнэ. Бусад тохиолдолд хянан шийдвэрлэх байгууллага хэргийн шалтгааны улмаас хэргийг шүүхэд “Lex Mitior” зарчмыг ашигласанаас бусад тохиолдолд үйлчилж эхлэх өдрөөс өмнө хүлээгдэж байсан допингийн эсрэг дүрмийн зөрчлийн ямар нэгэн тохиолдол ба үйлчилж эхлэх өдрийн өмнө гарч, допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн нь тухайн үед шүүхээр тогтоогдон үйлчилж эхлэх өдөр хүрсэн аль нэг хэрэгтэй холбоотойгоор дүрмийг буцаан хэрэглэхгүй.

25.3 2015 дүрмийн өмнөх шийдвэрийг хэрэглэх

Эцсийн шийдвэр нь үйлчилж эхлэх өдрөөс өмнө гарсан допингийн эсрэг зөрчлийн тохиолдлуудын хувьд үйчилж эхлэх өдрийн байдлаар шийтгэлийн хугацаа нь үргэжилж байгаа тамирчин болон бусад этгээд 2015 Дүрмийн хүрээнд шийтгэлийн хугацааг бууруулах асуудлыг авч үзэх тухай хүсэлтийг допингийн эсрэг зөрчлийн үр дүнгийн зохицуулалтыг хариуцсан допингийн эсрэг байгууллагад гаргаж болно.

Уг хүсэлт нь заавал шийтгэлийн хугацаа дуусахаас өмнө гарсан байх ёстой. Допингийн эсрэг байгууллагын шийдвэрийг 13.2 заалтын дагуу давж заалдаж болно. 2015 дүрэм нь Допингийн эсрэг дүрэм зөрчсөн тухай шийдвэрээр тогтоосон шийтгэлийн хугацаа нь дууссан допингийн эсрэг дүрмийн зөрчлийн ямар ч тохиолдолд хэрэглэгдэхгүй

25.4 Эхний зөрчил нь 2015 оны 1 дүгээр сарын 15-наас өмнө тохиолдсон хэд хэдэн зөрчил

Эхний зөрчилд оноогдсон шийтгэл нь 2015 оны дүрмээс өмнө батлагдсан үед 10.7.1 зүйл зааснаар тохиолдсон хоёр дахь зөрчлийн эрх хасах хугацааг баталгаажуулах зорилгоор эхний зөрчилд оноосон эрх хасах хугацаа нь 2015 оны дүрмэнд заагдсан байвал түүнийг хэрэглэнэ.

25.4-ийн тайлбар: 25.4-т тодорхойлсон нөхцлөөс бусад дүрмээс өмнө шийдвэр нь гарсан, 2015 дүрмээс өмнө хүчин төгөлдөр болсон допингийн эсрэг зөрчлүүд, шийтгэлийн хугацаа нь бүрэн дууссан тохиолдолд 2015 дүрмээр зөрчлийг дахин хянахгүй.

25.5 Дүрмийн бусад нэмэлт өөрчлөлтүүд

Дүрмийн бусад нэмэлт өөрчлөлтүүд нь 23.7 дахь заалтын дагуу үйлчилнэ.

ХАВСРАЛТ 1

ТОДОРХОЙЛОЛТ

ADAMS: Допингийн эсрэг захиргаа, удирдлагын систем нь мэдээлэл, оруулах, хадгалах, түгээх, тайлагнахад нууц хадгалах хуулийн дагуу допингийн эсрэг үйл ажиллагаа явуулах хүрээнд оролцогч бүлгүүд, ДДЭА-т туслах зорилго бүхий вэбэд суурилсан мэдээллийн сангийн удирдлагын хэрэгсэл

Зааварлах: Бусад этгээд хориотой бодис, хориотой арга хэрэглүүлэх, хэрэглүүлэхийг оролдох ажиллагаанд хангах, нийлүүлэх, удирдах, хөнгөвчлөх болон бусад хэлбэрээр оролцуулах. Гэхдээ энэ тодорхойлолтонд эмнэлгийн ажилтнууд зайлшгүй болон хууль ёсны эмчилгээний болон бусад үндэслэлээр хориотой бодис, хориглосон арга хэрэглэх болон тухайн хориотой бодисыг зайлшгүй болон хууль ёсны эмчилгээний зорилгоор бус спортын чадвараа сайжруулах зорилгоор хэрэглэхээр төлөвлөсөн нь нотлогдсоноос бусад тохиолдолд тэмцээний бус үед хэрэглэхийг хориглоогүй бодисыг хэрэглэх үйл ажиллагаа хамаарахгүй.

Сөрөг аналитик илэрц: ДДЭА-аас магадлан итгэмжилсэн болон батламжилсан лабораториос олон улсын лабораторийн стандарт болон бусад техникийн бичиг баримтын дагуу гаргасан дээжинд хориотой бодис, түүний дүрс хувирал шинж тэмдэг (бие үүсдэг бодисын зохих хэмжээ хэтэрсэн нь хамаарна) илэрсэн тухай тайлан эсвэл допинг хэрэглэсэн тухай нотолгоо

Паспортын сөрөг илэрц: Олон улсын стандартад тодорхойлсны дагуу паспортын сөрөг илэрц гэж тогтоосон тайлан

Допингийн эсрэг байгууллага: Допингийн хяналтын ажиллагааны аль ч хэсгийг хэрэгжүүлэх буюу түүнд холбогдох журмыг санаачлах, хэрэгжилтийг нь хангах үүрэг хүлээсэн Гарын үсэг зурагч этгээд. Эдгээрт, Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, том тэмцээн зохион байгуулдаг бусад байгууллагууд, ДДЭА, Олон улсын холбоод болон Үндэсний допингийн эсрэг байгууллага зэрэг багтана.

Тамирчин: Олон улсын (Олон улсын холбооноос тогтоосны дагуу) болон үндэсний (үндэсний допингийн эсрэг байгууллагаас тогтоосны дагуу) хэмжээний уралдаан тэмцээнүүдэд оролцогч аливаа этгээд.

Допингийн эсрэг байгууллага олон улсын болон үндэсний зэрэглэлийн бус боловч “тамирчин” гэсэн тодорхойлолтонд хамаарах этгээдэд допингийн эсрэг дүрмийг өөрийн үнэлэмжээр хэрэглэнэ. Олон улсын ба үндэсний зэрэглэлийн бус тамирчинтай холбоотойгоор Допингийн эсрэг байгууллага бүрэн ба бүрэн бус шинжилгээ авах, дээжинд хориотой бодисын цөөн үзүүлэлтийг шинжлэх, байршлын тухай хязгаарлагдмал мэдээлэл авах эсвэл мэдээлэл авахгүй байх, эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл шаардахгүй байх эсэхийг сонгож болно. Олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээнд оролцсон хэн нэгэн тамирчин дүрмийн 2.1, 2.3, 2.5 зүйлд заасан допингийн эсрэг дүрмийг

зөрчсөн бол допингийн эсрэг байгууллага дүрмэнд заасан арга хэмжээг(14.3.2-оос бусад) авах эрхтэй.

2.8 ба 2.9 заалтыг дагаж мөрдөх ба допингийн эсрэг мэдээлэл, боловсролын зорилгоор дүрмийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурагч этгээд , засгийн газар, бусад спортын байгууллагын ивээл дор оролцогч этгээдийг тамирчин гэнэ.

Тайлбар: Энэхүү тодорхойлолтын дагуу олон улсын болон үндэсний зэрэглэлийн бүх тамирчид, түүнчлэн Олон улсын холбоод болон Допингийн эсрэг үндэсний байгууллагуудаас зохион байгуулж буй олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээн уралдаан болгоныг энэхүү дүрмийн дагуу Допингийн эсрэг журмын зөрчлийн хяналтад хамруулна. Үндэсний Хэрэв Допингийн эсрэг байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд үндэсний хэмжээний тамирчдад хамаарах Допингийн хяналтын хөтөлбөрийг аливаа уралдаан тэмцээнд бага зэрэглэлийн түвшинд эсвэл бүгдэд нь бус фитнесийн үйл ажиллагаанд оролцох тамирчдад хамааруулахаар өргөтгөж болно. Тухайлбал допингийн эсрэг байгууллага сонирхогчийн түвшний оролцогчийг эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа шаардалгүйгээр шинжилгээнд дуудаж болно. Харин сөрөг аналитик илэрц гарсан, худалдаалахтай холбоотой допингийн эсрэг зөрчил илэрсэн тохиолдолд дүрмэнд заасан бүх арга хэмжээг(14.3.2-оос бусад) авна. Допингийн эсрэг байгууллага нь тэмцээнд өрсөлддөггүй боловч фитнесийн үйл ажиллагаанд оролцдог сонирхогчид ч үр дагаварын тухай шийдвэр хамаарна. Ижил нөхцөлд том наадам зохион байгуулагч байгууллага зөвхөн дээд зэрэглэлийн тамирчдаас шинжилгээ авахаар сонгож болох ба харин хориотой бодисын бүх үзүүлэлтийг бүрэн шинжлэхгүй. Аливаа уралдаан тэмцээний бүх шатанд оролцож буй тамирчдад Допингийн эсрэг зөрчлийн талаархи мэдээлэл, боловсролыг олгоно.

Тамирчны биологийн паспорт: Шинжилгээ, мөрдөн шалгалтын болон Лабораторийн олон улсын стандартад тодорхойлсон мэдээллийг цуглуулах болон харьцуулах хөтөлбөр болон арга

Тамирчныг дэмжигч этгээд: Тамирчдыг тэмцээн уралдаанд бэлтгэх буюу оролцоход нь тэдгээр тамирчидтай хамтран ажиллаж буй дасгалжуулагч, сургагч, менежер, төлөөлөгч, багийн ажилтан, албаны этгээд, эмнэлгийн болон эмнэлгийн туслах ажилтнууд, эцэг эх болон тухайн тамирчинтай хамтран ажилладаг, тэмцээнд оролцох болон бэлтгэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлдэг бусад этгээд

Оролдлого: Допингийн эсрэг журмын зөрчлийг бий болгоход чиглэсэн тодорхой зорилго бүхий бодит үйл ажиллагаа. Гэсэн хэдий ч уг Допингийн эсрэг зөрчил үйлдэх гэсэн оролдлого нь тухайн оролдлогод хамааралгүй гуравдагч этгээдийн оролцоотойгоор амжилгүй болсон буюу үүнээс болж тухайн зөрчил үйлдэх гэсэн этгээд тухайн ажиллагаагаа цуцалсан байх.

Гаж илэрц:

ДДЭА-аас магадлан итгэмжилсэн болон баталгаа олгосон лабораториос олон улсын лабораторийн стандарт болон бусад техникийн бичиг баримтын дагуу гаргасан сөрөг аналитик илэрц хэмээн тогтоохын тулд нэмэлт судалгаа шаардлагатай тухай тайлан

Паспортын гаж илэрц: Холбогдох олон улсын стандартад тодорхойлсны дагуу паспортын гаж илэрц хэмээн тогтоосон тухай тайлан

САШ: Спортын арбитрын шүүх

Дүрэм: Дэлхийн Допингийн эсрэг дүрэм

Тэмцээн: Аливаа уралдаан, тэмцээн, багийн болон түүнчлэн тамирчны ганцаарчилсан тэмцээн. Тухайлбал, сагсан бөмбөгийн тэмцээн, олимпийн хөнгөн атлетикийн гүйлтийн 100 метрийн зайн шигшээ тэмцээн, гэх мэт. Шагнал нь ердийн болон бусад түр хугацааны үндсэн дээр олгогддог урьдчилсан уралдаан болон хөнгөн атлетикийн уралдаан болон тэмцээнүүдийн хоорондын зөрүүг Олон улсын холбооноос баталсан журмаар зохицуулна.

Допингийн эсрэг журмын зөрчлөөс учрах үр дагавар (үр дагавар): Тамирчин болон бусад этгээд Допингийн эсрэг журам зөрчсөн тохиолдолд дараахь нөхцөл байдлууд үүснэ: (a) Тооцохгүй байх гэдэг нь тамирчны хүртсэн медаль, авсан оноо болон шагналыг хураах зэргээр тухайн тамирчны оролцсон аливаа уралдаан болон тэмцээний үр дүнг үгүйсгэхийг, (b) Эрхийн хасалт гэдэг нь тухайн тамирчныг 10.12.1 дэх хэсэгт заасанчлан допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотойгоор аливаа уралдаан, тэмцээн, үйл ажиллагаанд оролцох эрхийг нь тодорхой хугацаанд хасахыг, (c) Түр зуурын түдгэлзүүлэлт гэдэг нь 8 дугаар зүйлд заасны дагуу хянан хэлэлцэх ажиллагааны үеэр эцсийн шийдвэр гарахаас өмнө тамирчныг аливаа уралдаан, тэмцээн, үйл ажиллагаанд оролцох эрхийг нь түр түдгэлзүүлэхийг (d) Санхүүгийн үр дагавар гэж допингийн эсрэг дүрмийн зөрчил эсвэл зардал эргэн төлүүлэхтэй холбоотой оноосон санхүүгийн шийтгэлийг (e) олон нийтэд мэдээлэх, олон нийтэд тайлагнах гэж 14 дүгээр бүлэгт зааснаар олон нийтэд мэдээлэх эсвэл тухайн этгээдийг харьяалах хуулийн этгээдэд мэдэгдэхийг тус тус ойлгоно. Багийн спортод оролцогч багт 11 дүгээр бүлэгт заасан үр дагавар учирч болно.

Үл мэдэгдэх бүтээгдэхүүн: Хориотой бодис агуулж байгаа боловч түүнийгээ шошгон дээрээ бичээгүй эсвэл интернэт хайлтаар зохистой мэдээлэл нь олдохгүй байгаа бүтээгдэхүүн

Тооцохгүй байх: Допингийн эсрэг журмын зөрчлөөс үүдэн үр дагавар учруулах гэсэн хэсгийг харах

Допингийн хяналт: Шинжилгээ авах ажлыг төлөвлөх, дээж авах болон зохицуулах, лабораторийн шинжилгээ, зохицуулалтын журам, хянан хэлэлцэх ажиллагаа явуулах болон давж заалдах зэрэг процесс энд хамаарна.

Арга хэмжээ: Эрх бүхий байгууллагаас зохион байгуулж буй цуврал тэмцээн (Олимпийн наадам, Олон улсын усан спортын холбооны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Пан Америкийн наадам гэх мэт)

Арга хэмжээний байр: Тухайн арга хэмжээний голлон зохион байгуулагчдын сонгосон байр

Арга хэмжээний хугацаа: Тэмцээн зохион байгуулагчдаас тогтоосон тэмцээн эхлэхээс дуусах хоорон дахь хугацаа

Алдаа: Алдаа гэж хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эсвэл тухайн нөхцөл байдлыг дутуу үнэлсэнээс үүсэх дутагцлыг хэлнэ.Тамирчин болон бусад этгээдийн алдааны зэргийг батлах хүчин зүйл гэдэгт тухайлбал тухайн тамирчин бусад этгээд нь насанд хүрээгүй байх тохиолдолд тэдний туршлага, хөгжлийн бэрхшээл зэрэг тусгай нөхцөл,тамирчны ухамсарлаж буй эрсдлийн түвшин болон эрсдлийн түвшинг ойлгож буйтай холбоотойгоор мөрдөн шалгалтанд оруулсан тамирчны нөлөөний түвшин зэргийг ойлгоно.Тамирчин болон бусад этгээдийн алдааны зэргийг батлахад онцлох болон холбогдох тайлбарууд нь тамирчин болон бусад этгээдийн үйл явцын стандартаас гажиж буй шалтгааныг үнэлэх ёстой.Тухайлбал:Тамирчин эрх хасуулах хугацаанд их хэмжээний мөнгө олох боломжоо алдах тухай баримт эсвэл тамирчин богино хугацаа л алдах тухай баримт, эсвэл тэмцээний хуваарийн цаг хугацаа нь 10.5.1, 10.5.2-т заасны дагуу эрх хасах хугацааг бууруулахад нөлөөлөх хүчин зүйл болохгүй тухай зэрэг болно.

Тайлбар: Алдааг хянан үзэх үед тамирчны алдааны зэргийг батлах шалгуур нь бүх бүлэгт зааснаар ижил байна.Гэвч 10.5.2-ийн хүрээнд алдааны зэрэг батлагдсан, тамирчин болон бусад этгээд нь буруугүй болон хайнга байдлаасаа болж хамрагдсанаас бусад тохиолдолд шийтгэлийг бууруулахгүй.

Санхүүгийн үр дагавар: Дээр дурдсан допингийн эсрэг дүрмийн зөрчлөөс үр дагаварыг үз

Тэмцээний үеийн: Олон улсын холбоо болон наадмын ерөнхий зохион байгуулагчдаас баталсан журмуудад өөрөөр заагаагүй бол тэмцээний үеийн шинжилгээ гэдэг нь тухайн тамирчны оролцох хуваарьтай тэмцээн эхлэхээс арван хоёр цагийн өмнөөс уг тэмцээн дуусах хүртэл тухайн тэмцээнд хамааралтай дээж цуглуулах

Тайлбар: Олон улсын болон наадмыг зохион байгуулагчид тэмцээний үеийн хугацааг наадмын хугацаанаас өөрөөр шийдвэрлэж болно.

Хараат бус ажиглалтын хөтөлбөр: Ажиглалтын тайлан болон тодорхой спортын уралдаан тэмцээний үеэр Допингийн хяналтыг ДДЭА-ын хяналтан дор хэрэгжүүлэх үүрэгтэй багийн гишүүд. Хэрэв ДДЭА өөрөө тэмцээний үеийн шинжилгээг хийсэн тохиолдолд ажиглагчдын үйл ажиллагааг өөр бусад хараат бус байгууллага хянана.

Ганцаарчилсан спорт: Багийн спортод хамаарахгүй бүх спорт

Эрхийн хасах: Допингийн эсрэг журмын зөрчлөөс үүдэн үр дагавар учруулах гэсэн хэсгийг дээрээс харна уу.

Олон улсын үйл ажиллагаа: Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын холбоо, Томоохон арга хэмжээ зохион явуулдаг байгууллагууд болон бусад олон улсын спортын байгууллагуудаас зохион байгуулж буй үйл ажиллагаа эсвэл тэмцээнд ажиллах техникийн ажилтнуудыг томилох

Олон улсын зэрэглэлийн тамирчин: Олон улсын холбоодоос тодорхойлогдсон шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартад нийцсэн олон улсын тэмцээнд оролцогч тамирчин

Тайлбар: Олон улсын холбоо нь шинжилгээ, мөрдөн шалгалтын стандартад нийцүүлэн тухайн тамирчныг олон улсын зэрэглэлийнх гэдгийг тогтоох шалгуурыг саадгүй баталж өгнө. **Тухайлбал:** чансаа, олон улсын тэмцээнд оролцсон байдал, лицензийн хэлбэр... гэх мэт. Харин энэ шалгуурыг маш ойлгомжтой, тодорхой байдлаар хэвлэн нийтлэх ба тамирчин олон улсын ангилалд орох үедээ уг шалгуурыг хурдан, хялбар байдлаар ашиглах боломжтой байна. **Тухайлбал** уг шалгуурт олон улсын тэмцээний оролцоог оруулсан байвал олон улсын холбоо нь тэдгээр олон улсын тэмцээний жагсаалтыг гаргасан байх шаардлагатай.

Олон улсын стандарт: Дүрэмд дэмжлэг үзүүлэх зорилгоор ДДЭА-аас баталсан стандарт. Олон улсын стандартад (бусад стандарт, практик болон журамд харшилсан байх) нийцүүлсэн журмууд нь зүй зохистойгоор мөрдөгдөж байхаар байгууллагуудын үйл ажиллагаа нь Олон улсын стандартад нийцсэн байна. Олон улсын стандарт нь түүнийг мөрдөхөд шаардлагатай бичиг баримтыг агуулна.

Том наадам зохион байгуулагч: Энэхүү нэр томъёо нь тивийн Үндэсний олимпийн хорооны холбоод болон олон улсын, бүс нутгийн болон тивийн чанартай тэмцээн уралдааныг зохион байгуулах чиг үүрэг бүхий олон улсын олон спортын байгууллагуудад хамаарна.

Шинж: Нийлмэл, нийлмэлийн олонлог буюу эсвэл Хориглосон бодис болон хориглосон аргыг илрүүлэхэд хэрэглэгдэх биологийн өгөгдөл.

Дүрс хувирал: Биотрансформацийн ажиллагааны үр дүнд гарсан аливаа бодис

Насанд хүрээгүй этгээд: Арван наймаас доош насны этгээд

Үндэсний Допингийн эсрэг байгууллага: Үндэсний хэмжээнд Допингийн эсрэг журам батлах, хэрэгжилтийг нь хангах, дээж авах, шинжилгээний үр дүнгийн зохицуулалт хийх, хянан хэлэлцэх ажиллагаа явуулах бүрэн эрх олгогдож, үүрэг хүлээсэн этгээд. Хэрэв энэхүү бүрэн эрхийг олон нийтийн эрх бүхий байгууллагаас олгоогүй тохиолдолд дээрхи үүргийг тухайн улсын Үндэсний олимпийн хороо болон түүнээс эрх олгосон байгууллага хийж гүйцэтгэнэ.

Үндэсний үйл ажиллагаа: Олон улсын болон үндэсний тамирчдыг оролцуулсан Олон улсын бус спортын тэмцээн,наадам.

Үндэсний зэрэглэлийн тамирчин: Үндэсний допингийн эсрэг байгууллагаас тодорхойлсон, шинжилгээ мөрдөн шалгалтын станлартад нийцсэн үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаа тэмцээнд оролцогч тамирчин

Үндэсний олимпийн хороо: Олон улсын олимпийн хорооноос хүлэн зөвшөөрөгдсөн байгууллага. Үндэсний олимпийн хороо гэдэг нэр томъёонд мөн үндэсний спортын конфедераци нь Допингийн эсрэг салбарт Үндэсний олимпийн хорооны үүргийг хэрэгжүүлдэг орнуудын үндэсний Спортын конфедерацийг багтаана.

Гэм буруу болон хайхрамжгүй байдал гаргаагүй байх: Тамирчин болон бусад этгээд тухайн бодисыг хэрэглэсэн, эсвэл Хориглсон бодис болон Хориглосон аргыг хэрэглэсэн эсвэл бусад допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэдгээ мэдээгүй буюу сэжиг аваагүй байх буюу хамгийн наад захын анхааруулга байсан ч гэсэн ямар нэгэн байдлаар тэдгээрийг мэдэх буюу гадарлах боломжгүй байсан гэдгээ нотлох. 2.1 зүйл заасан зөрчлийг насанд хүрээгүй этгээд гаргасанаас бусад аливаа тохиолдолд тамирчин хориотой бодис хэрхэн түүний биед орсон талаар тайлбарлах шаардлагатай.

Гэм буруу болон хайхрамжгүй байдал нь ач холбогдолгүй байх: Тамирчин болон бусад этгээдийн гэм буруу болон хайхрамжгүй байдлыг тухайн үеийн нөхцөл байдлыг бүрэн шинжлэх болон гэм буруу болон хайхрамжгүй байдал нь ач холбогдолгүй байх шалгуураар авч үзэхэд тэдгээр нь Допингийн эсрэг журмын зөрчилд ач холбогдолгүй байхыг тамирчин нотлох. 2.1 зүйл заасан зөрчлийг насанд хүрээгүй этгээд гаргасанаас бусад аливаа тохиолдолд тамирчин хориотой бодис хэрхэн түүний биед орсон талаар тайлбарлах шаардлагатай.

Тайлбар: Каннабиноидын хувьд тамирчин спортын чадвараа ахиулах зорилгоор хэрэглээгүй гэдгээ тодорхой харуулж, гэм буруу болон хайхрамжгүй байдал нь ач холбогдолгүй гэдгийг нотолж болно

Тэмцээний бус үеийн: Тэмцээний үед хамраагдахгүй хугацаа

Оролцогч: Тамирчин болон тамирчныг дэмжигч аливаа этгээд:

Этгээд: Хувь этгээд, эсвэл байгууллага болон бусад этгээд.

Эзэмшил: Жинхэнэ бөгөөд бодит эзэмшил, эсвэл үр дүнтэй эзэмшил (Хэрэв тухайн этгээд Хориглосон бодис болон хориглосон арга, түүнчлэн хориглосон бодис болон хориглосон аргын угтвар нөхцөлд онцгой хяналт тавих эсвэл хяналт тавихаар төлөвлөх туйлын эрхтэй бол) гэсэн хэдий ч тухайн этгээд хориглосон бодис болон хориглосон арга, түүнчлэн хориглосон бодис/хориглосон аргын угтвар нөхцөлд хяналт тавих туйлын эрхгүй нөхцөлд, хэрэв тухайн этгээд хориглосон бодис ба хориглосон аргын талаар мэдээж байсан бөгөөд тэдгээрийг хянахаар зэхэж байсан бол үр дүнтэй эзэмшлийн асуудал энд хамаарна. Тухайн этгээд Допингийн эсрэг журам зөрчсөн тухай ямар нэгэн мэдэгдэл авах, тухайн этгээд ямар нэгэн зүйлийг эзэмших санаанаасаа больсныгоо тодорхой үйлдлээр харуулсан буюу эсвэл эзэмшилтэй холбоотой өөрийн өмнөх асуудлыг мэдэгдсэн зэргээс өмнөх тохиолдлуудад тус тус эзэмшилтэй холбоотой ямар нэгэн Допингийн эсрэг зөрчлийн асуудал яригдахгүй. Хориотой бодисыг худалдан авах ажиллагаа нь эзэмшил болохыг дангаар нотлох гэдэгт тухайлбал уг бүтээгдэхүүн нь ирээгүй байх, өөр хүн хүлээж авсан байх эсвэл гуравдагч этгээд үрүү илгээсэн байх зэрэг тохиолдлыг ойлгоно.

Тайлбар: Энэхүү тодорхойлолтын дагуу тамирчны машинаас нь бодис илэрсэн бөгөөд түүний машин нь бусдын эзэмшилд байсан гэдгийг нотолсон тохиолдолд тамирчныг Допингийн эсрэг зөрчлөөс чөлөөлөх бөгөөд хэдийгээр уг машин тамирчны бүрэн хяналтан дор байгаагүй ч гэсэн тамирчин бодисын талаар мэдсэн хийгээд түүнийг бүрэн хяналтандаа оруулахыг зорьсон гэдгийг Допингийн эсрэг байгууллага нь нотлох ёстой. Үүнтэй нэгэн адилаар, хэрэв бодис тухайн тамирчны гэрийн эмийн сангаас олдсон буюу тэр нь тамирчин болон түүний ханийн хамтын хяналт дор байсан тохиолдолд тухайн бодисыг эмийн санд нь байгаа гэдгийг тамирчин мэдэж байсан бөгөөд түүнийг хяналтан дороо авахыг зорьж байсан гэдгийг мөн Допингийн эсрэг байгууллага тогтооно.

Хориглосон жагсаалт: Хориглосон бодис болон хориглосон аргыг тус тус тодорхойлсон жагсаалт.

Хориглосон арга: Хориглосон жагсаалтаар тодорхойлсон арга

Хориглосон бодис: Хориглосон жагсаалтаар тодорхойлсон аливаа бодис эсвэл бодисын ангилал

Түр зуурын хянан хэлэлцэх ажиллагаа: 7.9 дэхь хэсгийн зорилгын хүрээнд, 8 дугаар зүйлд заасан хянан хэлэлцэх ажиллагаанаас өмнө хялбаршуулсан аргаар хийгдэж буй ажиллагаа бөгөөд энд Тамирчинд мэдэгдэл хүргүүлэх, ажиллагаанд аман буюу бичгэн хэлбэрээр оролцох боломж олгох зэрэг асуудал багтана.

Тайлбар: Түр зуурын хянан хэлэлцэх ажиллагаа гэдэг нь зөвхөн тухайн тохиодлын дэлгэрэнгүй баримтыг хянан үзэхэд хамаарагдахгүй урьдчилсан хяналтыг хэлнэ. Дараахи түр зуурын хянан хэлэлцэх ажиллагааны үед тамирчин бүрэн хянан хэлэлцүүлэх давуу талаа хадгална.

Хялбаршуулсан ажиллагаа нь 7.9-д тодорхойлсонтой зөрвөл дэлгэрэнгүй хянан хэлэлцэх ажиллагаа нь цаг хугацааны хялбаршуулсан хуваарьт үндэслэн хийнэ.

Түр зуурын түдгэлзүүлэлт: Допингийн эсрэг дүрмийн зөрчлийн үр дагаварын хэсгийг харах.

Нийтэд мэдээлэх буюу нийтэд тайлагнах: Допингийн эсрэг дүрмийн зөрчлөөс үүсэх үр дагаварыг үз

Бүсийн допингийн эсрэг байгууллага: Гишүүн орнуудын допингийн эсрэг дүрмийг батлах, хэрэгжүүлэх, төлөвлөх, дээж цуглуулах, үр дүнг удирдах, эмчилгээний зорилгоор чөлөөлөх асуудлыг хянан үзэх, хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг зохион байгуулах зэрэг асуудлыг багтаасан үндэсний допингийн эсрэг хөтөлбөрийг зохицуулах, удирдах, төлөвлөх болон бүсийн хэмжээнд допингийн эсрэг боловсролын хөтөлбөрийг зохион байгуулах зорилгоор байгуулсан бүсийн хэмжээний хуулийн этгээд

Шинжилгээний бүртгэлийн сан: Олон улсын холбооноос байгуулсан олон улсын түвшинд өрсөлдөх өндөр зэрэглэлийн тамирчдын болон үндэсний допингийн эсрэг байгууллагаас байгуулсан олон улсын болон үндэсний допингийн эсрэг байгууллагын

шинжилгээ авах төлөвлөгөөний нэг хэсэг болох хувьд үндэсний хэмжээнд тэмцээний болон тэмцээний бус үеийн шинжилгээ өгөх тамирчдын бүртгэлийн сан.Энд бүртгэгдсэн тамирчдаас 5.6 зүйл болон Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартад зааснаар байршлын тухай мэдээлэл өгөхийг шаардана.

Дээж: Допингийн хяналтын зорилгоор авсан биологийн аливаа материал.

Тайлбар: Зарим тохиолдолд шашны болон соёлын бүлгүүдийн зарчмаас шалтгаалан цусны шинжилгээ авдаг. Энэ тохиолдолд үндэслэл тодорхойлох шаардлагагүй.

Гарын үсэг зурагч этгээд: 23 дугаар бүлэгт заасны дагуу дүрмийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан болон энэхүү дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлсэн хуулийн этгээд

Тусгайлсан бодис: 4.2.2 зүйлийг үз

Хатуу хариуцлага: Допингийн эсрэг дүрмийн зөрчилтэй холбоотойгоор допингийн эсрэг байгууллагаас баталсан 2.1, 2.2 дүрмийн зөрчил нь санаатай, алдаанаас болсон буруугүй эсвэл хайхрамжгүй байдалтай холбоотой гарсан болон тамирчин хэрэглэхээ мэдэж байх шаардлагагүй зэргийг нотолсон үед хэрэглэх журам

Бодит туслалцаа: 10.6.1-т заасны дагуу бодит туслалцаа үзүүлэгч этгээд нь дараахи мэдээллийг заавал өгнө. (1)Допингийн эсрэг зөрчилд хамаарах мэдээллийг эзэмшиж байгаа тухай бичгээр үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулсан бүрэн нотолгоо (2) Уг мэдээлэлтэй холбоотой мөрдөн шалгах болон шүүхийн бүх үйл ажиллагаанд хамтран ажиллах, Тухайлбал: хянан хэлэлцэх болон Допингийн эсрэг байгууллага хүссэн тохиолдолд шүүх хуралд гэрчээр оролцох,цаашид хэрэг үүссэнээс хойших түүний чухал хэсгийг агуулсан, нотолгоотой мэдээллийг өгнө. Хэрэв хэрэг үүсээгүй бол уг хэргийг ингэж үзэх болсон үндэслэлийг мэдээнэ.

Хөндлөнгөөс оролцох: Зүй бус зорилгоор, зүй бус замаар, зүй бус нөлөөлөл үзүүлэх буюу нэгэнт гарсан үр дүнг зүй бусаар өөрчлөх, эсвэл хэвийн ажиллагааны журмыг алдагдуулах үйл ажиллагаа.

Тусгайлсан шинжилгээ: Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандартад заасан шалгуураар шинжилгээ авахаар тамирчныг тусгайлан сонгох

Багийн спорт: Уралдаан тэмцээний үеэр нэг тамирчин нь нөгөө тамирчныхаа үүргийг орлон гүйцэтгэж болдог спорт.

Шинжилгээ: Шинжилгээ авалтыг төлөвлөх, дээд цуглуулах, дээж гардах болон тэдгээрийг лаборатори руу тээвэрлэх зэрэг Допингийн хяналтын ажиллагааны тодорхой хэсэг.

Түгээх: Шууд, эсвэл гуравдагч этгээдийн тусламжтайгаар тамирчдад хориглосон бодис ба хориглосон аргыг худалдах, өгөх, зохицуулах, тээвэрлэх, илгээх, хүргэж өгөх болон түгээн тараах (эсвэл аливаа зорилгоор эзэмших) үйлдлийг хэлэх бөгөөд чингэхдээ хуулийн дагуу эмчилгээний зориулалтаар хориглосон бодис зарах болон түгээхгүй байх (эмнэлгийн

ажилтах болон тамирчныг дэмжигч ажилтнаас өөр бусад этгээдийн оролцоотойгоор) үйл ажиллагаа. Хууль ёсны эмчилгээнд хэрэглэгдээгүй шалтгаан тодорсон болон спортын чадвараа ахиулахаар төлөвлөснөөс бусад тохиолдолд тэмцээний бус үед хэрэглэхийг хориглодоггүй бодисыг үүнд хамааруулахгүй.

Эмчилгээ зорилгоор чөлөөлөх: 4.4 зүйлд тодорхойлсон эмчилгээний зорилгоор чөлөөлөхийг үз

ЮНЕСКО конвенц: 2005 оны 10 дугаар сарын 19-ны өдөр ЮНЕСКО-гийн ерөнхий бага хурлын 33 дугаар хуралдаанаас баталсан улс орнуудын баталсан конвенцид оруулах аливаа болон бүх өөрчлөлт ба спорт дахь допингийн эсрэг конвенцид оруулах улс орнуудын санал бодлыг багтаасан спорт дахь допингийн эсрэг олон улсын конвенц

Хэрэглэх: Хориглосон бодис болон хориглосон аргыг ямар нэгэн замаар хэрэглэх, залгих, тариулах, эсвэл хангах бэлтгүүлэх үйл ажиллагаа.

ДДЭА: Дэлхийн Допингийн эсрэг байгууллага

Тайлбар: Тодорхойлолтод багтсан нэр томъёонууд нь тэдгээрийн олон тоо, хамаатуулах хэлбэр болон ярианы бусад хэлбэрт хэрэглэгдэнэ.

ХАВСРАЛТ 2

10 ДУГААР БҮЛГИЙГ ХЭРЭГЛЭХ ЖИШЭЭ

ЖИШЭЭ 1:

Тэмцээний үед өгсөн шинжилгээнд анаболик стероид хэрэглэсний улмаас сөрөг аналитик илэрц гарсан, Тамирчин допингийн эсрэг дүрэм зөрчсөнөө даруй хүлээн зөвшөөрсөн, Тамирчин буруугүй болон хайхрамжгүй байдлаас болсноо нотолсон бөгөөд бодит туслалцаа үзүүлсэн.

Үр дагаварыг тооцох:

1. Эхлээд 10.2 зүйлийг үндэслэнэ. Учир нь тамирчин гэм буруугүй болон хайхрамжгүй байдлаас болсон гэдгээ баталж(10.2.1.1, 10.2.3) байгаа нь уг допингийн эсрэг дүрмийн зөрчил нь санаатай бус гэдгийг нотолж буй тул эрх хасах хугацаа нь дөрөв биш хоёр жил (10.2.2) байна.
2. Хоёрдугаар шатанд хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн алдаатай холбоотойгоор хөнгөрүүлэх үндэслэлийг хэрэглэж болох эсэхэд дүгнэлт хийнэ. Анаболик стероид нь тусгайлсан бодис биш тул буруугүй болон хайхрамжгүй байдал үндэслэлийг хэрэглэх хүрээнд шийтгэлийг хоёр жилээс нэг жил хүртэл (хамгийн багадаа хоёр жилийн шийтгэлийн хоёрны нэг) бууруулж болно. Хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн нь эрх хасах хугацааг тамирчны алдааны зэрэгт үндэслэж болох эсэхийг тогтооно. (Энэхүү жишээд дурдсан тайлбарыг дүгнэж хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн бусад тохиолдолд 16 сараар эрх хасах шийтгэл оноож болно.)
3. Гуравдугаарт, хэрэг хянан хэлэлцэх баг 10.6-д (алдаатай холбоогүйгээр хөнгөрүүлэх) зааснаар түтгэлзүүлэх буюу хөнгөрүүлэх боломж байгаа эсэхийг үнэлнэ. Энэ тохиолдолд зөвхөн 10.6.1(бодит туслалцаа)-ийг хэрэглэнэ.(Даруй зөвшөөрөх гэсэн 10.6.3 зүйлийг хэрэглэгдэхгүй. Учир нь эрх хасах шийтгэлийн хугацаа 10.6.3-т зааснаар хамгийн бага 2 жилээр оноогдсон.) Бодит туслалцаанд үндэслэн 16 сарын эрх хасах хугацааны дөрөвний гурвыг түтгэлзүүлж болно.* Ингэсэнээр хамгийн бага эрх хасах хугацаа нь 4 сар болно. (жишээнд дурдсан тайлбарыг үндэслэн хэрэг хянан хэлэлцэх баг 10 сарыг түтгэлзүүлж 6 сараар эрх хасах шийтгэл оноож болно.)
4. 10.11-т зааснаар эрх хасах хугацаа нь хэрэг хянан хэлэлцэх сүүлийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцогдоно. Харин тамирчин буруугаа даруй хүлээн зөвшөөрсөн тул энэ хугацаа нь аль болох эрт буюу дээж өгсөн өдрөөс тоологдоно. Гэвч аль ч тохиолдолд тамирчин хэрэг хянан хэлэлцэх эцсийн шийдвэр гарсан өдрөөс хойш хамгийн багадаа нийт хугацааны хоёрны нэгийг (3 сар) эдлэх ёстой.
5. Сөрөг аналитик илэрц тэмцээний үед илэрсэн тул хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн уг тэмцээнд үзүүлсэн үр дүнг автоматаар хүчингүйд тооцно.(9 дүгээр бүлэг)

6. Бусад шударга байдлыг хангахаас бусад тохиолдолд 10.8-д заасны дагуу дээж өгсөн өдрөөс эрх хасах хугацаа эхлэх өдөр хүртэл тамирчны үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцно.
7. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-т заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.
8. Тамирчныг эрх хасуулсан байх үедээ гарын үсэг зурагчид болон түүний гишүүдийн зохион байгуулсан ямар ч зэрэглэлийн тэмцээнд болон спортын бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно.(10.12.1) Харин тамирчин дараах тохиолдуудаас богино хугацаагаар багийнхаа бэлтгэлд эргэн орох, клуб, гарын үсэг зурагчид болон гишүүн байгууллагуудын байгууламжийг хэрэглэж болно. а) Эрх хасуулсан хугацааны сүүлийн хоёр сар, эсвэл б) Эрх хасуулсан хугацааны сүүлийн нэг улирал (10.12.2). Тамирчныг эрх хасах хугацаа дуусахаас 1 сар хагасын өмнөөс бэлтгэлдээ орохыг зөвшөөрнө.

ЖИШЭЭ 2:

Баримт: Тусгайлсан бодист багтдаг стимулянт хэрэглэснээс тэмцээний үеийн шинжилгээнд сөрөг аналитик илэрц гарсан,(2.1 зүйл) Допингийн эсрэг байгууллага тамирчныг допингийн эсрэг дүрмийг санаатай зөрчсөн гэдгийг нотлох боломжтой, Тамирчин уг хориглсон бодисыг спортын чадвартай холбоогүйгээр тэмцээний бус үед хэрэглэсэн гэдгээ нотлох боломжгүй,Тамирчин нотолгоо гаргахын тулд допингийн эсрэг дүрэм зөрчсөнөө даруй хүлээн зөвшөөрөөгүй татгалзсан,бодит туслалцаа үзүүлсэн..

Үр дагаварыг тооцох:

1. Эхлээд 10.2 зүйлийг үндэслэнэ.Учир нь Допингийн эсрэг байгууллага тамирчныг допингийн эсрэг дүрмийг санаатай зөрчсөн гэдгийг нотлох боломжтой бөгөөд тамирчин уг хориглсон бодисыг спортын чадвартай холбоогүйгээр тэмцээний бус үед хэрэглэсэн гэдгээ нотлох боломжгүй. (10.2.3 зүйл) Эрх хасах шийтгэлийн хугацаа нь дөрвөн жил байна. (10.2.1.2 зүйл)
2. Дүрмийг санаатай зөрчсөн тул алдааг (10.4, 10.5-ийг хэрэглэхгүй)үндэслэн шийтгэлийг хөнгөрүүлэхгүй.Бодит тусламжийг үндэслэн жилийн шийтгэлийн дөрөвний гурвыг түтгэлзүүлж болно.* Эрх хасах хугацаа нь хамгийн багадаа нэг жил болно.
3. Зарчмын хувьд 10.11-т зааснаар эрх хасах хугацаа нь хэрэг хянан хэлэлцэх сүүлийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцогдоно.
4. Сөрөг аналитик илэрц тэмцээний үед илэрсэн тул хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн уг тэмцээнд үзүүлсэн үр дүнг автоматаар хүчингүйд тооцно.(9 дүгээр бүлэг)
5. Бусад хэлбэрээр шударга байдлыг хангахаас бусад тохиолдолд 10.8-д заасны дагуу дээж өгсөн өдрөөс эрх хасах хугацаа эхлэх өдөр хүртэл тамирчны үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцно.
6. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-т заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.

7. Тамирчныг эрх хасуулсан байх үедээ гарын үсэг зурагчид болон түүний гишүүдийн зохион байгуулсан ямар ч зэрэглэлийн тэмцээнд болон спортын бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно.(10.12.1) Харин тамирчин дараах тохиодлуудаас богино хугацаагаар багийнхаа бэлтгэлд эргэн орох, клуб, гарын үсэг зурагчид болон гишүүн байгууллагуудын байгууламжийг хэрэглэж болно. а) Эрх хасуулсан хугацааны сүүлийн хоёр сар, эсвэл б) Эрх хасуулсан хугацааны сүүлийн нэг улирал (10.12.2). Тамирчныг эрх хасах хугацаа дуусахаас 1 сар хагасын өмнөөс бэлтгэлдээ орохыг зөвшөөрнө.

ЖИШЭЭ 3:

Баримт: Анаболик стероид хэрэглэсэнээс тэмцээний бус үед сөрөг аналитик илэрц гарсан,(2.1 зүйл) Тамирчин буруугүй болон хайхрамжгүй байдлаас болсныг болон бохирдсон бодисоос шалтаалж дүрэм зөрчсөн гэдгээ нотолж чадсан.

Үр дагаварыг тооцох:

1. Эхлээд 10.2 зүйлийг үндэслэнэ.Учир нь тамирчин допингийн эсрэг дүрмийг санаатайгаар зөрчөөгүй гэдгийг нотлосон. Бохирдсон бодис хэрэглэсэнээс шалтгаалсан алдаа гарсан.(10.2.1.1, 10.2.3) Эрх хасах шийтгэлийн хугацаа нь хоёр жил байна. (10.2.2 зүйл)
2. Хоёрдугаар шатанд хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн алдаатай холбоотойгоор хөнгөрүүлэх үндэслэлийг хэрэглэж болох эсэхэд дүгнэлт хийнэ.Тамирчин бохирдсон бодисоос шалтгаалан допингийн эсрэг дүрэм зөрчсөн болон буруугүй, хайхрамжгүй байдлаас болсон гэдгээ нотолсон тул эрх хасах шийтгэлийн хугацааг хоёр жилээс сануулга өгөх хүртэл хүрээгээр хөнгөлж болно. Хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн алдааны зэргийг үндэслэн энэ хүрээнд эрх хасах шийтгэлийн хугацааг тогтооно. (Энэхүү жишээд дурдсан тайлбарыг дүгнэж хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн бусад тохиолдолд дөрвөн сараар эрх хасах шийтгэл онооно.)
3. Бусад хэлбэрээр шударга байдлыг хангахаас бусад тохиолдолд 10.8-д заасны дагуу дээж өгсөн өдрөөс эрх хасах хугацаа эхлэх өдөр хүртэл тамирчны үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцно.
4. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-т заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.
5. Тамирчныг эрх хасуулсан байх үедээ гарын үсэг зурагчид болон түүний гишүүдийн зохион байгуулсан ямар ч зэрэглэлийн тэмцээнд болон спортын бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно.(10.12.1) Харин тамирчин дараах тохиодлуудаас богино хугацаагаар багийнхаа бэлтгэлд эргэн орох, клуб, гарын үсэг зурагчид болон гишүүн байгууллагуудын байгууламжийг хэрэглэж болно. а) Эрх хасуулсан хугацааны сүүлийн хоёр сар, эсвэл б) Эрх хасуулсан хугацааны сүүлийн нэг улирал (10.12.2). Тамирчныг эрх хасах хугацаа дуусахаас 1 сар хагасын өмнөөс бэлтгэлдээ орохыг зөвшөөрнө.

ЖИШЭЭ 4:

Баримт: Тамирчинд сөрөг аналитик илэрц гарч байсан болон допингийн эсрэг дүрэм зөрчиж байсан тохиолдол байхгүй. Тэр спортын чадвараа ахиулах зорилгоор анаболик стероид хэрэглэдэг байсан гэдгээ сайн дураар хүлээн зөвшөөрсөн бөгөөд бодит туслалцаа үзүүлсэн.

Үр дагаварыг тооцох:

1. Дүрмийг санаатай зөрчиж байсан 10.2.1-ийг хэрэглэх боломжтой, эрх хасах шийтгэлийн үндсэн хугацаа нь дөрвөн жил байна.

2. Алдаанаас хамаарч эрх хасах хугацааг хөнгөрүүлэх үндэслэл байхгүй. (10.4, 10.5-ийг хэрэглэхгүй.)

3. Тамирчин өөрөө сайн дураар хүлээн зөвшөөрсөн дээр үндэслэн эрх хасах хугацааг дөрвөн жилийн хоёрны нэг хүртлэх хугацаагаар бууруулж болно. Тамирчны үзүүлсэн бодит тусламжинд (10.6.1) үндэслэн дөрвөн жилийн дөрөвний гурав хүртлэх хэмжээгээр эрх хасах хугацааг түтгэлзүүлж болно*. 10.6.4 заалтын дагуу сайн дураар хүлээн зөвшөөрсөн болон бодит туслалцаа үзүүлсэн асуудлыг хамтад нь үндэс болговол ихэнхи шийтгэлийг дөрвөн жилийн дөрөвний гурав хүртэл хэмжээгээр хөнгөлж, түтгэлзүүлж болно. Эрх хасах хугацаа нь хамгийн багадаа нэг жил байна.

4. Зарчмын хувьд 10.11-т зааснаар эрх хасах хугацаа нь хэрэг хянан хэлэлцэх сүүлийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцогдоно. Сайн дураар хүлээн зөвшөөрсөн нь эрх хасах хугацааг бууруулах хүчин зүйл болсон бол 10.11.2-ийн дагуу эрх хасах хугацааг эрт тооцож эхлэхийг зөвшөөрөхгүй. Энэ заалт нь тамирчныг ижил шалтгаанаар хоёр дахин хөнгөлөлт авахаас сэргийлнэ. Харин бодит туслалцаа үзүүлсэн асуудлыг дангаар нь үндэс болговол 10.11.2-ийг хэрэглэж болох ба эрх хасах хугацааг аль болох эрт буюу тамирчны анаболик стероидыг хамгийн сүүлд хэрэглэсэн өдрөөс эхлэн тоолно.

5. Бусад хэлбэрээр шударга байдлыг хангахаас бусад тохиолдолд 10.8-д заасны дагуу дээж өгсөн өдрөөс эрх хасах хугацаа эхлэх өдөр хүртэл тамирчны үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцно.

6. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-т заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.

7. Тамирчныг эрх хасуулсан байх үедээ гарын үсэг зурагчид болон түүний гишүүдийн зохион байгуулсан ямар ч зэрэглэлийн тэмцээнд болон спортын бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно. (10.12.1) Харин тамирчин дараах тохиолдуудаас богино хугацаагаар багийнхаа бэлтгэлд эргэн орох, клуб, гарын үсэг зурагчид болон гишүүн байгууллагуудын байгууламжийг хэрэглэж болно. а) Эрх хасуулсан хугацааны сүүлийн хоёр сар, эсвэл б) Эрх хасуулсан хугацааны сүүлийн нэг улирал (10.12.2). Тамирчныг эрх хасах хугацаа дуусахаас 1 сар хагасын өмнөөс бэлтгэлдээ орохыг зөвшөөрнө.

ЖИШЭЭ 5:

Баримт: Тамирчныг дэмжигч этгээд тамирчнаа хуурамч нэрээр тэмцээнд оруулснаар эрх хасах хугацааг завшихад туслалцаа үзүүлсэн. Тамирчныг дэмжигч этгээд уг зөрчлийг допингийн эсрэг байгууллагаас допингийн эсрэг дүрэм зөрчсөн тухай мэдэгдэл хүлээн авахаас өмнө сайн дураар хүлээн зөвшөөрсөн

Үр дагаварыг тооцох:

1. 10.3.4-ийн дагуу зөрчлийн ноцтой байдлаас шалтгаалан эрх хасах хугацаа нь хоёроос дөрвөн жил байдаг. (Энэхүү жишээд дурдсан тайлбарыг дүгнэж, хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн бусад тохиолдолд 3 жилээр эрх хасах шийтгэл оноож болно.)
2. Санаатай байдал нь 2.9-д заасан допингийн эсрэг зөрчлийн нэг элемент нь болж байгаа тохиолдолд алдааны зэргээс хамаарч шийтгэлийг хөнгөрүүлэхгүй.
3. 10.6.2-т зааснаар хүлээн зөвшөөрөх нь цорын ганц найдвартай нотолгоо бол эрх хасах хугацааг хоёрны нэг хүртэл хэмжээгээр хасаж болно. (Энэхүү жишээд дурдсан тайлбарыг дүгнэж, хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн бусад тохиолдолд 18 сараар эрх хасах шийтгэл оноож болно.)
4. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-т заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.

ЖИШЭЭ 6:

Баримт: Тамирчин допингийн эсрэг дүрмийг анх удаа зөрчсөнөөр 14 сарын хугацаагаар эрхээ хасуулсан ч бодит туслалцаа үзүүлсэн шалтгаанаар дөрвөн сарын хугацааг түтгэлзүүлсэн. Тэмцээний үеийн шинжилгээнд тусгай бодист үл хамаарах стимулянт илэрч (2.1) хоёр дахь удаагаа допингийн эсрэг дүрмийн зөрчил гаргасан. Тамирчин буруугүй болон хайнга байдлаас шалтгаалсан гэдгийг нотолсон бөгөөд бодит туслалцаа үзүүлсэн. Энэ нь анх удаагийн зөрчил байсан бол хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн 16 сараар эрх хасах ба бодит туслалцаа үзүүлсний төлөө 6 сарын хугацааг түтгэлзүүлэх байсан

Үр дагаварыг тооцох:

1. 10.7.4.1, 10.7.5 заалтыг хэрэглэх тул 10.7 зүйлийг хоёр дахь зөрчилд хэрэглэнэ.
2. 10.7.1-ийн хүрээнд эрх хасах хугацаа нь дараахи тохиолдуудаас илүү байна:
 - a. Зургаан сар
 - b. 10.6 –д заасны дагуу шийтгэлийг хөнгөрүүлэх арга хэмжээ авалгүйгээр анх удаагийн зөрчилд оноосон эрх хасах шийтгэлийн хугацааны хоёрны нэгтэй тэнцүү

хугацаа (энэ жишээний хувьд 14 сарын хугацааны хоёрны нэгтэй тэнцүү буюу 7 сар)

с. 10.6 д зааснаар шийтгэлийг хөнгөрүүлэх арга хэмжээ авалгүйгээр эхний зөрчилд оноосон шийтгэлийн хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хугацаа (Энэ жишээний хувьд 16 сарын хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү буюу 32 сарын хугацаа)

3. Дараа нь хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн 10.6 (алдаатай холбоогүй хөнгөрүүлэх)-ийн дагуу шийтгэлийг түтгэлзүүлэх, хөнгөрүүлэх боломж байгаа эсэхийг үнэлнэ. Хоёр дахь зөрчлийн тохиолдолд зөвхөн 10.6.1 (Бодит тусламж) заалтыг хэрэглэнэ. Бодит туслалцаанд үндэслэн эрх хасах 32 сарын хугацааны дөрөвний нэгтэй тэнцүү хугацааг түтгэлзүүлж болно.* Ингэсэнээр эрх хасах хугацаа нь хамгийн багадаа найман сар болно. (Энэ жишээнд дурдсан тайлбарыг үнэлж хэрэг хянан хэлэлцэх баг 8 сарыг түтгэлзүүлэх шийдвэр гаргаснаар эрх хасах хугацаа нь хоёр жил болно.)
4. Сөрөг аналитик илэрц тэмцээний үед илэрсэн тул хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн уг тэмцээнд үзүүлсэн үр дүнг автоматаар хүчингүйд тооцно.
5. Бусад шударга байдлыг хангахаас бусад тохиолдолд 10.8-д заасны дагуу дээж өгсөн өдрөөс эрх хасах хугацаа эхлэх өдөр хүртэл тамирчны үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцно.
6. Тамирчин насанд хүрээгүй байх болон энэ нь шийтгэлийн хүчин төгөлдөр хэсгийн нэг болохоос (10.13) бусад тохиолдолд 14.3.2-г заасны дагуу мэдээллийг олон нийтэд зарлана.
7. Тамирчныг эрх хасуулсан байх үедээ гарын үсэг зурагчид болон түүний гишүүдийн зохион байгуулсан ямар ч зэрэглэлийн тэмцээнд болон спортын бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно.(10.12.1) Харин тамирчин дараах тохиолдуудаас богино хугацаагаар багийнхаа бэлтгэлд эргэн орох, клуб, гарын үсэг зурагчид болон гишүүн байгууллагуудын байгууламжийг хэрэглэж болно. а) Эрх хасуулсан хугацааны сүүлийн хоёр сар, эсвэл б) Эрх хасуулсан хугацааны сүүлийн нэг улирал (10.12.2). Тамирчныг эрх хасах хугацаа дуусахаас 1 сар хагасын өмнөөс бэлтгэлдээ орохыг зөвшөөрнө.

* ДДЭА онцгой шалтгааны улмаас баталгаа олгосон тохиолдолд бодит туслалцаа үзүүлсэнд ногдох эрх хасах хугацааг түтгэлзүүлэх дээд хэмжээ нь дөрөвний гурваас их байж болох ба тайлагнах, хэвлэн нийтлэх ажлыг хойшлуулж болно.